



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ**

**ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР
ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ4

1.1. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үндэслэл, шаардлага.....4

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох6

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгох, шалгуур үзүүлэлтийг томъёолох7

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл.....7

1.3.2. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....7

1.4. Үнэлгээний арга зүй8

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ9

2.1. Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал..... 11

2.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ зорилгодоо хүрсэн эсэх..... 11

2.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангах тухай хуулийн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх17

2.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх27

2.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах тухай хуулийн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх35

2.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний зарим эрхийг хангах тухай хуулийн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх41

2.1.6. Хөгжлийн бэрхшээлийг тогтоох хуулийн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх ..47

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ49

Хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдрах орчин нөхцөлийг сайжруулах асуудал49

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангах тухайд50

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухайд51

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн асуудал52

ХБХ-ий зарим эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал53

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ60

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Аргачлал	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын их хурал
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүн
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХБХЭМБНХК	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс
ХБХЭТХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХСайд	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮХ	Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэс
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭТМҮ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

УДИРТГАЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын Конвенц”, “Эрхийг бодитой болгоё” Инчеоны стратегийн үзэл санаанд нийцүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүн (цаашид ХБХ гэх)-д Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэх боломжийг бодитой бүрдүүлэхийг эрмэлзэн, 2005 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, холбогдох бусад хууль, эрх зүйн актыг өөрчлөх, сайжруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хамгаалалтыг бодитой, хүртээмжтэй болгох, улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүн нь нийгмийн амьдралд бусдын адил оролцоотой байх боломжийг бүрдүүлэх суурийг хуулиар тогтоох үндсэн зорилготойгоор уг хуулийг 2016 онд УИХ-аас баталсан.

2016 онд батдагдсан уг хуульд 10 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байх ба эдгээр нь ихэвчлэн Боловсролын ерөнхий хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль зэрэг бусад хууль тогтоомжийн шинэчлэлтэй холбоотой нэр томъёо, бүтэц, удирдлага зохион байгуулалтын шинжтэй өөрчлөлтүүд байна. Хууль батлагдсанаас хойш ХБХ-ий эрх зүйн байдлыг дээрдүүлсэн 3 нэмэлт өөрчлөлт орсон нь 2023 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн насны хязгаарыг 16 наснаас 18 нас болгосон, 2016 онд ХБХ нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчихтой холбоотой заалтууд юм.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд хууль санаачлагч нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг эхлүүлэхдээ тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний үр дүнд үндэслэхээр тусгасан бол мөн хуулийн 51 дүгээр зүйлд “Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, багц хуулийн төсөл боловсруулахад түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлно” гээд тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх шаардлага тавьсан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (цаашид ХБХЭТХ гэх)-ийг 2016 онд баталсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт заасан үнэлгээ хийх хугацаа хэтэрсэн, уг хууль батлагдсанаас хойш батлагдсан НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030” болон “Алсын хараа-2050” зэрэг олон улсын болон дотоодын урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилго, зорилтод нийцүүлэх, техник, технологийн хөгжил дэвшил, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хөгжлийн бэрхшээлийг үнэлэх, тодорхойлох олон улсын арга, аргачлалыг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэв.

ХБХЭТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” (цаашид Аргачлал гэх)-ын дагуу 1/ Төлөвлөх; 2/ Хэрэгжүүлэх; 3/ Үнэлэх гэсэн үндсэн үе шаттайгаар гүйцэтгэв.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатанд хууль тогтоомжид үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох, үнэлгээ хийх хүрээг тогтоох, шалгуур үзүүлэлтийг сонгох, харьцуулах хэлбэрийг сонгох, шалгуур үзүүлэлтийг томъёолох, мэдээлэл цуглуулах аргыг сонгох ажиллагаа хийгдсэн.

1.1. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үндэслэл, шаардлага.

Эрх зүйн үндэслэл:

Монгол Улс 2009 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцод нэгдэн орсноор тус конвенцын үзэл баримтлалд нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар дотоодын хууль тогтоомжоо боловсронгуй болгох, холбогдох зохицуулалтыг сайжруулах үүргийг хүлээсэн.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2 дугаар зүйлд “Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой.”, 22 дугаар зүйлд “Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй.” гэж тус тус заасан.

НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030” буюу дэлхийн хөгжлийн зорилтуудын 10 дахь “Тэгш бус байдлыг бууруулах”¹ зорилтын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам “2030 он гэхэд нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, яс үндэс, удам угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн болон бусад байр сууриасаа үл хамааран хүн бүрийг нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд эрх тэгш оролцох боломжоор хангаж, дэмжих”², мөн “Ялгаварлан гадуурхсан хууль журам, бодлого, зан заншлыг халж, энэ талын хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих замаар тэгш боломж бололцоог бүрдүүлж, тэгш бус байдлыг бууруулах”³, “Санхүү, цалин, нийгэм хамгааллын бодлогыг батлан хэрэгжүүлж, тэгш байдлыг аажмаар хангах”⁴ үүргийг хүлээсэн. Үүнээс гадна “Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030”-ын 10 дахь зорилтоос гадна Ядуурлыг бууруулах 1 дэх зорилгын 1.3 дахь зорилт⁵, Чанартай боловсролыг дэмжих 4 дэх зорилтын 4.5 дахь зорилго⁶, Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих 8 дахь зорилгын 8.5 дахь зорилтын⁷ хүрээнд ХБХ-ий боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх шаардлага бий болсон.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...", Арван зургаадугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг дурдаж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." хэмээн баталгаажуулсан боловч өнөөгийн хууль тогтоомжуудад дээрх эрхийг эдлүүлж, үүргийг хэрэгжүүлэхэд эрх зүйн зохицуулалт дутмаг, хэрэгжилт хангалтгүй байна.

Монгол Улсын Их Хурал (цаашид “УИХ” гэх)-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн “Хүний хөгжил” хэмээх Хоёрдугаар бүлгийн 2.3.3-т “...хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар

¹ Тогтвортой хөгжлийн зорилго

² Мөн тэнд Зорилт 10.2

³ Мөн тэнд Зорилт 10.3

⁴ Мөн тэнд Зорилт 10.4

⁵ Үндэсний онцлогт тохирсон нийгэм хамгааллын тогтолцоо, бүх хүнд зориулсан нийгэм хамгааллын арга хэмжээ, түүний дотор нийгэм хамгааллын үндсэн үйлчилгээг нэвтрүүлж, түүнд ядуу, эмзэг бүлгийн дийлэнх хэсгийг 2030 он гэхэд хамруулах

⁶ 2030 он гэхэд боловсролын байгууллагад суралцагсдын жендерийн зохистой харьцааг хангаж, эмзэг бүлэг, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нутгийн уугуул хүмүүс, эмзэг бүлгийн хүүхдүүдэд бүх шатны боловсрол, мэргэжлийн сургалтыг тэгш авах боломжийг бүрдүүлэх

⁷ 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнэтэй ажилд адилхан цалин хөлс олгох

баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын зохицуулалтыг сайжруулна.”, 2.6.14-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.”, 2.6.16-д “...хөгжлийн бэрхшээлтэй иргэд хагас цагаар, гэртээ, зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгоно.”, “Амьдралын чанар ба дундаж давхарга” хэмээх бүлгийн 3.1.18-д “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ.”, “Амар тайван, аюулгүй нийгэм” хэмээх Долоодугаар бүлгийн 7.3.5-д “Хорих анги, цагдан хорих, баривчлах байр, “Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага”-д хоригдож хүмүүжиж байгаа суурь өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл, аюулгүй байдлыг бүрэн хангаж, хүний эрхийг дээдэлсэн орчин нөхцөл бүрдүүлнэ.”, 7.3.11-д “Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл зөвлөгөө өгөх төвийг байгуулна.” гэж тус тус тусгасан.

Түүнчлэн, УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Хоёрдугаар бүлгийн 2.1.1.23-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах эрх зүйн орчныг сайжруулна.”, 2.1.1.25-д “Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлж, салбар дундын нийгмийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.”, 2.1.1.28-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангаж, цахимаар, зайнаас, цагаар болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.”, 2.1.1.29-т “Төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулна.” гэж тусгасан.

УИХ-ын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2025 онд батлахаар тусгасан.

Иймээс дээр дурдсан эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах, ХБХ-ий хөгжлийг дэмжих чиг хандлагыг тогтоох, ХБХЭТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад зориулан хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн.

Практик шаардлага

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн байдлыг тодорхойлсон анхны хууль 1995 онд батлагдсан Тахир дутуу иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль байсан бөгөөд уг хуулийг 2005 онд шинэчлэн найруулж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль болгон өөрчилсөн байдаг. ХБХ-ий эрхийг хамгаалах хууль тогтоомжид үзэл баримтлалын шинжтэй өөрчлөлт оруулж 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг баталсан бөгөөд өнөөг хүртэл хэрэгжиж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өнгөрсөн хугацаанд нийт 10 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч дийлэнх нь бусад хууль тогтоомжийн шинэчлэлтэй холбоотой, дагалдах хуулийн түвшний өөрчлөлтүүд байсан бөгөөд зарчмын шинжтэй өөрчлөлт хийгдээгүй байна. Тодруулбал, 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр “их дээд сургуульд сургуульд суралцах шалгалтад тэнцсэн хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сан хариуцах”, 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар “Ерөнхий боловсролын болон тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардлыг санхүүжүүлэх, үдийн хоолоор үйлчлэх журмыг батлахтай холбоотой болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймгийн төвд нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих”, мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс 18 нас хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох эрх зүйн орчныг бүрдүүлсэн бол бусад нэмэлт, өөрчлөлтүүд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулиуд, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хууль, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулиудын шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдож ихэвчлэн нэр томъёог өөрчилсөн байдаг.

2018 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка төслийн захиалгаар гүйцэтгэсэн ХБХЭТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр хуулийн зохицуулалт зорилгодоо хүрч чадаагүй, талууд нэгдмэл ойлголтод хүрээгүй, хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаагүйгээс төсөв хөрөнгө дутагдалтай, хүний нөөц, чадавх сул, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй гэх дүгнэлтэд хүрсэн байна.

Гэвч хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажил хэрэгжээгүйгээс өнөөдөр ч дээрх асуудлууд шийдвэрлэгдээгүй, тулгамдсан асуудал хэвээр байгаа ба ХБХЭТХ-ийн давхардал, хийдэл, зөрчлийн судалгаагаар уг хуулийн дотоод болон бусад хуультай үүсгэж буй давхардал, зөрчлийн тоо 51 байна. Үүнээс хуулийн нэр томьёо бусад хуультай зөрчилдсөн 10, хуулийн зохицуулалт салаа утгатай 5 байгаа бол тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томьёологдоогүй буюу хуулийн зохицуулалтыг хэрэгжилт хангагдахгүй байхад шууд нөлөөлөх 14, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй 7 заалт байгаа нь энэ хуулийг шинэчлэх болон холбогдох бусад хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ байгааг илэрхийлнэ.

Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар ХБХ-ийн суурь эрхийг баталгаатай эдлүүлэх түүнийг хамгаалах, эрхийг хангах нөхцөл, хугацаа, дараалал зэрэг нарийвчилсан зохицуулалтыг тусгах, тухайлбал, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль зэрэг салбарын бусад хуультай уялдуулж дээр дурдсан давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, мөн ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох, сурч, хөгжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь хууль, тогтоомжийн уялдаагүй байдлаас шалтгаалан хөдөлмөрийн насны ХБХ-ий 80 орчим хувь нь, байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүнийг асран халамжлагчид ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй, үүний улмаас ядууралд өртөж байгаа байдлыг өөрчлөх боломжтой гэж үзэж байна.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох аргачлалыг олон улсын жишигт нийцүүлснээр ХБХ-д үзүүлэх дэмжлэгийн төрөл, хэмжээг тодорхой болгох, мөн ХБХ өөрт тохирох ажлын байранд ажиллах, ажил олгогчид уламжлалт хандлагаа өөрчилж “тохируулгатай ажлын байр” бий болгох, үүнийг төрөөс дэмжих арга замыг тодорхойлох боломж бүрдэнэ. Энэ нь нэг талаас ХБХ-ий орлогыг нэмэгдүүлэх, нөгөө талаас тухайн хүний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

Үндэсний статистикийн хорооны 2023 оны жилийн эцсийн мэдээгээр Монгол Улсад 111, 228 хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа нь нийт хүн амын 3.1 хувийг эзэлж байна.

Иймээс ХБХ-ий эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үүнд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үүрэг, оролцоо, төсөв, санхүүжилтийг тодорхой болгох, чиг үүргийн давхардлыг арилгах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд төрөөс үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ болон ХБХ-ий бие даан амьдрах эрхийг хангах чиглэлээр тэдэнд үзүүлэх үйлчилгээ бүрийг тодорхой болгох, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх гээд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад тулгамдаж буй асуудлуудыг энэхүү үнэлгээний хүрээнд тодруулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд үнэлгээний үр дүнд үндэслэн ХБХ-ий эрхийг хангах эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн, ашиглаж болохуйц шийдлийн хувилбаруудыг дэвшүүлнэ.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Засгийн газрын (цаашид “ЗГ” гэх) Аргачлал батлах тухай 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д⁸ (цаашид “Аргачлал” гэх) зааснаар Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлохдоо хэрэгжилтийг нь шалгаж үнэлгээ хийх гэж буй хууль тогтоомжийн бүтэц, агуулга, зохицуулалтын шинж чанар, онцлогоос хамааран аль тохиромжтой буюу

⁸Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал. Эх сурвалж: <http://legalinfo.mn/annex/details/7338?lawid=11993>

түүгээр хэрэгжилтийн үр дагавар нь гарч ирэх шалгуур үзүүлэлтийг сонгох⁹ боломжтой байдаг.

Монгол Улсын Их хурлаас 2016 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль нийт 12 бүлэг, 45 зүйлтэй. Энэхүү үнэлгээний хүрээг тогтоохдоо ХБХЭТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт 2018 онд хийсэн үнэлгээгээр сонгон судалсан 26 зүйл, заалтыг сонгож тухайн үед тулгамдсан асуудлууд шийдвэрлэгдсэн эсэхийг судаллаа. Учир нь эдгээр эрх зүйн зохицуулалтууд уг хуулийг хэрэгжүүлэхэд агуулгын хувьд чухал ач холбогдолтой хэвээр байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдрах орчны хүртээмжид холбогдох асуудлын хүрээнд ХБХЭТХ-ийн Гуравдугаар бүлгийн 8 дугаар зүйлийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ. 8.1 дэх хэсэг. 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5 дахь хэсэг. 10 дугаар зүйл. Нийтийн тээврийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх. 10.1, 11 дүгээр зүйл. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх. 11.1, 11.2.1 дэх хэсэг, заалт;
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, хөгжих эрхийн хэрэгжилтийн хүрээнд ХБХЭТХ-ийн Дөрөвдүгээр бүлгийн 14 дүгээр зүйл. Сурч боловсрох эрх. 14.1.3 дахь заалт, 14.3.2 дахь заалт, 15 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөл, 15.1.1.-15.1.4, 15.3, 15.5, 15.6, 15.7 дахь хэсэг, 16.3, 16.4 дэх хэсэг;
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтэд холбогдох асуудлын хүрээнд Тавдугаар бүлгийн 17 дугаар зүйл. Хөдөлмөрлөх эрх, 17.3 дахь хэсэг. 18 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг төрөөс дэмжих 18.1.1-18.1.6 дахь хэсэг;
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээнд холбогдох асуудлын хүрээнд Зургадугаар бүлгийн 20 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ 20.1, 20.2 дахь хэсэг;
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний зарим эрхийн хэрэгжилттэй холбогдох асуудлын хүрээнд Есдүгээр бүлгийн 27 дугаар зүйл. Хууль зүйн туслалцаа авах эрх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох 30.3, 30.4, Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих 33.2 хэсгийг тус тус сонгосон.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгох, шалгуур үзүүлэлтийг томьёолох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал-ын 3.1.3-т заасан шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох ажлын хүрээнд ХБХЭТХ-ийн зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр сонгосон.

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Аргачлалд заасан “зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тодорхой таамаглал дэвшүүлэх, асуулт тавих замаар тогтоохыг зорьдог¹⁰

1.3.2. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

ХБХЭТХ-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг аргачлалын 3.7.3.1-т заасан бэлэн байгаа мэдээлэл цуглуулах арга буюу холбогдох ном, товхимол, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (цаашид ГБХНХЯ гэх), Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (цаашид ХБХХЕГ гэх), Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар (цаашид ХХҮЕГ гэх) зэрэг холбогдох байгууллагаас гаргасан статистик тоо мэдээ зэргээс, мөн аргачлалын 3.7.3.2-т заасан холбогдох субъектээс судалгаа авах аргын дагуу тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж буй байгууллагуудаас шаардлагатай мэдээ, мэдээллийг нарийвчлан гаргуулах зэргээр бүрдүүлсэн болно.

⁹ ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.6.2 дахь заалт. <http://legalinfo.mn/annex/details/7338?lawid=11993>

¹⁰ ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.4.1 дэх заалт. Эх сурвалж: <http://legalinfo.mn/annex/details/7338?lawid=11993>

1.4. Үнэлгээний арга зүй

Энэхүү үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан хийж, гүйцэтгэв. Түүнчлэн ХБХЭТХ-ийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлахдаа харьцуулах, түүхчлэх, задлан шинжлэх (анализ), баримт бичигт дүн шинжилгээ хийх гэсэн хууль зүйн судалгааны үндсэн арга зүйг ашигласан.

Үүнээс гадна ХБХ-ий эрх, нийгмийн тэгш оролцоог хангах асуудлуудаар салбарын мэргэжилтэн, төрийн бус байгууллагууд, тэдгээрийн төлөөлөл, ХБХ, байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн асран хамгаалагч зэрэг субъектээс хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг хэрхэн үнэлж буйг тогтоосон, мөн өмнө хийгдсэн судалгааны ажлуудыг ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатанд төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон үнэлгээ хийх хүрээнд багтсан зүйл заалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл буюу хууль тогтоомж, илтгэл, нийтлэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, ном, эмхэтгэл зэрэг олон нийтийн хүртээл болгосон бүтээлүүд болон холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ХБХЭТХ-ийн сонгогдсон заалтууд тухайн асуудлыг хангалттай зохицуулж чадаж байгаа эсэх, хэрэв хангалтгүй бол ямар шалтгаан байгааг тодорхойлохоор ажилласан.

Монгол Улсын хүн ам өсөж, нийгэм, эдийн засаг өргөжихийн хэрээр төрөлхийн болон олдмол ХБХ-ий тоо өсөж байна. Энэ нь хүн амын төвлөрөл үүссэн нутаг дэвсгэрт агаар, ус, хөрсний бохирдол, техник, тоног төхөөрөмж, ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалж байгаа бол хүн ам цөөтэй орон нутагт хүн амын дундах цус ойртолтоос шалтгаалсан ХБХ-ий тоо нэмэгдэж байгаатай холбоотой.





График 1 Монгол Улсын хүн амын тоо, ХБХ хүний тоо-харьцуулалт

Монгол Улсын хүн амын тоо 2016 оноос 2024 он хүртэл 16,9 хувиар өссөн бол ХБХ-ий тоо 11,7 хувиар өссөн байна. Дээрх тоо мэдээллийг 3 жилийн мөчлөгөөр судалж үзэхэд ХБХ-ий тоо нийт хүн амын 3,1-3,3 хувийг ХБХ эзэлж байгаа ба нийт хүн амд эзлэх ХБХ-ий тоо 2014 онд 3,32 хувь, 2017 онд 3,26 хувь, 2020 онд 3,22 хувь, 2023 онд 3,17 хувь болж буурах хандлага ажиглагдаж байна.

График 2 Хүн амд эзлэх ХБХ-ий тоо, ХБХ-ий тоо 3 жилийн өмнөх дүнтэй харьцуулсан үзүүлэлт (хувиар)




Нийт хүн амд эзлэх хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 2014-2023 онд дунджаар 3,2 хувийг эзэлж байгаа ба тогтмол буурсан үзүүлэлттэй байна. Харин Статистикийн мэдээллийн нэгдсэн санд¹¹ бүртгэгдсэн ХБХ-ий тооны хувьд харьцангуй өндөр хэлбэлзэлтэй байгаа нь хууль, эрх зүйн орчны болон бүртгэл мэдээлэл, үнэлгээний хэлбэрт орсог өөрчлөлттэй

¹¹ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан дахь “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, хэлбэрээр” мэдээлэл https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_3900_004V1&Disability_select_all=0&DisabilitySingleSelect=1&YearY_select_all=0&YearYSingleSelect= 2011 2023 2020 2017 2014&viewtype=table. Сүүлд үзсэн 2025.01.02

холбоотой байх магадлалтай байна. Тухайлбал, ХБХ-ий тоо 2011 онтой харьцуулахад 2014 онд 12,708 хүнээр буюу 14,6 хувь болж өссөн бол 2023 оныг 2020 онтой харьцуулахад 2,829 хүнээр буюу 2,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


График 3 ХБХ-ий тоо, хөгжлийн бэрхшээлээр



Харин ХБХ-ий тоог хөгжлийн бэрхшээлийн төрлөөр авч үзвэл хөдөлгөөний, сэтгэцийн болон бусад бэрхшээлтэй хүмүүс нийт ХБХ-ий 72 хувийг эзэлж байгаа нь цаашид анхаарах шаардлагатай асуудлын нэг юм. Учир нь дээр дурдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо жил бүр нэмэгдэж байгаа бол бусад, хэл, яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн тоо буурах хандлагатай байна.

Ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо цаашид нэмэгдэхэд цус ойртолт нөлөөлөх эрсдэлтэй байгааг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх Стратеги судалгааны хүрээлэнгээс¹² 2021 онд гүйцэтгэсэн “Хүн ам дахь цус ойртолт, үр дагавар” судалгаагаар тогтоосон байна.

Зураг 1 Хүн ам дахь цус ойртолтын түвшин, өвчлөлийн төрөл хоорондын регресс хамаарал¹³



Дээрх судалгаагаар Монгол Улсын хүн амд өөрөөс дээш 3-4 дэх үеийн ах, дүү нар гэрлэхэд цус ойртолт бий болж, энэ нь бүх аймаг, сум, багийн хүн амд нийтлэг үзэгдэл болсныг хүн судлаач эрдэмтдийн олон жилийн генетикийн судалгааны үр дүнгүүд хөдөлбөргүй нотолдог. Түүнчлэн гэрлэлтийн тогтолцоо ихээхэн эвдэгдэж хөдөөгийн багийн хувьд нэг багийн уугуул хүмүүс хоорондоо гэрлэх нь нийт гэрлэлтийн 85,4%, нэг сумын уугуул хүмүүс хоорондоо гэрлэх нь нийт гэрлэлтийн 73,9%, нэг аймгийн уугуул хүмүүс хоорондоо гэрлэх нь нийт гэрлэлтийн 86,1%-ийг тус тус эзэлдэг болсон. Төв суурин газар тийш чиглэсэн ганц урсгалт шилжих хөдөлгөөнтэй холбоотой хөдөө орон нутгийн хүн ам хэт цөөрч шууд бус цус

¹² Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх Стратеги судалгааны хүрээлэн. Эх сурвалж: <https://iss.gov.mn/?p=1340> Сүүлд үзсэн: 2025.01.02

¹³ Мөн тэнд

ойртолтын түвшин сүүлийн 10 жилд 1,2-5,1 дахин өссөн. Хүн ам дахь цус ойртолтын өнөөгийн түвшин дараах ноцтой үр дагавар учруулж байгааг анхааруулсан байна.

Судалгааны үр дүнд “Монгол Улсын 22 аймаг бүгд цус ойртолтод өртсөн бөгөөд үүний үр дагавар нь нэгт, өвчний олон улсын Х ангиллын 19 бүлэг өвчин, 32 төрлийн хорт хавдраар Монгол хүн өвдөж, эндэхэд цус ойртолт бодитой нөлөөлж байгааг, хоёрт, Монгол Улсын хүн амд бүртгэгдсэн “Оюуны хомсдол”-ын нийт тохиолдлын тавин хувь нь цус ойртолтын шалтгаантай болохыг, гуравт, төрөлхийн хөгжлийн согог, гажигтай хүүхэд аймаг бүрт мэндэлж, жил ирэх тусам тооны хувьд эрс өсөж, мэс заслаар ч шийдэх боломжгүй хүнд хэлбэрийн гажгууд илэрч байгаа нь цус ойртолттой шууд бөгөөд хүчтэй хамааралтай байна” гэж дүгнэснийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд зайлшгүй анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Иймээс хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ ХБХ-ий боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, амьдрах орчин болон зарим үйлчилгээний хүртээмжтэй байдалд холбогдох ХБХЭТХ-ийн холбогдох 32 заалтыг зорилгод хүрэх түвшин, практикт нийцэх байдал шалгуур үзүүлэлтийн дагуу сонгож үнэлэхээс гадна хөгжлийн бэрхшээлэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ХБХ-тэй хүнтэй ажиллаж хүний нөөц, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээх асуудлыг хөндсөн болно.

2.1. Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

2.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ зорилгодоо хүрсэн эсэх

Хүснэгт 1 8, 9, 10, 11 дүгээр зүйлийн холбогдох заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
	Хуулийн III бүлэг	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ АЖИЛЛАЖ АМЬДРАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	
	8 дугаар зүйл	Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ	
1	8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт	Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.	Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь ХБХ-д хүртээмжтэй болсон байна.
	9 дүгээр зүйл	Орон сууц, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх	
2	9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт	Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, тэдгээрийг чөлөөтэй ашиглах нөхцөлийг энэ хууль, хот байгуулалтын болон барилгын тухай хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх ажлыг иргэн, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулна.	ХБХ орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, тэдгээрийг чөлөөтэй ашиглах нөхцөл бүрдсэн байна.
3	9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалт	Орон сууц, нийгмийн дэд бүтцийн байгууламжийг ашиглалтад оруулах барилгын комиссын бүрэлдэхүүний дөрөвний нэгд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.	Барилгын комиссын бүрэлдэхүүний дөрөвний нэгд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөлөл орсон байна.
4	9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг улсын комисс хүлээж авахыг хориглоно.	2016 оноос хойш Улсын комисс ХБХ-ий шаардлага хангаагүй барилга хүлээж аваагүй байна.
	10 дугаар зүйл	Нийтийн тээврийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх	
5	10 дугаар зүйлийн	Нийтийн тээврийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн	ХБХ нийтийн тээврээр зорчих боломж бүрдсэн

	10.1 дэх заалт	тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.	байна.
	11 дүгээр зүйл.	Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх	хөгжлийн бэрхшээлтэй хүний
6	11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт	Мэдээллээр үйлчилдэг хуулийн этгээд нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, техник, технологийн хэрэгсэл, бусадтай харьцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.	ХБХ мэдээллийг чөлөөтэй авах нөхцөлд бүрдсэн байна.
7	11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт	Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрх, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 11.2.1. төрийн байгууллагын цахим хуудас хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээллийг чөлөөтэй авах боломжийг бий болгох;	Төрийн байгууллагын цахим хуудаснаас ХБХ мэдээлэл авах нөхцөл бүрдсэн байна.

ХБХЭТХ-ийн 3 дугаар бүлэгт тусгасан ХБХ-ий ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах эрх зүйн зохицуулалтын хүрээнд төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдийн зүгээс заавал хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан дээрх 7 заалтын хэрэгжилтийг орон сууц, нийтийн барилга байгууламж болон дэд бүтэц, нийтийн тээвэр гэсэн үндсэн 2 асуудал болгон хуулийн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэхийг үнэллээ.

Нийтийн болон орон сууцны зориулалтаар баригдсан барилга байгууламж ХБХ-ий хэрэгцээ, шаардлагад нийцэж буй эсэх

ХБХ зам, барилга, орон сууц гэхчлэн нийтийн байгууламжид зорчиход орчны саадтай цаг ямагт тулгардаг. Эдгээр саад, бэрхшээлийг шийдчихвэл ХБХ төдийгүй ахмад настан, бага насны хүүхэдтэй хүн гээд бүх иргэн аливаа үйлчилгээг хүртээмжтэй авч, ялгаатай байдал арилах юм. Гэвч манай улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны хүртээмж одоо болтол хангалтгүй, саадтай хэвээр. Иймээс ХБХ орчны саад бэрхшээлээс шалтгаалан бусдаас байнга дэмжлэг авч, тэднээс хараат, нийгмийн идэвхгүй нэгэн болж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орчны дэд бүтцийн асуудал шийдвэрлэгдэхгүй байгаатай салшгүй холбоотой.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд орчны саад бэрхшээлүүд нь дэд бүтцийн хүртээмжгүй байдал, хүртээмжгүй нийтийн тээвэр, нийгмийн сөрөг хандлага, хууль тогтоомж дахь тодорхойгүй байдал, туслах технологийн хүрэлцээгүй байдал зэргээс хамгийн их шалтгаалдаг байна.¹⁴.

Монгол Улсад өнөөдөр 111 мянга гаруй ХБХ амьдарч байгаагаас 2023 оны байдлаар 3 хүн тутмын 1 нь буюу 35 мянга гаруй¹⁵ ХБХ нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна. Эдгээр иргэд бусад иргэдийн адил нийгмийн үйлчилгээг авч чадахгүй байна. Үүний гол шалтгаан нь ХБХ-д зориулсан дэд бүтэц байхгүй, төр үйлчилгээ, олон нийтийн үзвэр үйлчилгээний газрууд тэдний асуудлыг орхигдуулсны улмаас хязгаарлагдмал нөхцөл байдал буюу бэрхшээлийг улам нэмэгдүүлж хэн нэгнээс хараат амьдрахаас өөр аргагүй байдал үүсгэж байна. Хэдийгээр 2016 онд батлагдсан ХБХЭТХ-ийн 8, 9 дүгээр зүйлд ХБХ орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хүртээмжтэй, саадгүй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, ийм шаардлага хангаагүй барилга байгууламжийг ашиглалтад авахгүй байх зохицуулалт оруулсан боловч өнөөг хүртэл бүрэн хэрэгжээгүй. Үүнд уг хуулийн 9.5-д заасан барилга ашиглалтад авах улсын комисс шаардлага хангаагүй барилга хүлээж авч байгаа нь нөлөөлж байгаа боловч тэдэнд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин тодорхойгүй, хариуцлага хүлээлгэдэггүй байдал нөлөөлж байна.

¹⁴ UB Case Study Publication Package Mongolian version.pdf
¹⁵ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, хүйс, бүс, аймаг, нийслэлээр. Эх сурвалж: https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_3900_002V1&SOUM_select_all=1&SOUMSingleSelect=&SEX_select_all=0&SEXSingleSelect=_1&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2023_2022_2021&viewtype=table

Хөгжлийн бэрхшээл үүсгэж буй өвчлөл гэмтлийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл ХБХ-ий 40 хувь нь авто ослоор, 22,8 хувь үйлдвэрлэлийн ослоор, 22,8 хувь ахуйн ослоор хөгжлийн бэрхшээлтэй болсон бол 3,8 хувь нь төрөлхийн, 1,9 хувь нь өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон¹⁶ гэсэн үзүүлэлт гарсан байна. Үүнээс үзэхэд нийт ХБХ-ий 60 гаруй хувь нь насанд хүрсэн, хөдөлмөрийн насандаа олдмол хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа бөгөөд дэд бүтцийн хүртээмжгүй байдал нь нь тухайн хүний эрүүл мэнд, сэтгэл зүй, эдийн засгийн байдал, нийгмийн идэвх, оролцоонд сөргөөр нөлөөлж байна.

Орчны хүртээмжийг сайжруулах тухай асуудал нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамааралтай бус, харин тухайн улс, хотын хөгжлийн суурь бодлого, төлөвлөлт болон хөгжиж байна. Харах, сонсох, хөдлөх, танин мэдэх, бусадтай харилцах, сэтгэн бодох, хүртэх, сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах, өөрийгөө хянах, анхаарлаа төвлөрүүлэх, суралцах зэргээр хүн бүрийн үйлдэхүйн чадвар нь өөр өөр. Ийм өөр өөр хүн бүр л саадгүй амьдрах орчныг бүрдүүлэх нь эдүгээ улс орнуудын тэргүүлэх зорилго болжээ.¹⁷

Манай улсад ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн, Барилга, хот байгуулалт, авто тээвэр, авто зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай зэрэг хуулиудад тодорхой зохицуулалтуудыг тусгаж эрх зүйн орчныг бүрдүүлсэн хэдий ч хэрэгжилт хангалгүйн улмаас ХБХ-ий эрх алхам тутамд зөрчигдөж байна. Нэн ялангуяа ХБХ-ий хамгийн ихээр үйлчилгээ авдаг эрүүл мэндийн байгууллагуудын хэмжээнд ч хангалтгүй байна. Тодруулбал, 2018 онд Хүний эрхийн үндэсний комиссоос хийсэн “*Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан*”¹⁸-д дурдсанаар “*нийслэлийн хэмжээнд судалгаанд хамрагдсан 9 өрхийн эрүүл мэндийн төвийн барилгад сүүлд шинээр бий болгосон тэргэнцэртэй хүнд зориулсан налуу зам стандартын шаардлага хангахгүй, мөн эрүүл мэндийн төв хүртэлх замд хашлага, босго, шон, хашлага их байх боловч хараагүй иргэд зориулсан тусгай тэмдэглэгээтэй замгүй байгаа нь гадаад орчны хамгийн том бэрхшээл байна. ... Харин үнэлгээнд хамрагдсан аймаг, сумын нэгдсэн эмнэлэг, БОЭТ, амаржих газруудын гадаад орчны тохижилт ХБХ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг харьцангуй сайн хангаж өгсөн нь барилга байгууламж анхнаасаа эмнэлгийн зориулалтаар баригдсанаас гадна түүний гадаад, дотоод орчинд зарим өөрчлөлт, өргөтгөл хийх зай талбай хангалттай байсантай холбоотой байв.*” гэжээ.

Хөгжлийн бэрхшээл үүсгэж буй шалтгаан нөхцөлийн 40 хувийг эзэлж буй зам тээврийн осол, түүнийг үүсгэгч автозамын болон явган хүний зам талбайн дэд бүтцийн асуудал өнөөг хүртэл шийдэгдээгүй, ХБХ-д төдийгүй, эрүүл мэндийн хувьд асуудалгүй иргэдэд ч ээлгүй байна. Тиймээс зам тээврийн ослын эрсдэлтэй нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүний дэд бүтцийн хүртээмж хангалтгүй байх нь тэднийг нийгмийн харилцаанаас шууд тусгаарлах хүчин зүйл болж байгааг судалгааны дүн харуулж байна. Тодруулбал, ХБХ нийгмийн харилцаанд тэгш эрхтэй оролцоход юу саад болж буй талаарх асуулгад хамрагдсан иргэдийн 2,36 хувь нь өөрөө оролцох сонирхолгүй, 27,6 хувь нь нийгмийн харилцаа, 80,0 хувь нь зам, шат, хаалга хүндрэл үүсгэдэг гэсэн бол 98 хувь нь тээврийн хэрэгсэл, унаа гэсэн хариултыг өгчээ.¹⁹

Монгол Улсын хүн амын талаас илүү хувь нь нийт нутаг дэвсгэрийнхээ 0,02 хувьд нягтаршин амьдарч буй энэ орчинд барилга байгууламж, дэд бүтэц хүртээмжийг бий болгодог эсвэл үгүй хийдэг бөгөөд үүнийг нийгмийн амьдрал, хүрээлэн буй орчинд өөрийн дураар оролцох боломж нь хязгаарлагдсан хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамгийн гүнзгий мэдэрдэг байна.²⁰

Б. Хууль тогтоомжийг ХБХ-ий хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн эсэх

2016 онд батлагдсан ХБХЭТХ-иар саадгүй орчин бүрдүүлэх, бодлого, хэтийн төлөвлөлтийг тодорхойлох зорилгоор тодорхой зохицуулалт оруулсан. Хуулийн 9 дүгээр зүйлд дэд бүтэц,

¹⁶ Д.Сүнжид. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 2018 он.

¹⁷ Хүн бүр саадгүй амьдрах орчин бүрдүүлье. Өнөөдөр сонин. *О.Бат-Ундрах. 2022.02.16*

¹⁸ ХЭҮК. Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан. 2018 он. Эх сурвалж: <https://lib4u.net/?lib=nhrc&search=Эрүүл+мэндийн+салбар+дахь+хүний+эрхийн+хэрэгжилтэд+хийсэн+үнэлгээний+тайлан>

¹⁹ Д.Сүнжид. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 2018 он.

²⁰ [UB Case Study Publication Package Mongolian version.pdf](#)

орон сууц, олон нийтийн газар саадгүй чөлөөт орчин бүрдүүлэх талаар төрөөс хүлээх үүргийг тодорхойлж, авто зам, хучилт, замын байгууламжийн үндэсний стандартыг боловсруулахыг үүрэг болгосон. Гэвч хуулийн зохицуулалт хэрэгжээгүй. Тухайлбал, нийтийн тээврийн хэрэгсэл, автобус, нийтийн үйлчилгээний байгууллагуудын авто зогсоол, автобусны зогсоол зэрэг нь ХБХ-ий онцлог хэрэгцээг хангахгүй байна. ХБХ-д зориулсан хөрөнгө оруулалт, тохижилт нийслэлийн хэмжээнд илүү хийгдэж байгаа бол орон нутагт хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд хөгжлийн бэрхшээлийн хандлага төлөвшөөгүй, санхүүжилт хангалтгүй гэсэн үндсэн 2 шалтгаан нөлөөлж байна. Нийслэл Улаанбаатар хотын хувьд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нийслэлийн салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд дэд бүтэц, нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах, шинээр оруулж ирэх автобуснууд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй байх шаардлага хангах, мөн явган хүний замын хүртээмжийг сайжруулан, хөтөч хавтан, орц гарцын налуу стандартыг хангах, өргөтгөх, тохижилт, бүтээн байгуулалт хийх зэрэг иргэдээс гаргасан саналыг тусгадаг. Гэхдээ хэрэгжилт хангалтгүй буюу хотын төв хэсэгт л эдгээр өөрчлөлтүүд бага багаар хийгдэж байна. Тодруулбал, нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр худалдан авах автобусны техникийн үзүүлэлтэд “хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих нэмэлт тоноглолтой байх” шаардлагыг 2015 оноос хойших худалдан авалтад тавьж байгаа боловч 2024 он хүртэл хотод өдөр тутам үйлчилж байгаа 1020 тээврийн хэрэгслийн 40.8 хувь буюу 417 автобус хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу тавцантай болсон. Харин хөдөлгөөний эрчим, автобусны ачаалал зэргээс шалтгаалан налуу хавтанг ихэвчлэн ашиглах боломжгүй байна. Тэгвэл зам, талбайд үүссэн эвдрэл, гэмтэл, тогтсон ус, цас, мөсний асуудлаас гадна замын хашлаганы буруу төлөвлөлт ХБХ төдийгүй, эрүүл саруул хүнд ч бэрхшээл үүсгэж байна. Төрөөс хэрэгжүүлэх арга хэмжээ хангалтгүй байхаас гадна иргэдийн дунд ХБХ-нд олон нийтийн газар тулгамдаж буй асуудлын талаар ойлголт, мэдлэг дутмаг, зарим тохиолдолд ухамсар, хүн чанар үгүйлэгдэж байгаагаас шалтгаалан ХБХ-ий эрх зөрчигдөж байна.

ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээг авч байгаа ч төсөв санхүүжилтийг тодорхой тусгадаггүй, шаардлагатай журам, аргачлал зэрэг хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулахад чиглэсэн эрх зүйн актуудыг боловсруулах батлуулах ажил удаашралтай байдаг, төрийн захиргааны байгууллагууд үйл ажиллагаагаа уялдуулдаггүй зэргээс шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байна.

Хууль эрх зүйн орчны хувьд 2016 онд батлагдсан Барилгын тухай хуулийн 11.1.6 дахь “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөн баригдсан байх”, 12.1.6-д зааснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байх” шаардлага тавигддаг. Эдгээр хуулийн заалтад нийцүүлэн боловсруулсан барилгын норм, дүрмээр, тухайлбал, Олон нийт, иргэний барилга /БНБД 31-03-03/, Олон нийт, иргэний барилга (нэмэлт) /БНБД 31-03-03*/11/, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм /БД 31-112-11/, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль /БД 31-101-04/, Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт /БНБД 31-01-10/, Захиргааны зориулалттай олон нийтийн барилга /БНБД 31-04-12/, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, үндсэн шаардлага MNS 6055-2009, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага MNS 5682-2006, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056-2009 зэргээр ХБХ-д холбогдох нийтийн барилга байгууламж, зам талбайд тавигдах шаардлагыг тодорхойлж байна.

Тэгвэл Улаанбаатар хотын хувьд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, сайжруулах үүднээс нийт 22 бүлэг, 97 стандартыг батлан мөрдөхөөр төлөвлөж байгаагаас 2023 оны байдлаар эхний 52 стандартыг баталсан ба үүний 19 стандартад хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжийг хангах тухай заалтууд туссан. Сүүлд нэмэгдсэн 14 стандартын хоёр нь зөвхөн тусгай хэрэгцээт иргэдийн хүртээмжтэй байдлыг хангахад чиглэсэн байгаа.²¹

²¹ Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны гишүүдтэй уулзлаа. Эх сурвалж: НЗДТГ-ЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХЭЛТЭС 2023 оны 05 сарын 08

Улсын хэмжээнд болон Улаанбаатар хотод мөрдөх стандартууд хэрэгжихгүй, стандартын шаардлага хангаагүй барилга байгууламжийг Барилга ашиглалтад авах комисс хүлээн авч байгаа нь төлөвлөлтгүй тэлж буй нийслэлийн барилгажилтын нөхцөл байдлаас харагдаж байна. Энэ талаар ГБХНХЯ-наас Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн зөвлөх, доктор Т.Батдулам 2021 онд “Гэвч барилга байгууламжийг ашиглалтад оруулах, дүгнэлт гаргах Улсын комисст ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөлд хүртээмжийг үнэлэх үнэлгээний шалгуур хуудас нь байдаггүй. Учир нь аль ч байгууллагаас ийм хуудас боловсруулж, батлуулаагүй. Тиймээс энэ бүхнийг нэг бүрчлэн шалгах боломжгүй тул тухайн барилгыг Улсын комисс шууд хүлээн авчхаж байна. Тэгэхээр үнэлгээний шалгуур хуудсыг боловсруулах шаардлагатай гэсэн үг. Мөн зам, нийтийн тээврийн хэрэгслийн орчны хүртээмжийг сайжруулахад хүртээмжтэй байдлын стандарт, түүний хэрэгжилтийг шалгах үнэлгээний хуудас боловсруулах хэрэгцээ бий. Бас нийтийн тээврийн зогсоолын хүртээмжтэй байдлын төлөвлөлт бүхий стандарт, түүнийг шалгах хуудас ч шаардлагатай. Өөрөөр хэлбэл, барилга байгууламжийн хүртээмжийг бүрдүүлэх чиглэлээр хууль, стандарт, норм, дүрэм хангалттай байгаа ч үнэлгээний тодорхой шалгуур хуудсыг өнөөг хүртэл боловсруулж, батлуулаагүй. Түүний дагуу хяналт, үнэлгээг барилга байгууламжид тодорхой, тогтмол хугацаатай, шат дараалалтай хийдэггүй, барилгуудыг гэрчилгээжүүлээгүй учраас холбогдох хуулийг шат шатандаа төдийлөн хэрэгжүүлэхгүй байна” гэж дүгнэсэн байна.²²

Иймээс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, тогтоомж, стандартуудыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай үнэлгээний хуудас, барилга байгууламж, нийтийн тээврийн зогсоолын орчны хүртээмжийн стандарт боловсруулах, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийн оролцоог бодитойгоор хангаж барилга байгууламжийн болон замын зураг төсөл боловсруулах, зураг төсөл хүлээн авах комисст заавал оруулах шаардлагатай байна.

Төрийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд хуучны барилга байгууламжид, эсхүл, түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа нь стандартад нийцээгүй орчинд ХБХ үйлчилгээ авах нөхцөл байдалд хүргэж байна. Тухайлбал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018.04.18-ны өдрийн А/93 тушаалаар хөдөлмөр хамгааллын салбарын нийслэл дэх нийт 37 байгууллагуудын барилга, байгууламжууд холбогдох стандартад нийцсэн эсэх хүртээмжийн үнэлгээг нэгдсэн удирдамжийн дагуу Түгээмэл хөгжил төв, Сонгино бие даан амьдрах төв, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо ТББ-гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээний дүгнэлтэд үнэлгээнд хамрагдсан нийт байгууллагуудын налуу замаас нэг ч стандартад нийцсэн зам байгаагүй, бүх байгууламжид ариун цэврийн өрөөний хаалга стандарт бус, суултуурын өмнөх орон зай стандарт бус буюу хүртээмжгүй, нэмэлт тоноглол буюу бариулгүй байсан бол 90% нь авто зогсоолдоо ХБХ-ий авто зогсоолын төлөвлөлт хийгээгүй, тэмдэг тэмдэглэгээ хийгээгүй, зогсоолын өргөн стандартын бус, үнэлгээнд хамрагдсан ХХҮХ-үүдээс цөөнгүй байгууллага стандарт огт хангаагүй түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг, давхар хаалгатай, хаалганы өргөн, босгоны өндөр стандартын шаардлага хангаагүй байсан зэрэг зөрчлийг арилгах чиглэлээр урт ба богино хугацааны ажлын төлөвлөгөө боловсруулах, шийдвэр гаргах төрийн зохих шатны эрх бүхий этгээдэд энэхүү үнэлгээний товч мэдээлэл боловсруулан хүргүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллахыг мөн зөвлөмждөө тусгасан байна.²³

Шигтгээ

Шигтгээ: Тэргэнцэртэй хүний хувьд би хотод үнэхээр муу дүн тавина. Улаанбаатар хот бол аймшигтай, үнэхээр харгис байна л гэж хэлнэ. Би өөрөө машинаа бариад явдаг. Нийгмийн амьдралаа идэвхтэй байж ажлаа хийнэ, мөн хувийн амьдралаа зохицуулна, бусдад дараа болохгүй гээд бүх чадлаараа зүтгэдэг. Гэтэл энэ ярьж байгаа дэд бүтцээс авхуулаад хүмүүсийн хандлага, ойлголт маш хэцүү байдаг. Би уг нь ажил хөдөлмөр эрхлээд, цалин аваад, улсдаа татвар төлөөд, өрхийнхөө амьдралыг аваад явж байгаа. Зарим үед жирийн хүнээс илүү ачаалалтай ажилладаг. Гэтэл хүмүүс тэгж ойлгодоггүй, бидний ялгаатай талыг л хараад байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд халамжийн мөнгө өгөөд, гэрт нь байлгах ёстой гэдэг социализмын үеийн сэтгэлгээ одоо хүртэл

²² Хүн бүр саадгүй амьдрах орчин бүрдүүлье

²³ Д.Сүнжид. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 2018 он.

ард иргэдэд байсаар л байна. Энэ утгаараа төрийн бодлого, хийж байгаа дэд бүтцийн төлөвлөлт нь үнэхээр муу. Улаанбаатар хотод олон гоё шинэ барилгууд баригдаж байна. Хүмүүс тэнд орж амьдарч, үйлчлүүлэх ёстой. Бид бас хүн шүү дээ. Бид бусадтай адил дэлгүүр орж, ресторанд сууж, үйлчилгээний газруудаар үйлчлүүлэх эрхтэй. Гэтэл тэр дэд бүтцүүд нь байдаггүй. Имарт дэлгүүр гарч ирээд бидний хувьд нөхцөл байдал нилээд таатай болж ирсэн. Хүнтэй гадуур хоолонд оръё гэхээд аль газар налуу замтай билээ, аль ресторан нь тусгай 00-той билээ гээд ярьсаар байгаад таардаг. Тэргэнцэртэй хүн өөрөө ороод, бие даагаад зорчоод явах байшин барилга Монголд байдаггүй. (“Би чадна” ТББ-ын тэргүүн Б.Отгонтуяа ikon.mn-д нийтлэгдсэн ярилцлагын хэсгээс)

ХБХ-нд хүртээмжтэй орчин бий болгох асуудлыг нэр төдий хэрэгжүүлж байгаа нь аль аль талдаа үр ашиггүй зардал гаргаж байна.

Шигтгээ

“оролцогчийн амьдардаг байранд лифттэй боловч хаалганаас лифт хүртэл шаттай учраас хүртээмжгүй байна гэсэн үг. Тиймээс энэ нь хот төлөвлөлт, хамтын ажиллагааны асуудал болж харагдаж байгаа юм; “ихэнх байшин цөөхөн хүртээмжтэй газруудтай хэдий ч тэдгээрийг холбосон хонгил хүртээмжгүй байдаг”²⁴.

Үүнээс гадна ХБХ-ий амьдрах орчны саад бэрхшээлүүдэд өвлийн улирлын цаг уурын хүндрэл, лифтгүй өндөр барилгууд (өндөр гадаах шат), халаалтын ба бохир зайлуулах дэд бүтэц болон гэр хорооллын айлын гадаа жорлон багтаж байна.²⁵

ХБХ-ий ажиллаж, амьдрах, нийгмийн харилцаанд оролцох орчин нөхцөл бүрдүүлэх, тулгарсан саадуудыг арилган, бүх хүнд ээлтэй хот төлөвлөн, байгуулах нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагынхны ч үүрэг, хариуцлага. Хүртээмжтэй орчин буюу түгээмэл загвар нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулагддаггүй, харин ч нас насны бүх иргэн, нийгмийн харилцаанд оролцогч хүн бүрт шаардлагатай зүйл. Жишээ нь, налуу болон чиглүүлэгчтэй хөтөч замаар тэрэг түрсэн хүн, өндөр настан, хүүхдүүд ч ээлтэй орчин, бүх хүн түүгээр эрх тэгш зорчих боломжийг бүрдүүлдэг. ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй хууль тогтоомж, стандартууд нь барилгажсан хотын төвийн бүсэд хамааралтай байгаа бол гэр хороолол буюу дэд бүтэц хөгжөөгүй хотын хэсэгт амьдарч буй ХБХ-ий эрхийн асуудал хүнд хэвээр байна.

Шигтгээ

Явган зорчигчдын хувьд хотоор явахад хэцүү. Хотын төвийн зарим хэсэгт тактилан зам, хүртээмжтэй гарцтай хэдий ч газар бүрд адил биш. Гэр хороололд зам нь засмал биш, эгц өгсүүр газарт цаг агаарын ямар ч нөхцөлд явахад хүнд байдаг. Манай зарим оролцогчид автомашины замаар явахад хялбар гэж үзэн тэргэнцэртэйгээ явдаг: “энэ нь аюултай, машинууд маш ойрхон явдаг, гэвч надад явах өөр зам байхгүй, өөр сонголт байхгүй. Явган хүний зам дээр заримдаа шороо овоолчихсон, заримдаа машин зогсчихсон байдаг”.

ХБХ-д аливаа үйлчилгээ тасралтгүй хүртээмжтэй байх нь чухал. Өнөөгийн байдлаар ХБХ өөрт шаардлагатай ямарваа нэг үйлчилгээг авах хамгийн эхний хэрэгцээ болох дэд бүтцийн, тээврийн хэрэгслийн хүртээмж хангалтгүй, холбогдох хууль тогтоомж хэрэгжижгүй байгаа нь тэднийг эрхээ эдлэх боломжийг хязгаарлаж байна.

Тухайлбал, Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлангаас харахад 2024.12.10-ны өдрийн байдлаар 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1685, хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 515, нийт 2422 ажлын төсөл арга хэмжээний ажлын зураг төсөл төсвийг хүлээн авч, гэрээ байгуулан барилга байгууламжийн ажлын зураг төсөл, төсөвт магадлал хийх ажлыг зохион байгуулж, 2200 ажлыг дүгнэлтийн нэгтгэлээр баталгаажуулсан байна.²⁶ Харин ЗГ-ын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах

²⁴ UB Case Study Publication Package Mongolian version.pdf

²⁵ Мөн тэнд

²⁶ Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлангаас.

тухай” 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтад заасны дагуу “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн”-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллийг гишүүнээр байнга оролцуулан ажиллуулсан байна.

Үүнээс харахад барилга байгууламжийг ХБХ-нд саадгүй, хүртээмжтэй байлгахад чиглэсэн хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа мэт харагдавч бодит нөхцөлд хэрэгжилт хангалтгүй байгаа нь ашиглалтад орж байгаа барилга байгууламжийн хүртээмжтэй байдлаас харагдаж байна.

ХБХЭТХ-ийн 2 8, 9, 10, 11 дүгээр зүйлийн холбогдох заалтын хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж үзвэл хууль батлагдсанаас хойших хугацаанд Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь ХБХ-нд хүртээмжгүй хэвээр байна. Харин хүртээмжтэй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт батлах үүргээ холбогдох төрийн байгууллагуудын үйл ажиллагаа сайн хэрэгжсэн байна. Үүнээс харахад хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх шатанд тавих хяналт хангалтгүй, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага сул байгаа нь нөлөөлж байна. Энэ нь ялангуяа барилга хүлээж авах улсын комиссын бүрэлдэхүүнд ХБХ-ий эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий ТББ-ын төлөөллийг оролцуулах журам бүрэн хэрэгжиж байх авч барилга байгууламж ХБХ-д хүртээмжгүй, саадтай хэвээр байгаа нь улсын комиссын гишүүдийн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэг дутмаг, мөн ашиг сонирхлын зөрчилтэй байх магадлалтайг харуулж байна.

Харилцаа холбооны салбарын хүртээмжтэй байдлын тухайд ХБХЭТХ-ийн 11 дүгээр зүйлд хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах асуудлыг хүрээнд төрийн байгууллагын цахим хуудас хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээллийг чөлөөтэй авах боломжийг бий болгох зохицуулалт тусгагдсан. Гэвч 2025 оны 1 дүгээр сарын байдлаар МУ-ын ЗГ-ын харьяа 14 яамны цахим хуудас²⁷ харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй байгаа бол олон нийтийн хэвлэл мэдээллийн цахим хуудаснууд мөн адил хүртээмжгүй байна. Тухайлбал, МОНЦАМЭ, news.mn, gogo.mn зэрэг 10 мэдээллийн цахим хуудаснаас харааны болон сонсголын бэрхшээлтэй хүн мэдээлэл авах боломжгүй байна. Харин төрийн үйлчилгээний цахим системүүдээс e-mongolia-гаас бусад нь хүртээмжгүй байгаа нь ХБХ-ий төрийн үйлчилгээ авах эрхийг хязгаарласан, хэн нэгнээс хараат байх, мэдээллийн нууц алдагдах нөхцөлийг бүрдүүлж байна.

Дээрхээс харахад 2016 онд ХБХЭТХ батлагдсанаас хойших хугацаанд ХБХ-д тулгарч буй дэд бүтэц, барилга байгууламжийн саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр УИХ, ЗГ, яамд, тэдгээрийн харьяа байгууллагууд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулж ажилласан боловч хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд төлөвлөлт, хэрэгжилт, ашиглалтад хүртээмжтэй байдлыг хэрхэн хангах, хэн хянах, хэн хариуцлага хүлээх асуудал тодорхойгүй, ногдуулах хариуцлага нь хэтэрхий бага зэрэг хүчин зүйлс нөлөөлж байгаа бол хүртээмжгүй баригдсан барилга байгууламжийг хэрхэн өөрчлөх тухай эрх зүйн зохицуулалт байхгүй, төсөв, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, хүрэлцээгүй байдал, хуваарилагдсан төсвийг чанаргүй, дүр эсгэсэн ажилд зарцуулж байгаа нь нөлөөлж байна.

2.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангах тухай хуулийн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх

Хүснэгт 3. 14, 15, 16 дугаар зүйлийн холбогдох заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
	Хуулийн IV бүлэг	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ	
	14 дүгээр зүйл	Сурч боловсрох эрх	
1	14.1.3	бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг	бүх шатны боловсролын байгууллага ХБХ-нд сурч боловсрох, мэргэжил

²⁷ Яамдын цахим хуудасны хүртээмжтэй байдлыг <https://mongolia.gov.mn/холбоосоор> орж шалгасан.

		бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх,	эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлдэг байна.
	14.3.2.	хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг тэдний хүйс, оршин суугаа газар, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үл хамааран бүх шатны боловсролд тэгш хамруулах, тухайн хүүхэд, залуучуудын онцлог, хэрэгцээг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, тэдний шаардлагад нийцсэн хичээлийн анги, танхимыг ердийн сургуулиудад зохион байгуулах үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээх.	ХБХ бүх шатны боловсролд тэгш хамрагдаж, онцлог, хэрэгцээндээ нийцсэн боловсролын хөтөлбөрийн дагуу шаардлагад нийцсэн хичээлийн анги, танхимд хичээллэх боломжтой байна.
	15 дугаар зүйл.	15 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөл	
2	15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг	15.1.Бүх шатны сургалтын байгууллага болон мэргэжлийн сургалтын төв нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид амьдрах ухаан, мэргэжлийн ур чадварыг үр дүнтэй эзэмшүүлэх бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 15.1.1.тухайн суралцагчийн онцлогт тохирсон хамгийн зохистой арга хэлбэрээр боловсрол олгох; 15.1.2.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг онцлог хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах; 15.1.3.сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтыг явуулах; 15.1.4.сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн заах арга зүй, арга барил эзэмшсэн багш, сурган хүмүүжүүлэгч явуулдаг байх;	Бүх шатны сургалтын байгууллага болон мэргэжлийн сургалтын төв нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид амьдрах ухаан, мэргэжлийн ур чадварыг үр дүнтэй эзэмшүүлдэг байна.
4	15.3.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Холбогдох сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр батлагдсан байна.
	15.5	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн явц, ахицын өөрчлөлтийг сургууль, цэцэрлэгийн удирдлага эцэг, эхийн оролцоотой хэлэлцэж, дүгнэлтийг энэ хуулийн 37.2.1-д заасан комисст хүргүүлнэ.	
	15.6.	Элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний мэргэжлийн, дипломын боловсрол болон бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлыг, хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сан хариуцна.	
	15.7.	Ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн ном, сурах бичиг, тусгай	


		хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг худалдан авах зардлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн тухайн жилийн төсөвт тусгана.	
	16 дугаар зүйл	Багшийн мэргэжил	
5	16.3.	Энэ хуулийн 16.2-т заасан арга зүй, арга барилыг олгох сургалт болон зөвлөх үйлчилгээг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллага гүйцэтгэж болно.	ХБХ нийтийн тээврээр зорчих боломж бүрдсэн байна.
	16.4.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, дохионы хэлний багш, сэтгэл зүйч, арга зүйчийг сургалтын төрийн сангийн зардлаар дотоод, гадаадад сургаж бэлтгэнэ.	

Тогтвортой хөгжлийн зорилгын²⁸ үндсэн зарчим болох “Хэнийг ч ардаа хоцроохгүй байх” зарчмыг хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангах замаар мэдлэг, мэргэжил олгох нь нийгмийн харилцаанд тэгш оролцох, ажил хөдөлмөр эрхлэх улмаар бие даан амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй.

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог 2020-2024 оны байдлаар авч үзвэл 2020 онд 106,400 хүн, 2022 онд 115,000 хүн, 2024 онд 111,200 хүн бүртгэгдэж нийт хүн амын 3.4-4 хувийг эзэлж байна²⁹. Үүнээс харахад ХБХ-ий тоо 2020-2022 онд нэмэгдэж, 2024 онд бага зэрэг буурсан байна. Энэ нь тухайн үеийн хүн амын өсөлт, эрүүл мэндийн үйлчилгээ, статистик бүртгэлийн өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж болох юм.

Харин ХБХ-ийн боловсрол эзэмшсэн байдлыг авч үзвэл 2020 оны хүн амын тооллогын дүнгээс³⁰ харахад Монгол Улсад 108,000 гаруй ХБХ бүртгэгдсэн бөгөөд тэдний дунд боловсрол эзэмшсэн хүмүүсийн хувь дараах байдалтай байна:

График 4 ХБХ-ий боловсрол эзэмшсэн байдал



Дээрхээс харахад хөгжлийн бэрхшээлтэй 4 хүн тутмын 1 нь боловсролгүй байгаа ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 21,6 хувь нь бага боловсрол эзэмшиж байгаа ч шатлал ахих тусам энэ тоо буурч дээд боловсролыг 6,7 хувь нь эзэмшсэн нь бүх шатны боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатайг илтгэнэ.


ХБХ-ий сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг 1/Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд сургуульд хамрагдалт бага, сурах орчин тохиромжгүй, сургууль завсардалт өндөр 2/ Дээд боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал, хүртээмжтэй сургалтын хөтөлбөр, дэмжлэг дутмаг, 3/ Харааны, сонсголын болон оюуны бэрхшээлтэй хүнд зориулсан хичээл заах аргазүй, багш хангалтгүй, 4/ Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын материал, орчин хомс 5/Боловсролын хүртээмж хөдөө

²⁸ Тогтвортой Хөгжлийн Зорилгууд. НҮБ. Эх сурвалж: <https://www.undp.org/mn/mongolia/sustainable-development-goals>
²⁹ 1212.mn
³⁰ ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН НИЙСЛЭЛИЙН НЭГДСЭН ДҮН
Эх сурвалж: https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=1.Summary%20report_Ulaanbaatar.pdf&ln=Mn

орон нутагт хоттой харьцуулахад бага, 6/ХБХ-ий ар гэр ядууралд өртсөн байна гэсэн хэд хэдэн үндсэн хүчин зүйлийг нэрлэж болно.


Түүнчлэн боловсролын хүртээмжид хот, хөдөөгийн ялгаанаас гадна хөгжлийн бэрхшээлийн төрөл ч нөлөөлж байна.

График 5 Бүс нутгийн ялгаа ХБХ-ий боловсролд нөлөөлөх байдал



Улаанбаатар хотод бүртгэлтэй, боловсрол эзэмшсэн ХБХ-ий 75 хувь нь суурь боловсрол эзэмшсэн бол 20 хувь нь дээд болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн байна. Харин энэ хувь төвөөс алслагдах тусам буурч сумын хэмжээнд ХБХ-ий 45 хувь орчим нь боловсрол эзэмшиж байгаагаас 5 хувь нь мэргэжлийн болон дээд боловсрол эзэмшсэн байдаг байна. Үүнээс харахад боловсролын хүртээмж төвөөс алслагдах тусам буурч байна.³¹ ҮСХ-ноос гаргаж буй ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо мэдээлэлд орон нутагт суралцаж буй сурагчдын тоо 2020 оноос хөдөө орон нутагт тогтмол буурч байгаа бол Төвийн бүсэд болон Улаанбаатар хотод өссөн дүнтэй байгаа нь үүнийг нотолж байна.

График 6 ХБХ-ий боловсрол эзэмшсэн байдал, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр



Хөгжлийн бэрхшээлтэй хүн сурч боловсрох эрхээ эдлэхэд түүний хөгжлийн бэрхшээлийн төрөл, онцлог хэрэгцээ ихээр нөлөөлж байна. Тухайлбал, боловсрол эзэмшиж буй ХБХ-ийг хөгжлийн бэрхшээлээр нь авч үзвэл хөдөлгөөний болон сонсголын бэрхшээлтэй хүний 50-иас дээш хувь нь боловсрол тодорхой түвшний боловсрол эзэмшиж чадаж байгаа бол оюуны бэрхшээлтэй иргэдийн 30 орчим, харааны бэрхшээлтэй ХБХ-ий 45 орчим хувь нь боловсрол эзэмшсэн байна³². Энэ нь боловсролын салбарын хүртээмжийн асуудалтай буюу мэргэжлийн багш, боловсон хүчний нөөц, сургалтын арга зүй, орчин зэргээс гадна олон нийтийн буюу эцэг, эхийн боловсролын түвшин, хандлагаас хамааралтай байна. Ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тусгай сургуульд хамрагдах шаардлагатай гэх үзэл нь одоог хүртэл бат оршиж байгааг “Сүүлийн үеийн судалгаануудаас харахад монгол багш нар тэгш хамруулах боловсролыг ихэвчлэн бие эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургуульд хамруулах явдал гэж үздэг хэвээр байна. Энэхүү явцуу үзэл нь “согог зүйчид/дефектологчид” хэмээн нэрлэгддэг мэргэжилтнүүд (тусгай боловсролын багш нар)-ийг тифлопедагогика (хараагүй суралцагчдад заах), сурдопедагогика (сонсголгүй суралцагчдад заах), олигофренопедагогика (танин мэдэхүйн бэрхшээлтэй хүүхдүүдэд заах) чиглэлээр бэлтгэдэг байсан Зөвлөлт Холбоот Улсын үеийн тусгай боловсролын

³¹ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦДАГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИД, бүс, аймаг, нийслэлээр

³² Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан

тогтолцооны нөлөөлөл байж болох юм”³³ гэж Азийн хөгжлийн банкнаас хийсэн судалгааны тайланд дурджээ.

Дээр дурдсан шалтгаанаас үүдэн Монгол Улсад ялангуяа алслагдсан хөдөө орон нутгийн болон бага орлоготой өрхийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадахгүй байгаа ба боловсролын байгууллагын шатлал ахих тусам сургууль завсардалт, ялангуяа, хөвгүүдийн хувьд өндөр байгаа³⁴ нь ялгаварлан гадуурхалт, ядуурал, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үр дагаврын суурь болох эрсдэлтэй.


Зураг 2 СӨБ-д хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа³⁵

Зураг 6. СӨБ-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо



Дээрхээс харахад сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн тоо 2022/2023 оны хичээлийн жилд 1498 болж, 2021/2022 оны хичээлийн жилийнхээс 433 (40.7%)-аар өсжээ. Үүнд төрөөс үзүүлж буй боловсролын үйлчилгээ, халамжийн бодлого зэрэг нөлөөтэй байна. Гэвч Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад улсын хэмжээнд тусгай хэрэгцээт боловсролын 7 багш байна³⁶.

Зураг 3 ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагч³⁷



Боловсролын түвшин бүр нь харилцан уялдаатай, нэг нэгнээ дэмжсэн шинж чанартай байх ёстой. Тэгвэл ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоо жил бүр буурч байгаа нь сургалтын байгууллагын хүртээмжгүй байдал, сургалтын хөтөлбөр, багш, мэргэжилтний арга зүй зэрэг олон зүйлээс шалтгаалж байна. Тухайлбал, ЕБС-ийн ажиллагчдын 2024-2025 оны хичээлийн жилийн тайланд³⁸ тусгай боловсрол олгох чиглэлээр мэргэшсэн багшийн тоон судалгааг гаргадаггүй нь боловсролын хүртээмжийг үнэлэхэд учир дутагдалтай байна. Энэ байдал анги өгсөх тусам хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын сурах сонирхол буурч байгаа нь түвшин хоорондын уялдаа сул байгаатай холбоотой.

³³ Монгол Улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь. Азийн хөгжлийн банк. 2020 он. Эх сурвалж: www.irim.mn

³⁴ Боловсрол | UNICEF Монгол

³⁵ Боловсрол, шинжлэх ухаан, оюуны өмч. Салбарын танилцуулга. ҮСХ. 2022 он.

³⁶ Боловсролын яам, сургуулийн өмнөх боловсролын 2024-2025 оны хичээлийн жилийн статистик тайлан. Эх сурвалж: [БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР](#)

³⁷ Мөн тэнд

³⁸ [ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИК ТАЙЛАН.xlsx](#) - Google Хүснэгт

Бага ангид нэг багш ордог тул хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхээ онцлогийг ойлгох, заах арга барилыг нь олоход, мөн хүүхэд багштайгаа ойлголцоход хялбар байдаг. Харин дунд, ахлах ангид хичээлийн тоо 16-18 хүртэл нэмэгддэг, багштайгаа харилцах, ойлголцох хугацаа бага болдог, багш нь хүүхэдтэйгээ хэрхэн харилцах талаар туршлага хуримтлуулах боломж бараг байдаггүй, мөн үзэж буй хичээлийн агуулга ялангуяа оюуны бэрхшээлтэй хүүхдэд хүнд зэргээс шалтгаалан хүүхдийн суралцах, багшийн заах идэвх буурдаг. Иймээс өөрийнх нь ойлгодог, агуулгыг нь дагах боломжтой цөөн тооны хичээлд анхаарч бусад хичээлийг нь бараг орхидог. Гэтэл хичээл заасан багш маань хүүхдээ үнэлэх гэхээр багш, эцэг эх аль алинд нь хүндрэл үүсдэг.

ХБХ-тэй ээжтэй хийсэн ярилцлагаас

ХБХЭТХ-ийн 4 дүгээр бүлэгт ХБХ-ий сурч боловсрох эрхийг хангах эрх зүйн зохицуулалтыг тусгасан байх ба үүнээс хэрэгжилтийн үр дагаврыг нь судлахаар сонгосон 9 заалтын хүрээнд бүх шатны боловсролын байгууллага ХБХ-ий онцлог хэрэгцээнд суурилан сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, зохистой дэмжлэг тусалцаа үзүүлж буй байдал, түүний санхүүжилтийг шийдвэрлэсэн эсэх, мөн багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, дохионы хэлний багш, сэтгэл зүйч, арга зүйчийг сургах, бэлтгэх ажлуудын хэрэгжилтийг үнэлнэ.

ХБХ-ий сурч боловсрох эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлд УИХ-аас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Боловсролын багц хуулиуд болох Боловсролын ерөнхий хууль³⁹, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай⁴⁰, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай⁴¹ болон Дээд боловсролын тухай⁴² хуулиудын шинэчилсэн найруулгыг баталсан нь боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд түлхэц болох чухал үйл явдал гэж үзэж байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн үзэл баримтлалд “Тэгш хамруулах, ялгаатай байдлыг хүндэтгэх – Хэнийг ч орхихгүй байх, суралцагчийн ялгаатай хэрэгцээнд тохируулах боломж, нөхцөлийг хангасан байх, Хүмүүнлэг байх – Суралцагч бүрийн эрхэм чанарыг ойлгох, хүндэтгэх, тэдний эрхийг хангах, хамгаалах хүмүүнлэг үзэл санаанд суурилах” зарчмыг⁴³ суулгахаар тусгажээ. Ялгаатай хэрэгцээ бүхий суралцагчийн сурч боловсрох эрхийг тэгш хангах, хүүхэд хаана амьдарч байгаагаас үл хамаарч боловсролын үйлчилгээ авах адил, тэгш нөхцөл боломж бүрдүүлсэн хууль, эрх зүйн орчин бий болсноор цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнээс үл шалтгаалан боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах боломж, нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусад хүүхэдтэй хамт суралцах, мөн түүнчлэн уян хатан сургалтын төлөвлөгөө, тохируулга бүхий сургалтын хөтөлбөрөөр хичээллэх, шаардлагатай хөгжлийн дэмжлэг авах, сонсголын бэрхшээлтэй суралцагч бичгийн болон дохионы хэлээр, үндэстний цөөнхийн суралцагч бага боловсролыг эх хэл болон цаашид хос хэлээр боловсрол эзэмших боломжтой болсон⁴⁴. Энэ хуулийн хүрээнд оношлох үнэлгээ, хувь хүний сурах, эзэмших арга барилын онцлог ялгаатай арга барилд суурилан тэгш хамран сургах сургалтын хөтөлбөрийн дагуу хувь хүнд тохирсон сургалтаар дамжуулан хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, ялгаатай хэрэгцээг хангасан сургалтын үйл ажиллагаа явуулах тухай тусгасан байна.

ХБ-тэй хүүхдийг тэгш хамруулан сургах асуудлаар гадаадын болон олон улсын донор байгууллагуудын дэмжлэгтэйгээр сүүлийн жилүүдэд эрчимтэй ажиллаж байна. Боловсрол шинжлэх ухааны яамнаас тэгш хамран сургах боловсролын чиглэлээр Жайка олон улсын байгууллагын “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах”, АХБ-ны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Тэгш хамруулах боловсролыг дэмжих”, Дэлхийн боловсролын түншлэл олон

³⁹ БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

⁴⁰ СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ хууль

⁴¹ МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ

⁴² ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

⁴³ Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн үзэл баримтлал. Эх сурвалж: <https://cdn.greensoft.mn/uploads/users/2760/files/76%20үзэл%20баримтлал.pdf>

⁴⁴ Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын Үзэл баримтлал. Эх сурвалж: <https://www.parliament.mn/nr/41197/>

улсын байгууллагын санхүүжилтээр “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл”-ийг хэрэгжүүлж байна⁴⁵.

Өнөөдөр Монгол Улсад улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг тусгай сургалттай зургаан сургууль нийслэлд ажиллаж байгаагийн дөрөв нь (25, 55, 63, 70 дугаар сургуулиуд) оюуны бэрхшээлтэй, 29 дүгээр сургууль сонсголын бэрхшээлтэй, 116 дугаар сургууль харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд тусгай хэрэгцээт хөтөлбөрийн дагуу боловсрол эзэмшүүлж байгаа⁴⁶ бол орон нутагт буюу 21 аймгийн хэмжээнд зөвхөн Дархан-Уул аймагт ХБ-тэй хүүхдэд зориулсан тусгай сургуультай. Эдгээр сургуулиудад тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин ажиллаж байна. Хэдийгээр энгийн сургуулиудад ХБ хүүхдийг тэгш хамруулан сургах талаар 2020 онд ЗГ-ын “Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай” 235 дугаар тогтоол⁴⁷, мөн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам” батлагдсан хэдий ч өнөөг хүртэл бүрэн хэрэгжээгүй байна. Үүнээс харахад ХБ-тэй хүүхэд, ялангуяа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээний гадна орхигдох эрсдэлтэй хэвээр байна.

Шигтгээ⁴⁸

Манай суманд хязгаарлагдмал чадамжтай 15 хүүхэд байдаг. Тэдний гурав нь ЕБС-д сурдаг. Бусад нь тусгай сургууль, мэргэжсэн боловсон хүчин байхгүй тул суралцаж чадахгүй байна. Тухайлбал, сургалтын үйлчилгээ огт авч байгаагүй 15 настай хоёр ч хүүхэд бий. Хараа, хэл яриа болон сонсголын 100 хувь чадамжгүй хүүхдийг ЕБС-ийн ангид суулгах ямар ч нөхцөлгүй шүү дээ. Дээрээс нь сумын дунд сургуулийн анги дүүргэлт ихэссэн. Нөгөөтээгүүр тэдний ихэнх нь амьжиргаа тааруу гэр бүлд амьдарч байна. Эцэг, эх нь дээд боловсролтой гэр бүлийн ганц хоёр хүүхэд л ЕБС-д сурдаг. Архангай аймгийн Жаргалант сумын халамжийн мэргэжилтэн Ц.Зэнэмэдэр

Тусгай хэрэгцээт хүүхдийг жирийн хүүхдүүдтэй хамт байлгах нь маш зөв шийдвэр. Багаасаа амьдралын олон өнгөтэй танилцаж байвал таны хүүхдэд л тустай. Гэхдээ нэгдүгээрт хүний нөөц чухал. Ажиллаж чадах мэргэшсэн багш байж гэмээнэ тэднийг эзнэгшүүлж чадна. Хүүхдүүд бусдыг хэзээ ч ялгаж харьцдаггүй. Хэн ялгадаг вэ гэхээр томчууд. Эцэг эхчүүд том хараад, цэрвээд эхлэхээр хүүхдэд энэ биднээс ялгаатай юм байна гэдэг үзэл сууж эхэлдэг. "Хөөрхөн шар шувуу" сургалт, судалгааны төвийн захирал, боловсрол судлаач, эцэг эхийн дасгалжуулагч Г.Төмөрзаяа

Тусгай хэрэгцээт боловсролын багш, туслах багш, мэргэжилтний дутагдал боловсролын хүртээмжид нөлөөлж байна.

ХБХЭТХ-ийн 16 дугаар зүйлд тусгай хэрэгцээт боловсролын байгууллагад ажиллах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох арга зүй, арга барил эзэмшсэн багш мэргэжилтнийг бэлтгэх тухай заасан бөгөөд хуулийн энэ зохицуулалт мөн хангалтгүй хэрэгжсэн.

Монгол Улс 60 орчим жилийн өмнөөс тусгай хэрэгцээт боловсролын багш нарыг ОХУ, Унгарт бэлтгэж тусгай сургуулиудад ажиллуулж эхэлсэн байна. 1967-1985 онуудад нийт 113 гаруй үндэсний мэргэжилтнийг бэлтгэжээ. Зах зээлийн харилцаанд шилжих нийгмийн шилжилтийн үе, 1993 оноос хойш гадаад оронд төрөөс бодлогын шинжтэйгээр мэргэжилтэн бэлтгэх асуудал үндсэндээ зогссон байна⁴⁹. Тусгай боловсролын багшийг МУБИС, Боловсролын хүрээлэн мөн тусгай сургуульд ажиллаж байгаа хуучнаар ЗХУ-д төгссөн 20 гаруй багшаар дамжин хэрэгжиж байна. Харин тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн багш бэлтгэх сургалтыг 2018 онд дахин эхлүүлж, МУБИС-д Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийг байгуулсан. Мөн 10 оюутныг БШУЯ-наас бодлогоор дэмжин хэлний

⁴⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар Х.Булгантуяа сайд мэдээлэл хийлээ

⁴⁶ Тусгай хэрэгцээт хүүхдүүд оршихын тулд биш хөгжихийн тулд амьдардаг. Эх сурвалж: <https://gogo.mn/r/191y2>

⁴⁷ ЗГ-ын “Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 235 дугаар тогтоол Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16146613159901>

⁴⁸ “ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮҮХДИЙГ ЕБС-Д ТЭГШ ХАМРАН СУРГАХ” ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ БА АСУУДАЛ” хэлэлцүүлэгт оролцогчдын ярилцлагаас Эх сурвалж: <https://gogo.mn/r/191y2>

⁴⁹ Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх хэрэгцээг судалсан нь. Г.Батцэнгэл, дэд профессор, Ч.Байгалмаа, магистр. Боловсрол судлал. Эх сурвалж: [17-LAV-014.pdf](https://gogo.mn/r/191y2)

бэлтгэлд сургаснаас ОХУ-ын Засгийн тэтгэлэгт найман оюутан тэнцээд одоо Москва, Санкт-Петербург, Томск хотод суралцаж байна. Мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай болсон учраас МУБИС-д Тусгай хэрэгцээт боловсролын багшийг 2013 онд нэг жилийн хөрвөх, 2015 онд 3.5 жилийн бакалаврын хөтөлбөр шинээр боловсруулан өөр өөрийн орны мэргэжлийн боловсон хүчний дэмжлэгтэйгээр бэлтгэж ирсэн бөгөөд 2020 оны байдлаар МУБИС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын багшийн нэг жилийн хөрвөх болон 3.5 жилийн бакалаврын ангийг 140 орчим багш төгсөж мэргэжлээрээ ажиллаж байна.⁵⁰ Үүнээс харахад улсын хэмжээнд ЕБС-иудад ажиллаж буй 37,700 гаруй үндсэн багшийн 0,001 хүрэхгүй хувь нь тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшсэн багш байна.

2013 оноос хойш 2025 он хүртэл тусгай хэрэгцээт боловсролын нийт 200 оюутан МУБИС-ийг 3.5 жилийн бакалаврын болон 1 жилийн хөрвөх сургалтаар төгссөн.⁵¹

Тэгш хамран сургах ажлыг 10-аад жилийн өмнөөс эхлүүлсэн боловч 2023 оны байдлаар СӨБ-д 1498, ЕБС-д 5,673 хүүхэд суралцаж буй мэдээлэлтэй харьцуулахад 36 ХБ-тэй хүүхдэд тутамд 1 багш бэлтгэгдсэн байна.

Зураг 4 СӨБ болон ЕБС-д суралцагчдын тоо⁵²

Хүн ам	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусын тоо /2020 оны байдлаар/	Тухайн насны хүн амын хувь	Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам /2022 оны тооцсон/	Боловсролд хамрагдсан суралцагчдын тоо /2022-2023 оны хичээлийн жилд/	Хамран сургалтын хувь
2-5 настай	1,585	0.6%	1,753	1,498	85.4%
6-17 настай	8,209	1.13%	9,012	5,673	63%

Эх сурвалж: Эхний хоёр баганыг “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (2020) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”-судалгаанаас

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн цэцэрлэг, сургуульд тэгш хамруулан сургах бодлого хэрэгжиж эхэлснээ мэргэшсэн тусгай хэрэгцээт боловсролын багшаас гадна цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа бүх багшийг хүүхэд бүрийн хөгжлийн түвшинг тодорхойлж, тэдэнд тохирох дэмжлэг, боловсролын үйлчилгээг үзүүлэх чадвартай болгож энэ чиглэлээр мэргэшүүлэх шаардлагатай. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны “Мэргэжлийн индекс, чиглэл батлах тухай” А/160 дугаар тушаалаар баталсан. Энэ хүрээнд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 1439 цэцэрлэг, 820 сургуулийн багш нараас нэг сургууль, цэцэрлэг дээр нэг багшийг тусгай хэрэгцээт боловсролоор мэргэшүүлэх ажил үргэлжилж байгаа ба энэ салбарт ажиллах хүний нөөц төрөөс дэмжлэг, нэмэгдэл үзүүлж байгаа хэдий ч хомсдолтой хэвээр байгаа нь төрөөс ядаж нэг сургуульд нэг багш бэлтгэх зохицуулалт хийхэд хүргэж байна. Энэ талаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг сайжруулах нь” хэлэлцүүлгээс гарсан дүгнэлтэд “Ялгаатай хэрэгцээг эрт илрүүлснээр таны хүүхэд саадгүй орчин нөхцөл (нэгдсэн ойлголт, эерэг хандлага, дэд бүтэц, хүртээмж, тохируулга, дэмжих үйлчилгээ)-д, өөрт тохирсон арга барилаар суралцах эхлэл тавигдах ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургаж, хөгжүүлэх нь зөвхөн анги удирдсан багшийн асуудал биш, сургуулийн удирдлага, нийт багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, сурагчдын хамтын ажиллагаа”⁵³ болохыг онцолсноос харж болно.

Боловсролын хүрээлэнгээс 2018 онд хийсэн “Үндэсний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт” судалгаагаар судалгаанд хамрагдсан сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй цөөн сурагчдын тухайд хөнгөн хэлбэрийнх тухайлбал, хараа муу, ойлгоц удаан цөөн сурагч байдаг бол оюуны, хэл ярианы, сонсголын бэрхшээлтэй, саажилттай сурагчид бас бий. Эдгээр сурагчидтай ажиллахад сургууль багш нарын бэлэн байдал харилцан адилгүй

⁵⁰ Б.Гэрэлтуяа: Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах багш нарыг мэргэшүүлэх шаардлагатай. 2020. Эх сурвалж: Б.Гэрэлтуяа: Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах багш нарыг мэргэшүүлэх шаардлагатай | Боловсрол, шинжлэх ухааны яам.

⁵¹ Тусгай хэрэгцээт боловсролын багш нарыг бэлтгэж байна

⁵² Боловсролын салбарын 2022 оны төсвийн зарлага болон үр дүнгийн тайлан. 2024 он. UNDP, ILO, FAO. Эх сурвалж: https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2024-02/bolovsrolyn_salbaryn_2022_ony_tosviyn_zarlaga_ur_dungiyn_taylan_final_layout_2024.02.20_1.pdf

⁵³ “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг сайжруулах нь” тандалт судалгааны үр дүнд суурилсан хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа. Эх сурвалж: <http://gadpwd.gov.mn/index.php/news/389>

байгааг дурдсан бөгөөд үүнийг Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн захиалгаар Хараат Бус Судалгааны Хүрээлэнгээс 2018 онд хийсэн “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь: Хэрэгцээ тодорхойлох судалгаа”-гаар мөн нотлогдсон байна. Уг судалгааны тайланд тэгш хамруулан сургах арга зүй “дунд” болон “хангалтгүй” гэж багш нарын 88 хувь нь хариулсан бөгөөд үүнд сургуулийн орчинд тулгарч байгаа олон хүндрэл бэрхшээлүүдээс тэгш хамруулан сургах багш нарын арга зүй, материаллаг орчин, дэд бүтэц, сурах бичиг, тоног төхөөрөмжийн хүрэлцээгүй байдал, эцэг эхийн сөрөг хандлага, сургуулийн бодлого, эрх зүйн орчны дутмаг байдлуудыг илүү их нөлөөлдөг гэсэн судалгааны дүн ч мөн бататгасан байдаг⁵⁴. Харин 2018 оноос хойш энэ байдал хэрхэн өөрчлөгдсөн талаар дахин судлаагүй байна.

Салбар дундын уялдаагүй байдлаас шалтгаалж нэг ХБХ-нд холбогдох асуудлыг салбар бүр өөрийн онцлогт нийцүүлэн судалж, мэдээллийн сан үүсгэж байгаа нь ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр бодлого тодорхойлоход хүндрэл үүсгэж байна.

Тусгай хэрэгцээт боловсрол олгох багш бэлтгэхэд нэн шаардлагатай асуудлын нэг бол ХБ хүүхдийн талаарх статистик мэдээлэл бодитой, тодорхой байх явдал. Гэтэл манай улсад ХБХ-ий статистик мэдээлэл хангалтгүй, ангилал, төрөл нь хэт ерөнхий байна. Иймээс Үндэсний статистикийн хороо, боловсролын удирдлага мэдээллийн системээс захиргааны маягтаар авч буй судалгаа нь зөвхөн хараа, сонсгол, оюуны бэрхшээл, хөдөлгөөн тулах эрхтний бэрхшээл, хэл ярианы бэрхшээл, бусад гэсэн зургаан ангиллын дагуу тоон мэдээлэл цуглуулж боловсруулдаг нь дауны хам шинж, аутизмын хүрээний эмгэг зэрэг оноштой хүүхдийн тоон мэдээлэл гардаггүй, хөгжлийн бэрхшээлийн зэрэг тогтоох боломжгүй байдалтай байгаа нь тусгай хэрэгцээт боловсролын багш, мэргэжилтэн бэлтгэх бодлогод сөргөөр нөлөөлөх юм.

Шигтгээ

Сонсголын болон харааны бэрхшээлтэй хүүхдийг энэ төрлийн бэрхшээлтэй гээд нэгдсэн нэг малгайнд оруулдаг. Иймээс бүрэн хараагүй юу эсхүл сул хараатай, хэдэн хувийн сул хараатай, бүрэн сонсголгүй юу эсхүл сонсголын аппарат, хагалгааны үр дүнд тодорхой хэмжээнд сонсголтой болох боломжтой юу гэж ангилдаггүй. Иймээс хэл ярианы болон сонсголгүй хүүхдүүд 29 дүгээр сургуульд л сурч байна. Тэнд байгаа багш нар нь хөрвөх сургалтаар мэргэжил эзэмшсэн болохоор хичээлээ дохионы хэлээр биш үсгэлэж заадгаас үүдэн хүүхдүүд хоцрогдолд ордог, сурах идэвхгүй болдог, өөрийгөө илэрхийлж чадахгүйгээс болоод уур уцаартай болдог гээд маш олон асуудал дагуулдаг. Монгол дохионы хэлний орчуулагчдын холбоо. Юмжирдулам

Ялангуяа ХБХ-ий асуудал үргэлж салбар дундын уялдаа холбоо шаарддаг боловч төрийн захиргааны байгууллагууд өөрийн салбарын онцлогт нийцсэн маягт, асуулгын дагуу мэдээлэл цуглуулдаг, өөрийн харьяалах асуудлаар судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгүүлдэг зэргээс шалтгаалан салбар салбарын мэдээлэл хоорондоо зөрүүтэй гардаг, харилцан ашиглахад хүндрэлтэй байдаг асуудал үүсдэг.

2016 онд батлагдсан ХБХЭТХ-ийн 4 дүгээр бүлэгт заасан ХБХ-ий сурч боловсрох эрхийг хангах тухай зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Хэдийгээр төрөөс ХБХ-ий сурч боловсрох эрхийг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд анхаарч, 2020 оноос эхлэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчилж байгаа боловч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийг боловсрол эзэмшүүлэх, тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн сурах орчин, сургалтын хөтөлбөр, тохирох хэрэглэгдэхүүн, мэдлэг, арга зүй эзэмшсэн багш, боловсон хүчнээр хангах, тэднийг бэлтгэх ажил удаашралтай байна. Үүнд, хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх журам, аргачлалуудыг боловсруулж, батлах явц удаан, сургалтын байгууллага, ХБХ, тэдний эцэг, эх, асран хамгаалагч, багш мэргэжилтнүүдийн шинэ нөхцөл байдлыг хүлээж авах, түүнд шилжих буюу дасан зохицоход асуудал байхаас гадна төсөв санхүүгийн асуудал ч нөлөөлдөг.

Эрх зүйн орчны хувьд 2016 онд ХБХЭТХ батлагдсанаас хойш ЗГ-аас “тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам”-ыг 2020 оны 97 дугаар тогтоолыг, “Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга

⁵⁴ Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан. 2019 он. Эх сурвалж: [CBR-MN-compressed.pdf](#)

хэмжээний тухай” 2020 оны 235 дугаар тогтоолыг тус тус баталсан бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн, Боловсролыг сайд нар хамтран эсхүл дангаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, маягт шинэчлэн батлах тухай” 2021 оны А/220, А/475, А/812 тушаал, Боловсролын сайд “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал батлах тухай” 2018 оны А155 дугаар тушаал, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”-ыг 2019 оны А/292 дугаар тушаал, “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам”-ыг 2019 оны А/184 дугаар тушаал, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй суралцагчийг үнэлэхэд баримтлах чиглэл”-ийг 2021 оны А/325 дугаар тушаалаар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам”-ыг 2021 оны А/177 дугаар тушаалаар тус тус баталсан байдаг⁵⁵. Үүнээс харахад эрхийн тухай хууль батлагдсанаас хойш түүний хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн журам, аргачлалуудыг боловсруулах ажил 2-4 жилийн дараагаас эхлэж, өнөөдрийг хүртэл үргэлжилж байгааг харуулж байна. Харин УИХ-аас Боловсролын багц хуулиудыг баталж, ХБХ-ий сурч, хөгжих хүртээмжтэй орчин, нөхцөлийг хангах, тэдэнд суралцахуйн дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан нь ХБХ-ий сурч боловсрох эрхийг хангахад ихээхэн түлхэц болно гэж үзэж байгаа бөгөөд холбогдох аргачлал, зааврыг шуурхай батлах нь хуулийн хэрэглээг зөв тогтооход нөлөөлнө гэж үзэж байна.

Дээрхээс харахад ХБХЭТХ-ийн 14, 15, 16 дугаар зүйлд заасан эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, холбогдох журам, аргачлал зэргийг батлах ажил зохих түвшинд хэрэгжиж байна. Харин суралцагчид тохирох орчин бүрдүүлэх, хэрэглэгдэхүүнээр хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургахад шаардлагатай анги, танхимыг тохижуулах ажлыг улсын, орон нутгийн болон боловсролын байгууллагын төсөвт тусгаж, хэрэгжүүлэх ажил хангалтгүй байна. Тодруулбал, донор байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн төслүүдийн хүрээнд нийт 3.0 тэрбум орчим төгрөгийн санхүүжилтээр 26 сургалтын байгууллагын хүртээмжтэй орчинг сайжруулж, хүүхэд хөгжлийн танхимыг шинээр тохижуулсан бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцдаг 2 цэцэрлэг, 6 сургуульд улсын төсвөөр 800.0 сая төгрөгийн санхүүжилтээр тохирох хэрэглэгдэхүүн нэмэгдүүлэх, хүртээмжтэй орчныг сайжруулах арга хэмжээ авчээ⁵⁶. Үүнээс харахад 2024 оны байдлаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 1,407 цэцэрлэг, 885 ерөнхий боловсролын сургуулиас⁵⁷ 26 байгууллагад буюу 0,01 хувийг хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад хүртээмжтэй болгох арга хэмжээ авсан байна.

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох урсгал төсвийн зарлага 2019 онд дунджаар 1,488.6 мянган төгрөг байсан бол 2022 онд 1,865.6 мянган төгрөг болж өссөн. Харин тусгай хэрэгцээт боловсролын байгууллагад суралцаж буй суралцагчид ногдох урсгал төсвийн зарлага дунджаар 7.5 сая төгрөг байна.

Зураг 5 Тусгай хэрэгцээт боловсролын байгууллагад суралцагчийн Урсгал төсвийн зарлагын хэмжээ⁵⁸

⁵⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн актын эмхэтгэл. 2022 он.

⁵⁶ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар Х.Булгантуяа сайд мэдээлэл хийлээ. 2023 он.

⁵⁷ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ТОО, бүс, аймаг, нийслэл, сум, дүүргээр

⁵⁸ https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2024-02/bolovsrolyn_salbaryn_2022_ony_tosviyn_zarlaga_ur_dungiyn_taylan_final_layout_2024.02.20_1.pdf

Байгууллага	Дүүрэг	2022 оны санхүүжсэн суралцагчдын дундаж тоо	Нэг суралцагчид ногдох урсгал төсвийн зарлага /мян.төг/
55-р сургууль /Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй/	Баянзүрх	488	5,689.9
63-р сургууль /Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй/	Хан-уул	283	5,806.3
25-р сургууль /Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй/	Сүхбаатар	194	10,058.5
116-р сургууль / Харааны бэрхшээлтэй/	Сүхбаатар-Яам шууд	129	13,256.5
70-р сургууль /оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй/	Баянгол	318	4,553.0
29- дүгээр сургууль /Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй/	Сүхбаатар-Яам шууд	272	11,474.0
Дундаж		1,684	7,511.9
Стандарт хазайлт			3,281.3

Боловсрол, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаал, “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам”-ын 3-т заасан бөгөөд холбогдох санхүүжилтийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагч, харьяалах төрийн захиргааны төв байгууллага болон тухайн сургалтын байгууллагын хичээл практикийн зардлаас шийдвэрлэхээр тусгасан. Гэхдээ нийт төсвийн хэдэн хувийг энэ чиглэлд зарцуулах тухай тодорхой заагаагүй, санхүүжилтийн үр нөлөөг тооцдоггүй зэрэг тогтолцооны шинжтэй асуудлууд хүртээмжтэй орчин бүрдүүлэх ажил боловсролын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай нүүр тулах хүртэл тодорхой хөрөнгө оруулахгүй байхад нөлөөлж байна. Мөн боловсролын салбарын төсвийн гүйцэтгэлийн тайланд тэгш хамран сургахтай холбоотой үүссэн зардлын тооцооллыг СӨБ, ЕБС-ийн болон их, дээд сургуулийн түвшинд ч тооцож гаргаагүй байна. Үүний үр дүнд ХБ-тэй суралцагч сургуульд элссэний дараа тохирох орчин, хэрэглэгдэхүүнтэй болох хүртэл хугацаанд сурлагын хоцрогдолд орох өндөр эрсдэл үүсгэж болзошгүй юм. Иймээс боловсролын салбарт хуваарилах төсвийн ангилалд ХБХ-ий сурч боловсрох эрхийг хангахад чиглэсэн төсвийг бие даасан ангилал болгон тусад нь тусгаж хэрэгжилтийн талаарх мэдээллийг тайлагнадаг байх шаардлагатай байна.

ХБХ-ий сурч боловсрох эрхийг хангахтай холбоотой хуулийн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж үзэхэд хууль батлагдсанаас хойших 8 жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалт бага, сургууль завсардалт өндөр, боловсролын хүртээмж хөдөө орон нутагт хоттой харьцуулахад бага, тусгай хэрэгцээт боловсролын сургалтын материал, орчин хомс, дээд боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал хэвээр байгаа нь тулгамдсан асуудал байна. Хэдийгээр эрх зүйн орчин боловсронгуй болж байгаа боловч багш, мэргэжилтний дутагдал, төсөв санхүүжилтийн тодорхойгүй байдал, ХБХ гэрээсээ боловсролын сургалтын байгууллагад хүрэх, суралцахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ тодорхойгүй байхаас гадна эцэг эх, асран хамгаалагчийн амьжиргааны болон боловсролын түвшин, хот, хөдөөгийн ялгаа зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан ХБ-тэй хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөх, сургууль завсардах асуудал байсаар байна. Ийнхүү ХБХ-ий боловсролын хүртээмж, хамрагдалт хангалтгүй хэвээр байгаа нь тэдний хөдөлмөр эрхлэлт, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байна. Иймээс боловсролын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хүртээмжтэй орчин бүрдүүлэх, тусгай хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөр боловсруулах, багш нарын чадавхыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх


Хүснэгт 4 17, 18 дугаар зүйлийн холбогдох заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томьёолол
	17 дугаар зүйл	Хөдөлмөрлөх эрх	
1	17.3.	Төрийн байгууллага, иргэн, хуулийн	Хөдөлмөрийн тухай хуулийн

		этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн ажлын байрыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу бий болгож ажиллуулах үүрэгтэй.	144 дүгээр зүйлийн хэрэгжилт хангагдсан байна.
	18 дугаар зүйл	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг төрөөс дэмжих	
		18.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтэд төрөөс дараах дэмжлэг үзүүлнэ: 18.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байр бий болгохыг урамшуулах; 18.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх чадварт тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байр бий болгох, тэдгээрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төсвийн хөрөнгөөр хийх худалдан авалтад тэргүүн элжинд хамруулах; 18.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүн мэргэжлээрээ ажиллахад шаардагдах ажлын багаж, тоног төхөөрөмж, материал болон бусад шаардлагатай хэрэгслийг худалдан авахад нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг удаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх; 18.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд мэргэжлийн ур чадварын тэмцээн зохион байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх; 18.1.5.мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох ба урамшуулал олгох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах; 18.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сургалтын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх.	

2024 оны байдлаар улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 111,200 иргэн бүртгэгдсэн нь нийт хүн амын 3.4 хувийг эзэлж байгаа ба тэдний 84 хувь буюу 93 мянга нь хөдөлмөрийн насных⁵⁹ хэдий ч 15,300 хүн ажил эрхэлж байгаа нь нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 13.8 хувийг бүрдүүлж байна. Тэгвэл ҮСХ-ноос гаргасан Ажиллах хүчний судалгааны 2024 оны 3 дугаар улирлын дүнгээр улсын хэмжээнд хөдөлмөрийн насны буюу 15, түүнээс дээш насны 2.3 сая хүн байгаагаас 1,448,4 мянга буюу 63 хувь нь ажиллах хүч байх ба тэдгээрийн 93,6 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэг бол 6,1 хувь нь ажилгүй иргэд байна.⁶⁰.

График 7 Хөдөлмөр эрхлэлтийн байдал 2023 оны байдлаар



Дээрхээс харахад улсын хэмжээнд ажиллах хүчний 93,6 хувь нь буюу 1,360 гаруй мянган хүн ямар нэг ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол хөгжлийн бэрхшээлтэй, 15-аас дээш насны 100 мянга гаруй хүний⁶¹ 0,15 хувь нь ямар нэг хөдөлмөр эрхэлдэг байна. Ерөнхийдөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 80 гаруй хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй байдал тогтмол ажиглагддаг. Ажиллаж буй ХБХ-ий дийлэнх нь сонсголын (23,5%), харааны (19%), хэл ярианы (16%) бэрхшээлтэй иргэд байгаа бол оюуны бэрхшээлтэй хүн цалинтай ажлын

⁵⁹ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлого, шийдвэр, үйл ажиллагааг бүх талаар дэмжинэ - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар 2024.

⁶⁰ Хөдөлмөрийн зах зээлийн тойм. 2024 оны III улирал. ГБХНХЯ.

⁶¹ ХБХ-ий дунд эзлэх 0-15 насны хүүхдийн тоо дунджаар 10 мянга орчим байдаг.

байранд хамгийн цөөн ажилладаг бол ХБХ-ий 50 гаруй хувьд нь цалинтай ажил хийдэг бол 28 хувь нь мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа нь дийлэнх хувийг эзэлдэг байна.

Төрөөс “халамжаас хөдөлмөрт” бодлого баримталж, зохистой хөдөлмөрийг дэмжих замаар ядуурлыг бууруулах, ХБХ-ий чадамжид тохирсон ажлын байрыг бий болгохыг зорьж байгаа боловч зах зээлийн нийгэмд ажил олгогчид ХБХ ажиллуулахаас илүү хууль тогтоомжид заасан төлбөрийг төлөх нь ажлын байрны тохируулга хийх, шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангахад зарцуулах хөрөнгөөс гадна ажлын байранд үүсч болох зөрчилдөөн, эрсдэлээс хамгаалах боломж болж байна.

Шигтгээ

Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн онцлог нь ажилтан байнга иртэй, шөвх, хурц хутга, техниктэй харьцдаг, хүйтэн, чийгтэй орчинд ажилладаг. Бид хүний эрхийг хангах зорилгоор сонсголын бэрхшээлтэй хүн ажилд авч байсан. Гэвч үйлдвэрийн ажилтнууд дохионы хэл мэдэхгүйгээс болж зөрчилдөөн үүсэх, яаралтай тохиолдолд хэл авалцаагүйгээс болж үйлдвэрлэлийн дамжлагад доголдол гарах гээд олон асуудал үүссэн учраас тэр хүн удалгүй ажлаасаа гарсан. ХБХ-нд ажил олгоход үйл ажиллагаа явуулж буй салбар, ажлын орчин маш их нөлөөлдгийг мэдэрсэн.

Траст трейд ХХК-ийн удирдах ажилтантай хийсэн ярилцлагаас⁶²

Эрх зүйн орчны тухайд Монгол Улс хүний эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах, хөдөлмөрлөх эрхийг дэмжих чиглэлээр Хүний эрхийн түгээмэл тунхаглал, I ба II дугаар пакт, Алагчлахгүй байх /ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлт/ тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц, Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 159 дүгээр конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай 61 дүгээр конвенц зэрэг нийт 15 олон улсын баримт бичигт нэгдэн орсон байна. Үүнээс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дугаар конвенцод хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олох, ажлын байраа хадгалах, ахиж дэвших адил боломж олгох, тэгш хандах, тухайн ажил нь өөрийн сонголтод нийцэж, хувь хүний боломж чадварыг харгалзсан байх зэрэг нийтлэг хэм хэмжээг заасан байдаг. Түүнчлэн тус конвенцод мэргэжлийн нөхөн сэргээлтэд хамруулах, хөдөлмөрийн зах зээлд нээлттэй оролцуулах, хөдөлмөр эрхлэлт, нөхөн сэргээлтийн дэд бүтцийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын цагийг богиносгох, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг татвар, бусад төлбөрөөс чөлөөлөх, мэдээлэл хүргэх, тэднийг дэмжихэд чиглэсэн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, багш нарыг бэлтгэх, давтан сургах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг гишүүн орнуудад зөвлөсөн. Конвенцын дагуу Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг эдлүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил хийгдэж байна. Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн халамжийн тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай зэрэг хэд хэдэн хууль, тогтоомжид тусгалаа олж батлагдсан.

Үүнд ХБХ-д хөдөлмөрийн зах зээл, ажлын байранд тэгш боломж олгох, хүртээмжтэй орчныг бүрдүүлэх зохицуулалтыг тусгахаас гадна хүртээмжтэй, тохируулгат ажлын байр бий болгосон ажил олгогч, ХБХ-д үзүүлэх хөнгөлөлт, урамшуулал, чөлөөлөлт, дэмжлэгийн талаар тусгасан байдаг. Тухайлбал, 2022 онд шинэчлэн баталсан Хөдөлмөрийн тухай хуульд ажил олгогчид ажил горилогчийг хөгжлийн бэрхшээлтэй байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглосон⁶³, тэгш боломж олгосон заалт оруулснаас гадна ажил олгогч ХБ-тэй ажилтанд тохирсон ажлын нөхцөл, орчныг бүрдүүлэх, ээлжийн амралтын хугацаа 20 хоног байх⁶⁴, ажлын богиносгосон цагаар ажиллуулах үүрэг хүлээлгэсэн. Мөн ХБХ болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан ажил олгогчийг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх зохицуулалтыг оруулжээ. Мөн хуулийн 144 дүгээр зүйлд ХБХ-ий хөдөлмөр

⁶² “Бизнес ба хүний эрх Азийн хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн “Хүний эрхийн магадлан шинжилгээ”-ний үр нөлөө судалгааны тайлан. 2024 он.

⁶³ ⁶³ Хөдөлмөрийн тухай хуулийн 6.1 дэх заалт. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751>

⁶⁴ Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4 дэх заалт

эрхлэлтийг дэмжих зохицуулалтыг тусгаж өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулахаар квот тогтоосон. Энэ шаардлагыг хангаагүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлөх үүргийг хүлээлгэсэн. Гэвч ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээ нэмэгдэхгүй байна. Тухайлбал, төр өөрөө хуулиа хэрэгжүүлэхгүй байна.

Шигтгээ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2021 онд хийсэн судалгаагаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийгмийн даатгалын санд бүртгэлтэй 25-аас дээш ажилтантай 6.5 мянган байгууллагаас судалгаанд хамрагдсан 3.2 мянган байгууллага 9.6 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаас 7.2 мянга гаруй иргэн ажиллуулж байгаа нь хуулийн хэрэгжилт аж ахуйн нэгж, байгууллагад 61 хувь, төрийн байгууллагад 59 хувийн хэрэгжилттэй байна гэсэн дүгнэлт гарсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяагийн танилцуулгаас⁶⁵

Тэгвэл 2023 оны байдлаар төрийн албанд 226,496 хүн ажиллаж⁶⁶ байгаагаас 4554 нь ХБХ байна⁶⁷. Энэ нь Хөдөлмөрийн хуульд заасан квотын дагуу төрийн албанд хамгийн багадаа 9,060 ХБХ ажиллахаас 50 хувийн хэрэгжилттэй байгааг харуулж байна. Энэ өмнөх статистиктай харьцуулахад буурсан хэмжээтэй байна. Иймээс төр өөрөө хуулиа хэрэгжүүлж хувийн хэвшлийн байгууллагуудад үлгэр үзүүлэх нэн шаардлагатай байна.

Шигтгээ

Өнөөдөр Монгол Улсад 12 мянга орчим харааны бэрхшээлтэй иргэн байгаагаас эхний элжинд хөдөлмөр эрхлэх боломжтой 300 гаруй иргэн байдаг байна. Бид хараагүй иргэдээ дэмжих зорилгоор дэргэдээ мэргэжлийн боловсрол олгох сургууль, “Нарны хаан хүүхдүүд” цэцэрлэгээр дамжуулан мэргэжлийн болон сургуулийн өмнөх боловсролыг олгож байна. Түүнчлэн Бест массаж 1 болон 3 төв, Кофе шоп, Бест ФМ зэрэг ажлын байруудыг бий болгон ажиллаж байна. Гэвч энэ хангалтгүй байна. Ажил олгогчид Хөдөлмөрийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангах зорилгоор тусгасан хуулийн зохицуулалтыг бодит амьдрал дээр хэрэгжүүлэхгүй, хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлгүй байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх, өөрийн гэсэн орлоготой байхад сөргөөр нөлөөлж, сэтгэл санааны болон эдийн засгийн хувьд халамжлуулагч болгож байгаа нь харамсалтай байна.

МХҮХ-ны ЕНБД Ч.Очиррэнчинтэй хийсэн ярилцлагаас⁶⁸

Дээрхээс харахад 2020-2025 оны хооронд Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо нэмэгдэж, тэдний хөдөлмөр эрхлэлт, боловсролын хүртээмж, нийгмийн халамжийн үйлчилгээ зэрэг олон чиглэлд ахиц гарсан ч зарим асуудлууд хэвээр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх хүрээнд Монгол Улсын ЗГ-ын 2017 оны 321 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг баталж, 2018-2022 онд хэрэгжүүлсэн. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, эргэн төлөгдөх санхүүгийн

⁶⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар Х.Булгантуяа сайд мэдээлэл хийлээ, 2023.11.03

⁶⁶ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД. Эх сурвалж:

https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_3300_2024052&T1_select_all=0&T1SingleSelect=_1&T2_select_all=0&T2SingleSelect=_1&T3_select_all=0&T3SingleSelect=_1&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2023&viewtype=table


⁶⁷ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоо” үндэсний чуулган. УИХ-ын гишүүн О.Саранчулууны илтгэлээс. 2024.11.29. Төрийн ордон

⁶⁸ Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооноос 2022 онд НҮБХХ-ийн “Бизнес ба хүний эрх” төслийн хүрээнд хөдөлмөр эрхлэх, ажлын байртай байх, цаашлаад амьдралын идэвхтэй байхад дэмжлэг үзүүлэх зорилгоор ажил олгогчдод зориулсан гарын авлага боловсруулж түгээх, хараагүй болон сул хараатай иргэдийг ажлын байранд зуучлах, дадлагуулахад ажилтан, ажил олгогчид дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлсэн туршлагаас.

дэмжлэг олгох, борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх, аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн. 2023 оноос Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг баталсан байна.


Засгийн газар болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, амьдралын чанарыг сайжруулах чиглэлээр олон арга хэмжээ хэрэгжүүлсэн, ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хөдөлмөр, нийгмийн халамж, татварын хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхтэй холбоотой бодлого, хууль тогтоомжийг баталсан. Гэвч хувийн хэвшлийн ажил олгогчоос ХБХ-д ажлын байр бий болгох хүсэл эрмэлзлийг өдөөх түвшинд нөлөөлдөггүй, харин тухайн ажил олгогчийн нийгмийн хариуцлагад илүү суурилсан байгаа нь ХБХ-ий ажил эрхлэлтийн түвшин бага, боловсролын хүртээмж хязгаарлагдмал зэрэг асуудлуудад цаашид ч илүү анхаарал хандуулж шийдвэрлэх шаардлагатайг харуулж байна.

Зураг 6 ХБХ хөдөлмөр эрхлэхэд тулгамдаж буй асуудал 2021 онд⁶⁹



2021 онд Эгүүр.мн хэвлэл мэдээллийн байгууллагаас 184 ХБХ-ий дунд явуулсан судалгаагаар ХБХ ажил хөдөлмөр эрхлэхэд хүндрэл үүсгэж буй шалтгааныг тодорүүлсан байх ба хамгийн эхэнд ажлын байрны олдоц муу, ажилтнуудын сөрөг харилцаа хандлага, ажлын цагийн нөхцөл тохиромжгүй шалтгаанууд тэргүүлж байна. Энэ нь 2018 онд Европын Ардчиллын Холбоо, Тэгш нийгэм ТББ-ын "Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн эрхийг үнэлэх" төслийн тайланд дурдсан шалтгаан өөрчлөгдөөгүй болохыг харуулж байна.

Зураг 7 ХБХ хөдөлмөр эрхлэхэд тулгамдаж буй асуудал 2018 онд⁷⁰



Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлбөр төлсөн хэмжээг авч үзвэл 2020 онд хамгийн өндөр дүнтэй төлбөр төлсөн байна.

⁶⁹ ХӨНДӨХ СЭДЭВ: Хөдөлмөрлөх чин хүсэлтэй ч ажлын талбараас гадуурхагдсаар буй Хөгжлийн бэрхшээлтэй иргэд - Eguur.MN


⁷⁰ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН. 2018. Д.Сүнжид

График 8 Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлсөн төлбөрийн хэмжээ



Харин ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангаас ХБХ-нийг ажлын байраар хангахад төлөвлөсөн хөрөнгө, зарцуулалтыг сүүлийн 5 жилээр харьцуулахыг зорьсон боловч зөвхөн 2021, 2022 оны аудитын тайланд эл асуудал тусгагдсан байна.

График 9 ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас зарцуулсан санхүүжилт ⁷¹



Хөдөлмөрийн зах зээлийн тойм судалгаанаас харахад Хөдөлмөрийн биржид 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 74 мянган ажлын байрны захиалга ирснээс 18,6 мянган хүнийг ажлын байранд зуучилж, нийт хөдөлмөрийн эрэлтийн 25,1 хувийг хангасан байна. Үүнээс хэдэн хувь нь ХБХ болох талаар судалгаа байсангүй. Гэхдээ бүртгэлтэй ажил хайгч 7178 хүний 2,6 хувь болох 186 нь ХБХ байжээ.

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 2024 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 4 үйл ажиллагаа, 25 арга хэмжээг хэрэгжүүлж, 50 тэрбум төгрөгийг зарцуулснаас 6,083.1 сая төгрөг буюу 13,23 хувийг 2,016 ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зарцуулснаас 85,3 хувийг санхүүгийн дэмжлэг хэлбэрээр олгосон байна. Үүнээс харахад нэг ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд төрөөс дунджаар 3 сая төгрөг зарцуулж байгаагаас 2,5 сая гаруй төгрөгийг дэмжлэг болгон өгдөг байна. Харин эдгээр дэмжлэгийн үр дүнд байнгын ажлын байртай болсон, эсхүл ажлын байраа тогтвортой хадгалсан эсэх, мэргэжил, ур чадвар дээшилсэн эсэх, орлогоо нэмэгдүүлж эдийн засгийн хувьд бусдаас хараат бус болоход бодит дэмжлэг болсон эсэхэд тавих хяналт сул, үр дүнг үнэлдэггүй байдал нь

⁷¹ Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2017-2022 оны үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт
Эх сурвалж: <https://mlsp.gov.mn/content/detail/3011>

төрөөс үзүүлж буй дэмжлэгийн төрөл, хэмжээ зохистой хэлбэрээр хэрэгжиж байгаа эсэх, цаашид энэ чиглэлээр бодлогын өөрчлөлт хийх шаардлагатай эсэхийг тодорхойлоход хүндрэл үүсгэж байна.

ХБХ цалинтай ажлын байранд ажиллах сонирхол өндөр байх магадлалтай бөгөөд энэ нь тохируулгатай ажлын байрыг дэмжих, ажлын байранд дадлагуулах, сургах хэрэгцээг тодорхойлж байна. ХНХЯ “Жайка” олон улсын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөлтэй хамтран 2022 оноос эхлэн ажлын байрны дадлагуулагчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба Ажлын байрны дадлагуулагч нь ХБХ-ийг ажлын байранд зуучлах, ажлын байранд нь тогтвортой ажиллуулахын тулд ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу дэмжлэг үзүүлдэг. Мөн ажил олгогч байгууллагад хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн сургалт явуулдаг байна⁷².

2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоо” үндэсний чуулганд тавьсан илтгэлүүдэд ч мөн адил ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зөвхөн хүртээмжтэй ажлын байр бий болгохоос гадна тэднийг ажлын байранд дадлагуулах, ажлын байранд болон хувийн туслахын үйлчилгээг сайжруулах замаар “гэр-ажил” хооронд үүсэж буй хүндрэлүүдийг арилгах шаардлагатай болохыг онцолж байв. Төрөөс энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хөдөлмөр эрхлэлтийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энэ хүрээнд ажил олгогчид ажлын байрны тохируулга хийх замаар ХБХ-ийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллуулах, ажлын байрны дадлагуулагч бэлтгэх асуудалд анхаарч 2024 онд 242 ажлын байрны дадлагуулагч, 16 трэйнэр багш бэлтгэсэн байна. Мөн ХБХ-ийг мэргэжлийн болон давтан сургалтад хамруулах, хувийн туслах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж, 2024 онд 123 хүнд 11,231 цагийн үйлчилгээ үзүүлэхэд 15,702 сая төгрөгийг зарцуулсан тухай тайлагнасан⁷³. Үндсэндээ 2021-2024 онд 6 багц арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд 14,418 хүн хамруулж 31,7 тэрбум төгрөг зарцуулжээ.

ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн зэрэгцээ ХБХ-ий дам нөлөөлөлд байгаа гэр бүл, асран хамгаалагчдад боловсрол олгох, хөдөлмөрлөх боломжоор хангах нь ХБХ-ний хүрээлэлд байгаа 250 гаруй мянган хүний хандлага, ойлголт, боломжийг өөрчлөх, тэднийг ядуурлаас гаргах, ая таатай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй.

ХБХЭТХ-ийн 17, 18 дугаар зүйлийн хэрэгжилтийн нэгтгэж үзвэл, ХБХ-ийг ажлын байраар хангах, түүний онцлог хэрэгцээнд нийцсэн тохируулгат орчин бүрдүүлэх ажил хангалтгүй байна. Үүнд ХБХ-ий боловсрол, мэргэжил эзэмшсэн байдлаас ажлын байрны олдоц муу, ажил олгогч, ажилтнуудын ойлголт, хандлага сөрөг байгаа нь нөлөөлж байна. Хэдийгээр Хөдөлмөрийн тухай болон холбогдох бусад хууль, тогтоомжоор ХБХ-ийг ажлын байраар хангах квот тогтоох, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээ авч байгаа ч үр дүн хангалтгүй байгааг төрийн байгууллагууд ажиллуулбал зохих ХБХ-ий 50 хувьд буюу 4554 хүнд ажил олгож байгаагаас, мөн хувийн хэвшлийн байгууллагууд ХБХ ажиллуулснаас төлбөрөө төлөөд явах нь илүү хялбар гэж үзэж байгаагаас харж болно. Иймээс төр өөрөө энэ чиглэлээр бусдаа манлайлж хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагатай байхаас гадна хуулийн хариуцлага тодорхой, гарцаагүй байх шаардлагатай юм.

Төрөөс ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийг тасралтгүй, харилцан уялдаатай хэрэгжүүлэх, үр дүнг тодорхой хугацаанд үнэлж, дараагийн шатны төлөвлөлт хийдэг байх шаардлагатай байна. Тухайлбал, ЗГ-аас 2017 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн үр дүнгийн талаар мэдээлэл байхгүй, зөвхөн статистик мэдээгээр хэмжиж байгаа нь учир дутагдалтай байна.

ХБХ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, санхүүжилтийн талаар нэгдсэн мэдээлэл, статистик байхгүй, хөдөлмөрлөх чадвартай ХБХ-ий талаар тодорхой судалгаагүй байгаа нь салбарын албан тушаалтнуудын олон нийтэд хүргэж буй тоо мэдээлэл, статистик зөрүүтэй, цаг хугацааны хувьд үргэлжилсэн байдал хангагдаагүй, энэ тэндээс аль нэг асуудлыг онцолж, тоо мэдээлэл цуглуулдаг байдлаас

⁷² У.Сосорбурам: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд салбар дундын уялдааг сайжруулах шаардлагатай

⁷³ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоо” үндэсний чуулган. ГБХНХСайд Л.Энх-Амгалангийн илтгэлээс. 2024.11.29. Төрийн ордон

харж болно. Иймээс ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын үр дүнг үнэлэх аргачлал, мэдээллийн санг бий болгох замаар хэтийн бодлого төлөвлөлтийн чанар, үр дүнг сайжруулах боломжтой байна. Үр дүнд нь ХБХ аль цаг үед буюу аль нэг нам, улс төрийн бодлого, нөлөөллөөс ангид, бусадтай адил ажил хөдөлмөр эрхэлж, эдийн засгаа бэхжүүлэх нөхцөлийг тасралтгүй бүрдүүлэхийн сацуу өнөөгийн хөдөлмөрийн насны ХБХ-ий 0,1 ажил эрхэлж буй байдлыг өөрчлөх боломжтой. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарч давхар ялгаварлан гадуурхалтад өртөж буй оюуны бэрхшээлтэй иргэдийн асуудлыг ч мөн хөндөх цаг ирсэн байна. ХБХ ямар хөдөлмөр эрхлэх боломжтой болохыг тогтоосны үндсэн дээр түүнд тохирох ажлын байрыг бий болгох, хэрэглэгдэхүүнээр хангах, сургалтад хамруулах, цаашид ямар төрлийн бэрхшээлтэй иргэд илүү хөдөлмөрийн зах зээлд гарах боломжтой эсэхийг судалсны үндсэн дээр энэ төрлийн ажлын байрыг бодлогоор дэмжих асуудал яригдах ёстой атал өнөөдөр жишээ нь, харааны бэрхшээлтэй иргэдийн хэдэн хувь нь бүрэн, эсхүл ямар хэмжээнд сул хараатай болохыг харуулах судалгаа байхгүй, аутизм, даун зэрэг оюуны бэрхшээлтэй иргэдийн хэдэн хувь нь ажлын байранд сургаснаар хөдөлмөр эрхлэх боломжтой болох тодорхойгүй, оюуны бэрхшээлтэй хүмүүсийг дорд үздэг, нийгэм тэр аяараа тэднээс айдаг хандлага өөрчлөгдөөгүй байна.

Дээрхээс харахад ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь зөвхөн ажлын байр бий болгох, хадгалахад дэмжлэг үзүүлэхээс илүү цогц байдлаар хэрэгжих шаардлагатай юм. Тухайлбал, ХБХ гэрээсээ ажлын байрандаа очих хүртэл орчны хүртээмжийн асуудал, ажлын байранд бол тохируулгатай ажлын байрыг дэмжих, ажлын байранд дадлагажуулах, сургах, эрүүл мэндийн байдалд тохирсон уян хатан нөхцөлөөр хангах гээд ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний асуудал давхар шийдэгдэхгүйгээр хөдөлмөрийн таатай нөхцөл бүрдэхгүй байгааг өнгөрсөн хугацааны туршлага харуулж байна. Энэ байдлыг өөрчлөхөд хөндлөнгийн дэмжлэг буюу төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын үүрэг оролцоог нэмэгдүүлж төсөв, санхүүжилт, үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих, сургалт, нөлөөллийн ажил хийлгэх зэргээр иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлж төрөөс ХБХ-д зарцуулж буй санхүүжилт, үйл ажиллагааны үр дүнг ил тод, нээлттэй болгох шаардлагатай.

Түүнчлэн ХБХ-ий эрхийн асуудал олон салбарын хамтын ажиллагаа шаардсан асуудал болохын хувьд ХБХ-ий асуудал хариуцсан байгууллагуудын үүрэг, оролцоог тодорхой болгох, хувийн хэвшилд төдийгүй төрийн байгууллагуудын ажилтан албан хаагчдын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, харилцаанд анхаарах шаардлагатай байна. ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд төрийн бүх түвшний байгууллага үүрэг хүлээдэг ч үйл ажиллагааны уялдаагүй байдал үндсэн зорилго биеллээ олоход сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, УИХ, Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бодлого боловсруулах, түүнийг хууль, журам хэлбэрээр батлах, баталсан хууль, эрх зүйн хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй бол Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар батлагдсан төсөл, хөтөлбөр, хууль тогтоомжийг иргэнд хүргэх, мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг хариуцах бөгөөд аймаг, нийслэл, сум, дүүрэг бүх түвшинд өөрийн алба буюу ажилтнаар дамжуулан хэрэгжүүлэх ба энэ харилцаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ ба Засаг дарга гээд эдгээр төрийн институт хоорондын хамтын ажиллагааг уялдуулах, холбогдох нөөцийг бүрэн ашиглаж, үр дүнтэй зохицуулах хэрэгцээ, шаардлага байна.

Эцэст нь, хөгжлийн бэрхшээлийн тархалт ихэсч байгаа учир ойрын жилүүдэд энэ асуудал бүх нийтийн анхаарлын төвд байх болно. Энэ нь хүн амын насжилт өндөрсөж, үүнээс үүдэн чихрийн шижин, зүрх судасны өвчин, хавдар, сэтгэцийн өвчин зэрэг эрүүл мэндийн архагшсан нөхцөл байдал газар авч, сэтгэцийн эмгэг, мэдрэлийн өвчин, гэмтэл согогийн өвчин, нүдний өвчин нь хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх шалтгаан болж байгаа ба 2019 онд бүртгэгдсэн хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн 76.01 хувийг эзэлсэн⁷⁴ бол хүн амын дунд цус ойртолтын түвшин нэмэгдэж байгаагаар холбоотой бусад асуудал ч үүсэх төлөвтэй байна.

Иймээс цаашид холбогдох хууль тогтоомжийг цаг үеийн шаардлагад нийцүүлэх шинэчилж, нийгмийн халамжийн бодлогын хүрээнд ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжих, хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх шинэ үйлчилгээг бий болгох, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг

⁷⁴ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АСУУДАЛ: БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА 2020. Эх сурвалж [hbi_nom2020.pdf](#)

үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, ХБХ-ий мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, ажилд зуучлах үйлчилгээг сайжруулах, үүнд тэдний эрх ашгийн төлөөх төрийн бус байгууллагыг татан оролцуулахад анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай зэрэг хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй даатгуулагчид олгох ажилгүйдлийн даатгалын хэмжээ, олгох хугацаа, ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлт зэргийг ХБХ-нд ээлтэй байдлаар тусгаснаар ХБХ ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд дараагийн ажил олтлоо эдийн засаг, сэтгэлзүйн хувьд дарамтад орохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Мөн Хөгжлийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх, ХБХ-ий эрүүл мэндийн байдлыг тогтмол хянах, эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах тусламж, үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар нийгмийн бүхий л түвшинд тэдний оролцоог нэмэгдүүлж, боловсрол эзэмшүүлж, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

2.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах тухай хуулийн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх

Хүснэгт 5 20 дугаар зүйлийн холбогдох заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
	20 дугаар зүйл	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	
1	20.1.	Төрөөс хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Төрөөс хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлсэн байна.
	20.2	Эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.	ХБХ өөрийн онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр эрүүл мэндийн үйлчилгээ авдаг байна.


Олон улсын эрх зүйн баримт бичгүүд болох Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт гээд Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцод иргэдийн эдийн засаг, оршин суугаа газар зэргээс үл хамааран эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээг эрх тэгш авах эрхийн талаар, төрөөс энэхүү боломж, нөхцөлийг бүрдүүлэх талаар тусгасан байдаг. Тэгвэл Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6-д иргэн бүр “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно” гэж заасан бөгөөд Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай гээд хүний эрүүл мэндийг хамгаалах тусламж, үйлчилгээтэй холбоотой 10 гаруй хууль, эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг тусгасан 30 гаруй хууль мөрдөгдөж байна. Цаашлаад ХБХ-ий тухайд ХБХЭТХ, Нийгмийн халамжийн тухай хуулиудад ХБХ-ий эрүүл мэндийн, тусламж үйлчилгээтэй холбоотой зохицуулалтууд орсон байдаг. эрүүл мэндийн, тусламж үйлчилгээ, сэргээн засах, нөхөн сэргээх, шаардлагатай туслах хэрэгсэл зэрэг ХБХ-д холбогдох цөөнгүй дүрэм, журам, стандартуудыг боловсруулсан боловч Нэгдсэн үндэстний байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилт-2030 баримт бичигт тусгасан “Хүн бүр чанартай эрүүл мэндийн үйлчилгээг хэрэгцээтэй үедээ хаана амьдарч байгаагаас үл хамааран, санхүүгийн хүндрэлгүйгээр авах боломжтой байх” зорилгын хүрээнд ХБХ өөрт ойр байршилд эрүүл мэндийн, тусламж үйлчилгээ авах эрхийн хэрэгжилт төдийлөн хангагдахгүй байна. Үүнийг дараах хэд хэдэн шалтгаантай холбож болно.

Хөгжлийн бэрхшээлийг эрт үед илрүүлэх нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг. Энэ үйл явц нь эмч, эмнэлгийн байгууллагаас гадна эцэг, эхийн оролцооноос ихээхэн хамааралтай. Манай улс эрт илрүүлгийн үр дүнг сайжруулах зорилгоор жирэмсний хяналт, нярайн тандалт шинжилгээ, хүүхдийн ягаан дэвтрээр дамжуулан хүүхдийн хөгжлийг хэмжих, дархлаажуулалтад хамруулах зэрэг цөөнгүй арга хэмжээ авч байгаа ч хүн амд эзлэх ХБХ-ий тоонд дорвитой өөрчлөлт гарахгүй байна. Ялангуяа, сүүлийн жилүүдэд тархины саажилт болон оюуны бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэх хандлагатай байна. Энэхүү үнэлгээний эхэнд ХБХ-ий тоог хөгжлийн бэрхшээлийн төрлөөр авч үзвэл хөдөлгөөний, сэтгэцийн болон бусад бэрхшээлтэй хүмүүс нийт ХБХ-ий 72 хувийг эзэлж байгаа нь цаашид анхаарах шаардлагатай асуудлын нэг болж байна. Оюуны бэрхшээлтэй иргэдийн тоо жил бүр нэмэгдэж байгаа бол бусад, хэл, яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн тоо буурах хандлагатай байгаа тухай, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо цаашид нэмэгдэхэд цус ойртолт нөлөөлөх эрсдэлтэй байгаа тухай дурдсан⁷⁵ Үүнд агаар, орчны бохирдол, амьдралын буруу хэвшил зэрэг олон зүйл нөлөөлж байгаа талаар судалгааны дүнгүүд ар араасаа гарч байна.

Өөр нэг судалгааны дүнгээс харахад “Монгол улс 2022 оны байдлаар нийт 3457548 иргэнтэй түүний 3.329% буюу 115115 иргэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэнийг 2003 харьцуулбал 54680 буюу 47,5%-иар өссөн үзүүлэлттэй байна. Тэр дундаа хөгжлийн бэрхшээлийн төрлийн дундаж өсөлт нь: Хараа – 3.38%, хөдөлгөөн – 3.01%, сэтгэцийн бэрхшээл – 4.368% буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна” гэжээ.

Зураг 8ХБХ-ий 2003–2027 оны өсөлтийн дундаж хурд⁷⁶

Диаграмм 1. 2003–2027 оны өсөлтийн дундаж хурдыг үзүүлэв.



Судлаачид 2003–2022 оны тоон мэдээлэлд тулгуурлан 2023–2027 оны хөгжлийн бэрхшээлийн аль төрөл, хэр нэмэгдэх хандлагатайг тодорхойлсон бөгөөд харааны бэрхшээл – 9.1%, хөдөлгөөний бэрхшээл – 8.6%, сэтгэц, оюуны бэрхшээл – 14.1% -иар, бусад бэрхшээл – 7.2%-иар өсөх төлөвтэй байна гэжээ. Ялангуяа сэтгэц, оюуны бэрхшээл нь сүүлийн 20 жилийн туршид тасралтгүй өссөн цор ганц бэрхшээл бөгөөд энэхүү бэрхшээл өмнө хамгийн бага тоон үзүүлэлттэй байсан бол одоо хамгийн их болсон байна. Иймээс энэ бүгдэд нөлөөж буй хүчин зүйлсийг дэлгэрэнгүй судалж бууруулах арга хэмжээ авах нэн шаардлагатай юм. Дээрхээс харахад хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой тодорхойлж холбогдох арга хэмжээг авах асуудал тулгамдаж байна.

Дараагийн шатанд хөгжлийн бэрхшээл, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх нь ХБ-тэй хүүхдэд шаардлагатай эмчилгээ, сувилгаа, дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжийг бүрдүүлэх бөгөөд ингэснээр тэднийг тэгш бус нөхцөлд амьдарч, нийгэмтэй харилцах, өөрийгөө илэрхийлэх чадваргүй болж, нийгмээс тусгаарлагдаж, цоожтой хаалганы цаана үлдэхээс сэргийлэх анхны алхам юм.

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод “Тухайн хүний хэрэгцээ, боломжид нийцсэн олон мэргэжилтний үнэлгээг үндэслэн хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээг

⁷⁵ Энэ тайлангийн 14 дэх нүүр

⁷⁶ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛЫН ҮР ДҮНГИЙН АСУУДАЛД илтэлээс. Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж. Эрдэм шинжилгээ, онол практикийн XI хурлын эмхэтгэл. 2023 он. Эх сурвалж: <http://www.gadpwd.gov.mn/images/tts/1d2d5-khugjliin-berhsheel-ba-tegsh-hurteemj-2023.pdf>

аль болох эрт үзүүлэх нь чухал” гэж тэмдэглэсэн байдаг. Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэн эмчлэх нь хүний амьдралын чанарыг бүх талаас нь сайжруулна гэж үздэг. Иймээс эцэг, эх, эмч, багш, олон нийт гээд бүх хүн л хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэхэд чухал үүрэгтэй байна. Гэвч иргэдийн дунд энэ талын мэдлэг хомс, оношилгооны өртөг өндөр байгаа нь эрт илрүүлэгт сөргөөр нөлөөлж байна. Мөн хүүхдийн мэргэшсэн эмчийн хомсдол, эмчийн мэдлэг, ур чадвар, хариуцлагын асуудал ч нөлөөтэй байна.

Шигтгээ

Би хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүүхэдтэй. Том охин зургаан нас, бага хүү хоёр нас таван сартай. Тэд минь хоёулаа төрөх үйл явцаас үүдэж хөгжлийн бэрхшээлтэй болсон. Би эрүүл ураг тээж байсан. Цаг тухай бүрт нь ургийн гажиг илрүүлэх ЭХО-д харуулж, шинжилгээ өгөхөд хүүхэд эрүүл гэдэг байлаа. Анх жирэмсний 36-37 хоногтой байхад гэнэт ургийн ус гараад эмнэлэгт очсон. Ургийн ус гарчхаад байхад намайг төрүүлэхгүй 20 гаруй цаг байлгасан. Охин минь төрөхдөө тархиндаа цус харвасныг надад хэлэлгүй эмнэлгээс гаргасныг нь би сүүлд нь мэдсэн л дээ. ... Харамсалтай нь, яг л ийм золгүй явдал дахин тохиолдсон. Би мөн л эрүүл ураг тээж байв. Жирэмсний 33-34 долоо хоногтойд ургийн ус гэнэт гарч, яаралтай төрөх эмнэлэгт очлоо. “Өмнө нь би охиноо хөгжлийн бэрхшээлтэй болгосон шүү. Боломжтой бол намайг Кесарево хагалгаанд оруулаад өгөөч. Ургийн ус нэлээд их гарсан” гэж эмчид анхааруулж хэлсэн. Охин минь тархины саажилттай болсон учраас дүүд нь муу зүйл тохиолдох вий гэхээс дотроо айж байлаа. Гэтэл намайг Кесарево хагалгаанд оруулахгүй эмнэлэгт дөрөв хонуулсан. Аргагүйн эрхэд надад төрөлтийг сэдээх дусал залгаж, хүчээр төрүүлсэн. Хүчтэй өвдсөндөө болоод би хэсэг хугацаанд ухаан балартсан юм билээ. Нэг сэрэхэд миний энгэр дээр цэлдийсэн хөх хүүхэд тавьсан байв. Гэтэл ЭХЭМҮТ-ийн сэхээн амьдруулахын эмч хүүг минь шүүрээд л аваад явчихсан. Яаралтай арга хэмжээ авсан ч хүү минь мөн л тархиндаа цус харваж, тэр нь шимэгдэхгүй байсаар усжилт үүссэн. ХБХ-тэй эхийн ярилцлагаас⁷⁷

Дэлхий нийтийн чиг хандлага хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусдын адил нийгмийн харилцаанд тэгш оролцуулах бодлого хэрэгжүүлдэг. Үүний нэг жишээ бол “Эрхийг бодитой болгоё” Инчоны стратеги юм. Энэ хүрээнд хүүхдийг төрсөн цагаас сургуульд орох хүртэл хугацаанд хөгжлийн бэрхшээлийг аль болох эрт илрүүлэх, дэмжлэгийн үйлчилгээнд оруулах талаар төрөөс тодорхой арга хэмжээг авч байна. Тухайлбал, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн сайдуудын хамтарсан тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”⁷⁸-ыг 2021 онд батлан хэрэгжүүлж эхэлснээр хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг 9, 18, 36 сартайд нь илрүүлэх, шаардлагатай тусламж, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдсэн гэж үздэг байна. Харин эрт илрүүлэгт холбогдох төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төсөв санхүүжилт хангалтгүй байгаа нь энэ төрлийн үйл ажиллагаа ихэвчлэн гадаадын донор байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжихэд хүргэдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцсэн орчинд, шаардлагатай тоног төхөөрөмжөөр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хуулийн зохицуулалтын хэрэгжүүлэх ажил удаашралтай байна.

ХБХ-д аливаа үйлчилгээг авахад хамгийн их тулгардаг бэрхшээл нь орчны саад, эмч, мэргэжилтнүүдтэй харьцах харилцааны буюу харилцан ойлголцлын асуудал байдаг. Эрүүл мэндийн байгууллага (цаашид ЭМБ гэх)-ын барилга байгууламжийн орц, гарц, шат, зам, хаалга, ариун цэврийн өрөө нь хөгжлийн бэрхшээлтэй болон тэргэнцэртэй хүн бие даан үйлчлүүлэх боломжгүй буюу зохих шаардлагыг хангаагүйгээс тэдгээр хүмүүст үйлчилгээ авахад хүндрэл үүсэж, хэн нэгнээс хараат болж, бусдын тусламж дэмжлэг авахад хүргэдэг. Ерөнхийдөө эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудын орчин, хүлээлгийн хэсэг тав тухтай, үйлчилгээний шаардлага хангаж чадаж байгаа эсэхийг тодруулахад дунд зэрэг, байр жижиг, суух газар олдоггүй, иргэдэд ээлтэй бус орчинтой, ариун цэврийн өрөөгүй, өрөөтэй байсан ч иргэдийг оруулдаггүй,

⁷⁷ “Цогц үзлэгт хамруулснаар хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх боломжтой” 2022 он. ГБХНХЯ.Эх сурвалж: mlsp.gov.mn

⁷⁸ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ. 2021 оны Дугаар А/220, А/475, А/812. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390053953441>

хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замгүй, түшлэг бариулгүй зэрэг асуудал нийтлэг байна⁷⁹.

Уг асуудлыг Хүний эрхийн үндэсний комиссоос 2022 онд “Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан” боловсруулсан бөгөөд уг тайланд ХБХ-ий эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилтийг тусгайлан авч үзсэн байна. Үнэлгээнд хамрагдсан 16 эрүүл мэндийн байгууллагын нөхцөл байдлаас харахад ХБХ бие даан эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал байна. Ялангуяа, харааны, хэл ярианы, сонсголын болон тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэдэд өөрийн эрүүл мэндэд хамаарах зарим асуудлаар дангаар шийдвэр гаргах, нууцаа хадгалах боломж бүрдээгүй болох нь гадаад, дотоод орчны үнэлгээгээр тогтоогджээ.

Доорх зурагт эмнэлгийн зориулалтаар баригдсан, өөр зориулалтаар баригдсан барилгуудыг ХБХ-д хүртээмжтэй байдлаар тохижуулсан байдлыг харуулав.

Зураг 9 ЭМБ-уудын гадаад орчны хүртээмж



Шигтгээ

Орхон аймгийн БОЭТ-ийн Сэтгэц болон сүрьеэгийн тасаг нэг барилгад хамт байрладаг ба 1 давхарт сэтгэцийн тасаг, 2 давхарт сүрьеэгийн тасаг байрлаж, үйл ажиллагаа явуулдаг. Эмнэлгийн зориулалтын бус оросын цэргийн ангийн ажилчид, албан хаагчдын байрладаг байсан байшинд 2000 оноос засвар үйлчилгээ хийж сэтгэц, сүрьеэгийн тасаг үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш хамгийн сүүлд 2018 онд 263 сая төгрөгөөр урсгал их засвар хийж, байрны агааржуулалт болон өрөө тасалгааг эмнэлгийн байрны стандартыг хангуулах түвшинд засвар үйлчилгээ хийжээ. Тус төвийн сэтгэцийн болон сүрьеэгийн тасгууд нэг байранд байрлаж байгаа нь сэтгэцийн эмчилгээ үйлчилгээ хийлгэж буй иргэд сүрьеэгийн халдвар авах, түүгээр өвчлөх эрсдэлийг бий болгож байна.

Амгалан амаржих газрын шинэ байр 2015 оны 10 дугаар сараас 150 ортой, төрөх эмнэлгийн “А”, “Б” 2 блокоос бүрдсэн, зоорийн давхартай, 10096 м2 талбай, 422 өрөө бүхий, 5 давхар байранд үйл ажиллагааг явуулж эхэлсэн бөгөөд эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй нөхцөл байдлыг онцлон судлахад тус амаржих газар хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчинд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг ашиглан тусламж, үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлсэн байна.

Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлангаас⁸⁰

⁷⁹ ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙН СУДАЛГАА СУДАЛГААНЫ ТАЙЛАН. 2021 он. ЭМЯ, АШУҮИС, ДЭМБ. Эх сурвалж: (PDF) ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙН СУДАЛГАА СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Үүнээс харахад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх анхан шатны байгууллагууд ихэвчлэн түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдгаас шалтгаалан дэд бүтэц, барилга байгууламж, байршил ХБХ-нд хүртээмжгүй байдаг бол энэ байдал эмнэлгийн шатлал ахих тусам сайжирдаг, ялангуяа эмнэлгийн зориулалтаар шинээр баригдаж буй барилга байгууламжийн түвшинд хүртээмжтэй болж байна.

ХБХ-д эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн дутагдлын талаар тодорхой судалгаа байхгүй байна. Харин эмчилгээний түвшин, эмийн хүртээмж, эмч мэргэжилтний мэдлэг, ур чадвартай холбоотой тулгамдсан асуудлууд байна.

Шигтгээ

Манай хүүхэд тархины саажилт, уналт таталт гээд хавсарсан өвчтэй. Монголд эмчилгээ таарахгүй болохоор хүүхдээ амьд байлгахын тулд Энэтхэг явж эмчлүүлдэг. Ирэхдээ чемодан дүүрэн эмтэй ирдэг. Тэр маань гааль дээр бөөн асуудал үүсгэж, үргэлж л танил тал хайх шаардлага үүсдэг. Учир нь төрөөс эдгээр сайн чанарын эмийг хүрэлцээтэй, хүртээмжтэй, тасралтгүй байлгах тал дээр арга хэмжээ авдаггүй. Хотын бид хол ойроос захиад болгож л байна. Хөдөө орон нутгийнханд бол байнга л түгшүүр, айдас үүсгэдэг асуудал болсон. Ковидоос хойш бол бүр нөөцлөх ёстой юм байна л гэдэг ойлголт авсан. ХБХүүхэдтэй ээжтэй хийсэн ярилцлагаас

Үүнээс харахад ХБХ-д амь насанд нь эрсдэл учрахаас урьдчилан сэргийлэх эм, эмийн бэлдмэлийн хангамж, түгээлт, бүртгэлийн тогтолцоо хангалттай ажиллахгүй байна.

Эмч нарын харилцаа, хандлага, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ХБХ-нд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт нөлөөлж байна. Тухайлбал, эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд дохионы хэлний мэдлэгтэй боловсон хүчин хомс, мөн эрүүл мэндийн байгууллагын түвшинд ярианы, сонсголын бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үр дүнгийн талаар мэдээлэл өгөх, үйлчлүүлэгчийн тайлбарыг сонсох асуудалд хүндрэл үүсгэдэг бол харааны бэрхшээлтэй иргэнд зориулан брайль үсгээр хэвлэсэн танилцуулга, мэдээлэл эрүүл мэндийн байгууллагад байхгүй зэргээс шалтгаалан ХБХ-д ихэвчлэн хамт ирсэн хүнээр нь дамжуулж, хэрэв ганцаараа ирсэн бол бичгээр, дохио зангаагаар харилцдаг нь эмчилгээ, оношилгооны талаар бүрэн дүүрэн ойлголт өгч чаддаг эсэхэд эргэлзээ төрүүлэхээс гадна ХБХ-ий эрүүл мэндийн нууцаа хадгалах, өөрөө шийдвэр гаргах эрхийг зөрчихөд хүргэж байна. Үүнд эрүүл мэндийн байгууллагууд бүгд төсөвтөө орчуулагч, хэлмэрчийн хөлсийг өнөөг хүртэл тусгаагүй, ӨЭМТ-үүд дохионы хэлтэй ажилтан/гэрээт ажилтангүй байгаа нь нөлөөлдөг. Ялангуяа ХБХ-ий боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг төвөөс алслагдсан буюу алслагдсан дүүрэг, орон нутагт буурч, бичиг үсэггүй хүний тоо өсөх хандлагатай байгаа нь анхаарах шаардлагатай асуудлын нэг юм. Иймээс эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс эрүүл мэндийн байгууллага бүрт дохионы хэлмэрч ажиллуулах, дохионы хэлтэй эмч, мэргэжилтэн бэлтгэх асуудалд анхаарах хэрэгтэй юм. Түүнчлэн хэл, ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчидтэй харилцах асуудлыг шийдвэрлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтэд дохионы хэлмэрчтэй байх шаардлагыг тусгасан нь энэ тал дээр түлхэц болохоор байна.

Шигтгээ

2022 онд нийслэлийн ЕБС-ийн 29-р тусгай сургуулийн ахлах ангийн 41 суралцагчаас авсан судалгаанд эрүүл мэндийн үйлчилгээ авах үед хүндрэлтэй асуудал тулгардаг гэж 22% нь буюу 54 хүүхэд тутмын 1 нь хариулсан байна⁸¹

Мөн зарим төрлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ХБХ-д хүртээмжтэй болгох асуудалд анхаарах шаардлага байна. Тодруулбал, энд шүдний эмнэлгийг онцолж болно. Амны хөндийн эрүүл мэнд нь хүний сайн сайхан байдлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг, амьдралын чанарыг илэрхийлэх нэг үзүүлэлт тул эрүүл мэндийн тусламж үйлчилгээний

⁸⁰ Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан.2022 он. Эх сурвалж: Scanned Image

⁸¹ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ АСУУДАЛ илтгэлээс. 2023. Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж. Эрдэм шинжилгээ, онол практикийн XI хурлын эмхэтгэл.2023. Эх сурвалж: <http://www.gadpwd.gov.mn/images/tts/1d2d5-khugliin-berhsheel-ba-tegsh-hurteemj-2023.pdf>

талаар мэдээлэл авах, амны хөндийн эрүүл ахуйг сахих, мэргэжлийн эмчийн үзлэг, эмчилгээнд хамрагдах нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чухал асуудал бөгөөд тэд бусад иргэдийг бодвол нүүр амны болон шүдний өвчлөлд өртөх өндөр эрсдэлтэй, эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах тал дээр дутагдалтай байна. Шүдний эмнэлгийн тусламж үйлчилгээг ХБХ-ий онцлог хэрэгцээ, эрүүл мэндийн байдалд тохирсон эмчилгээний менежменттэй болгох, тэгш хүртээмжтэй хамруулах нь өнөөгийн нийгэмд зайлшгүй хэрэгцээтэй тулгамдсан асуудлуудын нэг юм.

Шигтгээ

Аутизмтай хүүхдийн шүдийг үздэг эмч, шүдний эмнэлгийн айдас төрүүлэхээргүй тохижуулсан улсын эмнэлэг байхгүй, дээрээс нь хүүхэд маань яг шүдний цаг авсан өдөр явах эсэхийг урьдчилан таамаглах боломжгүй, очлоо гэхэд түүнийг хэзээ шүдээ үзүүлэхэд бэлэн болохыг хүлээгээд сууж байх эмч ч байдаггүй. Үзлэгийн цагтаа шахагдаад байдаг. Ийм болохоор хувийн эмнэлэгт үзүүлдэг. Орчин харьцангуй сайн, гэхдээ төлбөртэй.

ХБХ-тэй
ээжтэй хийсэн ярилцлагаас

ХБХ, тэдний асран хамгаалагчдын эрүүл мэндийн мэдлэг хангалтгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай нүүр амны эмч, эрүүл ахуйч зэрэг мэргэжилтнүүдийн хэрэгцээг тодруулсан судалгааны дүнгээс⁸² харахад улсын болон хувийн хэвшлийн аль ч эмнэлгүүдэд тусгай хэрэгцээт хүмүүст үйлчлэх нарийн мэргэшсэн нүүр амны эмч, эрүүл ахуйч мэргэжилтний орон тоо байдаггүй. Шүд, нүүр амны эмнэлгүүдийн ажлын байрны хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт хүмүүст үйлчлэх дэд бүтэц, орчин нөхцөл хангалтгүй байсан бөгөөд энэ нь ХБХ шүдний эмнэлгээр үйлчлүүлэхээс татгалздаг гол шалтгаан болж байна. Иймээс ХБХ-д ээлтэй орчин бүрдүүлэх, мэргэжилтэн бэлтгэхэд анхаарах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн ажлын ачаалал их, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг урьдчилан олгосон цагийн дагуу үзүүлдэг зэргээс шалтгаалан ХБХ-ий хэл яриа, сонсгол болон оюуны бэрхшээлтэй хүн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад хүндрэл үүсгэдэг бөгөөд энэ салбарт хот, хөдөөгийн ялгаатай байдал их банья. Иймээс ХБХ-ний онцлог хэрэгцээнд нийцсэн тохирох орчинд, тэднийг ойлгох, хүндэтгэх, шаардлагатай тохиолдолд нэмэлт цаг, мэргэжлийн дэмжлэг, туслалцаа авах боломжийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч мэргэжилтнүүдэд олгох нь чухал байна.

ХБХЭТХ-ийн 20 дугаар зүйлийн хэрэгжилтийг үнэлж үзэхэд хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх хуулийн зохицуулалт тодорхой хэмжээнд хэрэгжиж байгаа боловч бүрэн хэрэгжсэн гэж үзэх боломжгүй. Учир нь хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэхэд эрүүл мэндийн байгууллагаас гадна иргэдийн эрүүл мэндийн боловсрол, мэдлэг, эрүүл мэндээ хамгаалах ухамсрыг дээшлүүлэх шаардлагатай. Тухайлбал, жирэмсний хяналт, хүүхдийг 5 хүртэл насанд хянах, эрт илрүүлэг, дархлаажуулалт зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг үнэ төлбөргүй үзүүлж байгаа боловч ХБХ-ий тоо буурахгүй байна. Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцооны санхүүжилт хангалтгүй, ихэвчлэн гадаадын донор байгууллагуудын дэмжлэгтэй төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлдэг нь энэ арга хэмжээний тогтвортой байдалд нөлөөлөх талтай.

Эрүүл мэндийн байгууллага ХБХ-ий онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг Хүний эрхийн үндэсний комисс болон эрүүл мэндийн салбарт хийгдсэн судалгаа, хяналт үнэлгээний дүнгүүд харуулж байна. ХБХ-нд хүртээмжтэй, саадгүй орчин бүрдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад юуны өмнө эрүүл мэндийн салбарт оруулж буй хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудал голчлон нөлөөлж байгаа бол эрүүл мэндийн салбарт ажиллагсдын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, ажлын ачаалал, харилцаа, хандлага ч хамааралтай байна. Иймээс холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд өөрчлөлт оруулах замаар ХБХ-д үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, эмч, эмнэлгийн ажилтнуудын харилцаа, хандлагыг дээшлүүлэх, шаардлагатай тохиолдолд ХБХ-ий онцлогт

⁸² ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ШҮД, НҮҮР АМНЫ ӨВЧНИЙ ЭМЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ ИЛТГЭЛЭЭС.

нийцсэн дэмжих үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг арга хэмжээ авах боломжтой. Эдгээрийг хэрэгжүүлснээр тухайлбал, ХБХ-нд үйлчилгээ үзүүлэхдээ тухайн хүний онцлогт нийцсэн дэмжих үйлчилгээг урьдчилан захиалах, ХБХ-нд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд хангалттай хугацааг олгох зэргээр асуудалд эерэг өөрчлөлт хийх боломжтой гэж үзэж байна. Ялангуяа ХБХ-ий эрүүл мэндийн асуудал нь Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны аль алинд нь хамааралтай. Мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон нийгмийн хамгааллын зорилгоор иргэдэд олгодог эмчилгээ, асаргаа, сувилгааны бүтээгдэхүүн, туслах хэрэгсэл, үйлчилгээний цар хүрээ, нэр төрлийг тодорхой болгох, санхүүжилтийг аль байгууллагын төсвөөс гаргах асуудлыг оновчтой тогтоож, хэрэгжүүлснээр салбар дундын зөрүүтэй байдлыг арилгах боломжтой.

2.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний зарим эрхийг хангах тухай хуулийн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх

Хүснэгт 6 ХБХ-ий зарим эрхэд холбогдох заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
	27 дугаар зүйл	Хууль зүйн туслалцаа авах эрх	
	27.1.	Шүүх, прокурор, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна	Үйл ажиллагаа хүртээмжтэй болсон байна.
	30 дугаар зүйл.	Улс төрийн үйл ажиллагаанд оролцох	
	30.3, 30.4.	30.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдох, төрийн аливаа албанд томилогдон ажиллахад нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих үүрэгтэй. 30.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгана.	ХБХ-ий улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрх хангагдсан байна.
	33 дугаар зүйл.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих	
	33.2	33.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг биеийн тамир, спортын тэмцээн, уралдаанд оролцоход нь төрөөс дэмжлэг үзүүлнэ.	

Энэ хэсэгт ХБХ-д нэн хэрэгцээтэй боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой эрхүүдийг хангахаас гадна тэдний нийгэм, соёл, улс төрийн эрхийг хангах нь чухал. ХБХ эдгээр эрхээ эдлэхэд шаардагдах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, орчны хүртээмжийг нэмэгдүүлснээр ХБХ бусдын адил нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох нөхцөл бүрдэнэ.

Хууль зүйн туслалцаа авах эрхийн тухайд

ХБХЭТХ-ийн 27 дугаар зүйлд ХБХ-ий хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулж өгсөн ба шүүх, прокурор, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх тухай заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна, Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж, мөн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх...” гэж заасан эрхүүд ХБХ-ий тухай хэрхэн хэрэгжиж байгааг товч судалж үзлээ. УИХ-аас 2017 онд баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль⁸³, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль⁸⁴, 2002 онд баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль⁸⁵-иудад хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэйн улмаас өөрийн

⁸³ Өмгөөлөгч, хэлмэрч оролцуулах. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/12694>

⁸⁴ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль <https://www.legalinfo.mn/mn/detail/12696>

⁸⁵ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль . Өмгөөлөгч, хэлмэрч оролцуулах <https://legalinfo.mn/mn/detail/302>

хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол бичиг, дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангагдах эрхийг баталгаажуулж, шүүхийн шийдвэрийг түүнд ойлгомжтой байдлаар танилцуулахыг шүүхэд үүрэгжүүлж өгсөн бөгөөд холбогдох журам, аргачлалуудын батлан хэрэгжүүлж байгаагаас харахад хууль эрх зүйн орчныг хангалттай бүрдүүлсэн гэж үнэлж болно.

Харин бодит хэрэгжилтэд олон хүндрэл тулгарч байгаа жишээ нь орон нутгийн түвшинд хууль зүйн үйлчилгээний хүртээмж бага, мэдээлэл дутмаг, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх боломж хязгаарлагдмал зэргээс харж болно. Ялангуяа хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай материаллаг болон хүний нөөц хангалтгүй байна. Тухайлбал, эрүүгийн хэрэг хянан шалгах явцад оролцох ХБХ-ий сэтгэлзүй, нөхцөл байдал, асуудлыг бүрэн ойлгуулах чадвартай дохионы хэлмэрч, хараагүй хүнд зориулсан уншигч, бичигчээр бүрэн хангагдаагүй байна. Хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээг Дохионы хэлний хэлмэрч, орчуулагчдын холбооны гишүүд хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа боловч хүний нөөцийн дутагдалтайн дээр санхүүжилтийн асуудалд хүндрэл байнга гардаг. Хэлмэрчийн зардлыг хэн хариуцах нь ойлгомжгүй тохиолдол иргэний маргааны үеэр цөөнгүй тохиолдож байна. Энэ талаар “Хууль сахиулах байгууллагаас хэл, ярианы бэрхшээлтэй иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлэхэд анхаарах асуудал”⁸⁶ эрдэм шинжилгээний өгүүлэлд “Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэд өөрсдийн эх хэл болох дохионы хэлээр төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах боломж өнөөг хүртэл аль ч шатны байгууллагад хомс байна. (Монгол Улсын хэмжээнд 20 гаран дохионы хэлний хэлмэрч байдаг) Хууль, эрх зүйн туслалцаа шаардлагатай болох үед сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй шууд харьцах, анхан шатны тусламж, үйлчилгээг тухайн чиглэлээр үзүүлэх мэргэшсэн дохионы хэлний мэргэжилтэнгүй байгаа нь эдгээр иргэдэд орхигдсон, мартагдсан, гадуурхагдсан мэдрэмжийг төрүүлдэг.” тухай онцолсон байна.

Шигтгээ

Хэлгүй, дүлий хүн зарим тохиолдолд бичиг үсэггүй, дохионы хэлээ мэдэхгүй байдаг, ялангуяа хүүхдүүд. Гэр бүлийн хүчирхийлэл, хүчингийн хэргийн хохирогч болсон хүүхдэд туслалцаа үзүүлэхэд биеийн хэлэмжээр, дүрслэлээр дохионы хэлрүү орчуулах, дохионы хэлнээс ярианы хэлрүү орчуулах гээд 2 хэлмэрч шаардлагатай болдог. Гэтэл хуулийн байгууллагаас хэлмэрч авах зардал нь 1 хүн дээр тооцогддог. Хөдөө гадаагүй орчуулгад явахаар бид ч бас хөгжлийн бэрхшээлтэй болохоор ядардаг, солигдох хүн байдаггүй. Хараа, сонсгол, хэл ярианы хавсарсан бэрхшээлтэй хүнд бол туслалцаа үзүүлэх боломжгүй. Ийм цөөн хүн бий.

Дохионы хэлний хэлмэрч, орчуулагчдын холбооны гишүүнтэй хийсэн ярилцлагаас

УИХ-аас 2022 онд баталсан Хууль зүйн туслалцааны тухай⁸⁷ хуулийн хүрээнд эрүүгийн хэрэгт холбогдсон, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд төрөөс үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэхээр тусгасан нь ХБХ-д үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлсэн зохицуулалт болсон.

Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийн хэрэгжилт харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд харьцангуй сайн байгаа бол оюуны бэрхшээлтэй хүний хувьд хэрхэн хэрэгжүүлэх талаар хуулийн зохицуулалт байхгүй байна. Үүнийг өмнө дурдсан хуулиудад оюуны бэрхшээлтэй хүнээс тайлбар, мэдүүлгийн зурган болон хялбаршуулсан аргаар авах чадвартай мэргэжилтний асуудлыг хууль тогтоомжид тусгаагүйгээс харж болно.

ХБХЭТХ-ийн 27 дугаар зүйлд зааснаар хүн ямар хөгжлийн бэрхшээлтэйгээс үл хамааран хууль зүйн туслалцаа авах эрхээ тэгш, хүртээмжтэй эдлэх эрхийг баталгаажуулахыг зорьсон боловч өнгөрсөн хугацаанд хуулийг хэрэгжүүлсэн туршлага харааны болон сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд илүү хүртээмжтэй байхад чиглэгдсэн байна. Иймээс цаашид сэтгэц, оюуны бэрхшээлтэй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудалд анхаарах шаардлагатай байна.

⁸⁶ Хууль сахиулах байгууллагаас хэл, ярианы бэрхшээлтэй иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлэхэд анхаарах асуудал. Н.Бадамцэцэг. 2022 он. Эх сурвалж: <https://legaldata.mn/b/1371>

⁸⁷ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ

Дараагийн хөндөх сэдэв бол ял шийтгэл эдэлж буй ХБХ-ий асуудал. Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын хувьд ял эдэлж байх хугацаандаа гэр бүлийн харилцаа, асаргаа сувилгаа, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгэм, хамт олны харилцаанаас бүрэн тусгаарлагддаг ба хөгжлийн бэрхшээлийн улмаас үүдэн сэтгэл зүй, бие физиологи болон дэд бүтэц, ахуйн хэрэглээний хүндрэл бэрхшээлтэй ихээхэн тулгардаг⁸⁸. ХБХ хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үндсэн хуулиар олгосон эрхээ хязгаарлуулж байгаа ч түүний ХБХЭТХ-д заасан эрхийг хязгаарлахгүй. Гэтэл хорих ангийн дотоод журам, бусад дүрэм журмаар зохицуулаагүйгээс ХБХ хорих ял эдлэх хугацаандаа хөдөлмөр чадвар алдалтын хувь хэмжээг тогтоолгох, сунгуулах процесс хүртээмжгүй, хугацаандаа сунгуулж чадахгүй байх асуудал гардаг бөгөөд үүнийг хэрхэн хэрэгжүүлэхийг хорих анги бүр өөр өөрөөр шийддэг байна. Мөн гадаад, дотоод орчны хүртээмжийн асуудал ч мөн тулгамдсан асуудлын нэг. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хоригдол номын сангаар үйлчлүүлэх, сургалт, хөдөлмөр, нийгмийн ажлын үйлчилгээнд хамрагдаж ялын хугацааг өөрчлөх боломжоо ашиглахад хүндрэлтэй байна. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын асуудлыг шийдвэрлэхэд хорих байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлийн онцлогт нийцсэн сургалт, нийгмийн ажилд хамруулах тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлага байна. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 214 дүгээр зүйлийн 214.11-д “хоригдлын хүсэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг бие эрүүл мэндийн нөхцөлд нь таарсан ажил гүйцэтгүүлж болно” гэх заалтын хэрэгжилтийг хангах, хөдөлмөрийн норм, ажлын цагийг холбогдох хууль журамд тодорхой тусгаж өгөх, мөн хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг асарч байгаа хүнд /ажилтан, хоригдол гэх зэрэг/ х ШШГЕГ-ын харьяа хорих анги, албаны алба хаагчид, тэр дундаа нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарт хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээг хүндэтгэх, ёс зүйг эрхэмлэх хандлагыг төлөвшүүлэх, дохионы хэлний анхан шатны мэдлэгтэй болгох, цаашлаад энэ чиглэлээр дохионы хэлний хэлмэрч, хөтчөөр сургах зэрэг олон асуудал тулгамдаж байна.

Үндсэндээ шүүх, хууль сахиулах байгууллагуудын орны хүртээмжийг нэмэгдүүлэхэд боловсрол, эрүүл мэндийн салбарын нэгэн адил төсөв, санхүүжилтийн асуудал тулгамдаж байгаа тул эдгээр байгууллагуудын төсөвт ХБХ-п хүртээмжтэй орчин бүрдүүлэх чиглэлд тусгайлан төсөв олгож хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна.

ХБХ-тэй харилцах хүний нөөцийн дутагдал энэ салбарт ч байна. Хэдийгээр хуулийн байгууллагууд албан хаагчдаа сургалтад хамруулах, хөтөч үйлчилгээг нэвтрүүлэх замаар асуудлыг шийдвэрлэхийг зорьж байгаа боловч ажлын ачаалал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн их байдаг тул төдийлөн үр дүн гарахгүй байна. Хуулийн байгууллагуудаас гаргаж буй мэдээ тайланд албан хаагчдыг сургалтад хамруулсан, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, мөн холбогдох эрх зүйн орчныг сайжруулсан талаар мэдээлэл их байх боловч үр дүн ямар байгаа талаар тайлагнадаггүй⁸⁹ нь учир дутагдалтай байна. Иймээс цаашид илүү үр дүнг харуулсан тайлан гаргадаг байхад анхаарах шаардлагатай гэж үзэж байгаа бөгөөд энэ нь нэг талдаа ХБХ-д чиглэсэн үйл ажиллагааны төсвийн асуудалд, нөгөө талдаа хуулийн салбарт ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлоход ч хамааралтай юм.

Улс төрийн оролцоо хангах тухайд

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх заалтад “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “...шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...” гэж заасан бол Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын 29 дүгээр зүйлд “...Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн эрхийг баталгаажуулж, эдгээр эрхээ бусдын нэгэн адил эдлэх боломжийг бий болгох үүднээс дараах үүрэг хүлээнэ: а) Бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрх, боломжийг оролцуулан шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөллийн байгууллагаараа дамжуулан улс төр, нийгмийн амьдралд үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцох...” гэж, мөн ХБХЭТХ-ийн 30 дугаар зүйлд ХБХ-ийг бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдох, төрийн аливаа албанд томилогдон

⁸⁸ Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж. Эрдэм шинжилгээ, онол практикийн XI хурлын эмхэтгэл.2023. Эх сурвалж: <http://www.gadpwd.gov.mn/images/tts/1d2d5-khugjliin-berhsheel-ba-tegsh-hurteemj-2023.pdf>

⁸⁹ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АСУУДАЛ: БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА 2020 тайланд хийсэн дүгнэлт. Эх сурвалж: https://mlsp.gov.mn/uploads/files/hbi_nom2020.pdf

ажиллахад нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих үүргийг хүлээлгэсэн, мөн ХБХ сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгах тухай тус тус заажээ. Үүнээс гадна Сонгуулийн тухай хуулиудад сонгох, сонгогдох эрх болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг санал өгөх боломжоор хангасан байхыг хуульчилсан бол Улс төрийн намын тухай хуульд нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллахыг үүрэг болгож хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоогоор төрийн санхүүжилтийг нэг удаа олгоно гэсэн зохицуулалтуудыг оруулж 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн Улс төрийн намын тухай хуульд тусгагдсан нь бодитой алхам болсон.

ХБХ улс төр, нийгмийн амьдралд бусдын нэгэн адил бүрэн дүүрэн, саадгүй, бие даан оролцох эрх нь дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжгүй байдал, нийгмийн хандлага, ойлголт сул, хууль, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт хангалтгүй, сонгуулийн тогтолцоо зэргээс шалтгаалан хязгаарлагддаг. ХБХ гэх ерөнхий нэршил дор олон янзын бэрхшээлтэй хүмүүс байх бөгөөд бэрхшээл тус бүрд тулгардаг асуудлууд хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээс шалтгаалан өөр өөр байна.

ХБХ-ий сонгогдох эрхийн хэрэгжилтийг харахад нам эвслээс 6, бие дааж нэр дэвшсэн 3 ХБИ байна. УИХ болон орон нутгийн долоон удаагийн сонгуульд нийт найман хөгжлийн бэрхшээлтэй хүн нэр дэвшиж, өрсөлдсөн буюу 2000–2020 оны хооронд болсон УИХ-ын сонгуульд 6, орон нутгийн сонгуульд 2 ХБИ нэр дэвшиж өрсөлдсөн бөгөөд орон нутгийн сонгуульд 2 нь ялалт байгуулсан байна.

Зураг 10 ХБХ сонгуульд нэр дэвшсэн байдал⁹⁰

Д/д	Төрөл	Он	Тойрог	Нам, эвсэл, бие даасан байдал
1	Улсын Их Хурал	2004	63 дугаар тойрог	Ардчилсан нам
			Баянгол дүүрэг	Иргэний зориг ногоон нам
		2008	Сонгинохайрхан дүүрэг	Бие даагч
		2012	Баянзүрх дүүрэг	Бие даагч
		2016	Сэлэнгэ аймаг	Тусгаар тогтнол эв нэгдлийн нам
		2020	Хэнтий аймаг	Шинэ нам
		2020	Баянзүрх дүүрэг	Ардчилсан нам
2	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2016, 2020	Чингэлтэй дүүрэг, 16 дугаар тойрог	Ардчилсан нам

ХБХ сонгуульд нэр дэвшихэд хамгийн их тулгардаг бэрхшээл бол санхүү, дэд бүтэц, хандлага ойлголтын асуудлууд. Сонгуульд намаас нэр дэвшихэд маш их өрсөлдөөн байдаг тул санхүүгийн боломжгүй, хүрээлэл багатай, танигдаагүй ХБХ-ий хувьд нэр дэвших нь бараг боломжгүй зүйл юм. 2020 оны ээлжит сонгуулиар жишээ аваад үзэхэд УИХ-ын сонгуульд нийт 606 нэр дэвшигч өрсөлдсөнөөс 2 нь хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигч, орон нутгийн сонгуульд 17,357 нэр дэвшигч өрсөлдсөнөөс 1 нь хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигч байжээ. Энэ нь ХБХ-ий сонгогдох эрхийн тухайд төлөөллийн оролцоог дэмжих хууль эрх зүйн орчин хангалтгүй хэрэгжиж байгааг харуулж байна.

Хэдийгээр сонгогдох эрхийн хэрэгжилт хангалтгүй ч ХБХ-ий сонгуульд оролцох идэвх харьцангуй өндөр байна. Тухайлбал, ХЭҮК-ын судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 85.7 хувь нь 2020 оны УИХ-ын, 84.1 хувь нь 2020 оны орон нутгийн сонгуульд, 84.7 хувь нь 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд санал өгсөн гэжээ.⁹¹ Хэдийгээр ХБХ-ий сонгох эрхийг хууль тогтоомжоор баталгаажуулж өгсөн ч бэрхшээлийн хэлбэрээр хэт ерөнхийлсөн, бодит байдал дээр хэрэгжилт хангалтгүй байдгаас болж ХБХ зохих ёсоор, бие дааж сонгох эрхээ эдлэхэд саналаа нууцаар, бие дааж өгөх нөхцөл бүрдэхгүй байх, өөрийн онцлог хэрэгцээнд нийцсэн хэлбэрээр мэдээлэл авч чаддаггүй байх, ойр дотно хүмүүсийн нөлөөнд автах асуудал гардаг бол ихэнх тохиолдолд “саналаа нууцаар өгөх” эрх хэрэгжих боломжгүй байдаг байна. ХБХ сонгох эрхийн хэрэгжилтэд мөн д гадаад, дотоод

⁹⁰ хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт. ХЭҮК. 2024 он: Эх сурвалж: <https://legaldata.mn/b/2235>

⁹¹ хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт. ХЭҮК. 2024 он: Эх сурвалж: <https://legaldata.mn/b/2235>

орчны хүртээмж нөлөөлдөг. Ялангуяа цөөнгүй санал авах байр сургууль, цэцэрлэгийн барилгын хоёрдугаар давхарт байршсан нь хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд хүндрэл үүсгэсэн бол сул хараатай иргэдэд зориулсан 16-аас доошгүй үсгийн фонтоор хэвлэсэн мэдээлэл аль ч байранд байгаагүй, дохионы орчуулагч ажиллуулсан санал авах байр байгаагүй зэрэг мэдээллээс харж болно.

Ерөнхийдөө хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд санал авах байрны хүртээмжгүй байдал илүү асуудал болдог бол харааны бэрхшээлтэй иргэдийн саналаа бие дааж, нууцаар, чөлөөтэй өгөх эрх нь илүү зөрчигддөг байна. Сонсголгүй иргэдийн эх хэл нь дохионы хэл байдаг бөгөөд бичгийн хэлний чадвараасаа шалтгаалан нэр дэвшигчдийн болон намын мөрийн хөтөлбөрөөс мэдээлэл авах боломж нь хязгаарлагддаг тул хэнийг сонгохоо мэдэхгүй байх, ойр дотно хүмүүсийн нөлөөнд автаж саналаа өгөх гэх мэтээр бие дааж шийдвэр гаргах эрх нь зөрчигддөг.

ХБХ-ий улс төрийн үйл ажиллагааны оролцоог хязгаарлаж буй хүчин зүйл бол тэдний хувь хүний боловсрол, санхүүгийн чадавх, хувь хүний хөгжил, нийгмийн харилцаанд бие даан оролцох дадал, өөрийгөө үнэлэх үнэлэмж, улс төрд оролцох идэвх бага, чанартай мэдээлэл хомс, хүртээмжгүй байдал байна.

ХБХ-ий улс төрийн оролцоог Хүний эрхийн Үндэсний комиссоос хийсэн судалгааны “ХБХ нийгмийн амьдралд бусад хүмүүсийн адил, үр дүнтэй оролцох боломжийг бий болгох нь ХБХ-ий улс төрийн оролцоог нэмэгдүүлэхээс гадна нийгмийн бүлгүүд улс төрд идэвхтэй оролцсоны дүнд тэдний амьдрал, нөхцөл байдал, хүсэл эрмэлзэл төрийн бодлого, хууль тогтоомжид илүүтэй тусгагдах тул хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрхийг хангах нь бусад эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг дээшлүүлэх арга зам юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол өнөөгийн нийгмээс хамгийн их тусгаарлагдсан нийгмийн бүлэг юм. Амьдралын наад захын шийдвэрийг өөрөө гаргах дадал бага, бие даан амьдрах, нийгмийн харилцаанд оролцох чадвар сул, хөдөлмөр эрхлэхгүй, эдийн засгийн чадавхгүй байдал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн идэвх, оролцоонд саад учруулж буй тэргүүлэх хүчин зүйлс байна. Орчны хүртээмжгүй байдал, бие даан чөлөөтэй зорчих боломжгүй, бэрхшээлийн онцлогт тохирсон байдлаар мэдээлэл авч чадахгүй байгаа нь нийгмийн идэвхтэй харилцааг хязгаарлах удаах хүчин зүйл болж байна. Энэ нь нэг талаас өөрийн чадвар, чадавхын талаарх төсөөлөлд хүйс төдийлөн чухал нөлөө үзүүлэх хүчин зүйл биш болохыг, нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоо маш бага учраас хөгжлийн бэрхшээл ба нийгмийн бусад хүчин зүйлсийн харилцан хамаарлыг мэдрэх туршлага байхгүйг илтгэж болно. Өөрөөр хэлбэл, нийгмийн тулгамдсан асуудлыг ихэнх тохиолдолд хууль тогтоомж, бодлогыг өөрчилж, асуудал эрхэлсэн байгууллага үүсгэснээр бодитой шийдэхгүй, харин тухайн асуудалд нөлөөлж буй хувь хүний, нийгэм-соёлын, эдийн засгийн, улс төр, эрх зүйн суурь хүчин зүйлсийг тодорхойлж, авах арга хэмжээний эрэмбийг тогтоох нь илүү үр дүнтэй байж болохыг энэ бүлгийн дүн шинжилгээ сануулж байна” гэх дүгнэлтээр үнэлж болох юм.

Иймээс ХБХ-ий улс төрийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд тэдний боловсрол, санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ нийгмийн амьдралд бие даан оролцох нөхцөлийг бүрдүүлэх замаар өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нэмэгдүүлэх нь чухал. Мөн сонгох эрхийн хэрэгжилтийг хангахын тулд орчны болон мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, бие даан шийдвэр гаргах, сонголт хийх хэвшил, дадал төлөвшүүлэх шаардлагатай байна. Мөн оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийг бэрхшээлийн хэлбэрээр нь ялгаварлан гадуурхаж, хуулиар сонгох эрхийг нь хязгаарлах⁹² нь ХЭТТ-ын 21 дүгээр зүйл, ИБҮТЭТОУП-ын 25 дугаар зүйлд заасан тэгш сонгох эрхийг хамгаалах олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй зөрчилдөх магадлалтай энэ асуудлыг гүнзгийрүүлэн судалж, цаашид анхаарах шаардлагатай юм.

Биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих асуудал

ХБХЭТХ-ийн 33 дугаар зүйлд ХБХ-ийг биеийн тамир, спортын тэмцээн, уралдаанд оролцоход нь төрөөс дэмжлэг үзүүлэхээр заасан. Гэвч энэ зохицуулалт ХБХЭТХ-аас хамгийн муу хэрэгждэг буюу хуулийн заалтын хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр хаанаас

⁹² Монгол Улсад эрх зүйн чадамжгүйг нь шүүхээр тогтоосон 6,000 гаруй оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэд байдаг гэсэн мэдээлэл байгаа ч албаны эх сурвалж тодорхой бус, мөн энэ төрлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоох мэдээлэл хангалтгүй байна.

гарах нь тодорхойгүй, нийгмийн халамжийн сангаас гардаггүй тул бодит байдал дээр хэрэгжих боломжгүй болохыг дурджээ⁹³.

ХБХ-ий биеийн тамир, спортыг дэмжих асуудлыг УИХ-аас 2024 онд баталсан Биеийн тамир, спортын тухай хууль⁹⁴ болон ХБХЭТХ-иар зохицуулдаг. Харин 2017 онд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 153 дугаар тогтоолоор “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого⁹⁵”-ыг баталж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх үйл ажиллагааг бодлогоор дэмжихээр тусгасан бол ЗГ-ын 2019 оны 335 дугаар тогтоолоор “Биеийн тамир, спортын үндэсний хөтөлбөр” (2019-2027 он)⁹⁶-ийг баталж, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өөрийн бие бялдрын хөгжлийг тодорхойлох арга зүйг биеийн тамирын хичээлээр олгодог болох; тусгай сургуулийн биеийн тамирын хичээлийн сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог, ажиллах чадварт тохирсон спортын төрлүүдийг тусгаж хэрэгжүүлэх, багш, дасгалжуулагчийг мэргэшүүлэх, давтан сургах, ерөнхий боловсролын сургуулиудыг стандартын спортын заал, талбайтай болгох, спортын хэрэглэлийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэрэглэлээр тоноглох, хяналт тавих зэрэг арга хэмжээг тусган ажиллаж байсан боловч эдгээр бодлогын баримт бичгүүд 2021 онд хүчингүй болсон байна.

Биеийн тамир, спортын тухай хууль (2024 он)-ийн 11 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй тамирчныг паралимп, дифлимп, тусгай олимпын наадамд оролцоход дэмжлэг үзүүлэх тухай, мөн 30 дугаар зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг тусгайлсан заалт болгон шинээр нэмэгдсэн нь хуулийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлэх магадлалтай байна. Учир нь өмнө 2017 онд батлагдсан хуулиар зөвхөн паралимпыг онцлон авч үзсэн нь бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, урамшуулах асуудал орхигдох, мөн дифлимп, тусгай олимпийн наадамд оролцох тамирчид олон нийтийн хандив тусламжаар тэмцээнд оролцох нөхцөл байдалд хүргэсэн.

Харин 30.1 дэх хэсэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан дэмжлэг үзүүлнэ гэж ХБХЭТХ-ийг эшэлсэн нь өнөө л санхүүжилтийн эх үүсвэрийн асуудал шийдэгдэхгүй байхад хүргэж болзошгүй юм. Хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан тамирчны эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ гэж тухайлан оруулснаас Засгийн газраас олимп тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож, медаль хүртсэн тамирчин, дасгалжуулагчид олгох мөнгөн шагнал, урамшуулалд хамрагдах боломж нээгдэнэ. Гэвч энэ журмыг ЗГ-аас шинэчлэн батлаагүй бөгөөд 2018 онд баталсан олон улсын олимпийн хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам⁹⁷ үйлчилж байна.

Шигтгээ

Хөгжлийн бэрхшээлтэй тамирчин тив, дэлхийн наадамд оролцоход дасгалжуулагчаас гадна орчуулагч, хэлмэрч, эмч, сэтгэлзүйч гээд олон хүний бүрэлдэхүүнтэй явах шаардлагатай байдаг. Ялангуяа сонсол, хэл ярианы бэрхшээлтэй тамирчдын дунд 1 дохионы хэлмэрч явах тохиолдол их гардаг. Хэрэв зэрэг тоглолт хийвэл аль нэг нь хэлмэрчгүй үлддэг. Үүнээсээ болж алддаг. Сэтгэлзүйн хямралд ордог гээд асуудал бий. Бусад орны тамирчдыг хараад атаархдаг. Тэд хэлмэрч орчуулагч, хоол зүйч, хувийн туслах, сэтгүүлч гээд бараг бидний мөрөөдөөд биелэхээргүй олон хүний бүрэлдэхүүнтэй оролцдог. Дифлимпын холбооны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Дээрхээс харахад ХБХ-ий биеийн тамир, спортыг дэмжих замаар амьдралын чанар, сэтгэл зүйг дэмжих боломж өндөр байгаа ч биеийн тамир, спортын заал танхимуудын хүртээмжгүй

⁹³ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН. 2018. Д.Сүнжид

⁹⁴ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ

⁹⁵ ТӨРӨӨС БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ

⁹⁶ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

⁹⁷ ОЛОН УЛСЫН ОЛИМПИЙН ХОРООНЫ ИВЭЭЛ ДООР ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ ТИВ, ДЭЛХИЙН НААДАМ БОЛОН ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОЖ МЕДАЛЬ ХҮРТСЭН ТАМИРЧИН, ТҮҮНИЙ ДАСГАЛЖУУЛАГЧИЙГ ШАГНАЖ УРАМШУУЛАХ, МӨНГӨН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

байдал, жишээ нь ЕБС-ын биеийн тамирын заал 2-3 давхарт байрладаг, лифтгүй, ХБХ-ий хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх арга хэмжээ хангалтгүй байна.

Мэргэжлийн түвшинд хичээллэж буй тамирчдын хувь дасгалжуулагч, хувийн туслах, орчуулагч, хэлмэрчийн үйлчилгээг хүртээмжтэй авч чаддаггүй, медаль авсан ч урамшууллыг хаанаас олгох нь тодорхойгүй байдлаас эдийн засаг, сэтгэлзүйн хувьд эрсдэл үүрч байна.

*Шигтгээ*⁹⁸

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2017-2019 онд дэлхийн зэрэглэлийн тэмцээнд оролцож, амжилт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урамшууллыг олгож ирсэн. Харин үүнээс хойш урамшууллын асуудлыг шийдвэрлэж чадалгүй удааширсан учир тамирчид ХНХЯ-нд энэ талаар удаа дараа хүсэлтээ хүргүүлж байв.

Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хорооны даргын хувьд Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах санаачилгыг гаргаж, Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа нартай хамтран 2020-2024 онд паралимп, дифлимп, тусгай олимпын тамирчид тив, дэлхий, олимпын зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн 57 тамирчинд дээрх хуулийн дагуу олгох 744.3 сая төгрөгийн урамшууллын асуудлыг өнөөдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэлээ.Биеийн тамир, спортын улсын хорооноос мэдээллээ.

Иймээс ХБХЭТХ-д паралимп, дифлимп, тусгай олимпын тамирчид тив, дэлхий, олимпын зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцож, медаль хүртсэн тамирчид, дасгалжуулагчид олгох урамшуулал, түүнийг олгох, санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхойлох, мөн ХБХ-ийг дасгалжуулах багш бэлтгэх, эсхүл хувийн туслахын үйлчилгээний асуудлыг ч мөн шийдвэрлэх шаардлагатай байна.

ХБХ-ий биеийн тамир, спортын үйл ажиллагаанд хамрагдахад спортын байгууламж, дэд бүтэц, ялангуяа, хөдөө орон нутагт хүрэлцээгүй, хүртээмжгүй, төрөөс ХБХ-ий спортын үйл ажиллагааг дэмжихэд зориулсан санхүүжилт хангалтгүй зэрэг бэрхшээл үүсч байгаад анхаарах нь зүйтэй байна.

2.1.6. Хөгжлийн бэрхшээлийг тогтоох хуулийн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх

Хүснэгт 7ХБХ-ий зарим эрхэд холбогдох заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томьёолол
	37 дугаар зүйл.	Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох	
	37 дугаар зүйл.	37.1. Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараах шалгуураар тогтооно: 37.1.1.эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдал, ангилал, хугацаа; 37.1.2.биеийн үйлдэл, үйл ажиллагааны олон улсын ангилал.	Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдал болон биеийн үйлдэл, үйл ажиллагааны олон улсын ангиллын дагуу тогтоодог болсон байна.

Хөгжлийн бэрхшээлийг тогтоох асуудлыг ХБХЭТХ-д эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдал болон үйлдэл, үйл ажиллагааны ажиллагааны олон улсын ангиллын дагуу тогтоохоор хуульчилсан боловч одоогоор зөвхөн эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдлаар (ICD) хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ, хугацааг тогтоож байна. Хөгжлийн бэрхшээлийг үнэлэх, тогтоох тогтолцоо нь 1/ орон нутгийн эрүүл мэндийн төвүүд эсвэл мэргэжилтнүүдийн анхан шатны үзлэг, 2/ хоёрдугаар шатлалын эрүүл мэндийн төвүүдийн гурваас таван эмчээс бүрдэх эмч нарын хурлаар онош тогтоодог, 3/ Эрүүл мэндийн магадлалын зөвлөл оношийг баталж, тогтсон стандартын дагуу шийдвэр гаргах байдлаар хэрэгжиж байна.

⁹⁸ Тив, дэлхийн тэмцээнд амжилт үзүүлсэн тамирчдад мөнгөн урамшуулал олгоно

Харин 16-аас доош насны, 2024 оноос 18-аас доош насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс Эрүүл мэндийн яамнаас баталсан 326 өвчний оношоор хөгжлийн бэрхшээлийн түвшин болон хугацааг нь тогтоож мэдээллийн сан үүсгэдэг байна. Үүнээс харахад Монгол Улсад өнөөг хүртэл хөгжлийн бэрхшээлийг зөвхөн тухайн өвчний байдлаар буюу зөвхөн эмнэлгийн загвараар тодорхойлж ирсэн. ХБ-тэй насанд хүрэгчид, хүүхдийг үнэлэх зорилтот бүлгийг тодорхойлох аргачлал “Өвчний олон улсын ангилал ICD-10” ангиллаар явж байна. Энэ нь зөвхөн онош тавих төдийгөөр хязгаарлагдсан байдаг.

Үүнээс харахад ХБХЭТХ-ийн 37.1.2.биеийн үйлдэл, үйл ажиллагааны олон улсын ангиллаар хөгжлийн бэрхшээлийг тогтоох (ICF) зохицуулалт хэрэгжээгүй байна.

Гэхдээ ДЭМБ-аас гаргасан хөгжлийн бэрхшээлийн талаарх өргөн хүрээний тодорхойлолт болон НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу хөгжлийн бэрхшээлийг тодорхойдох эмнэлгийн загвараас хүний эрхэд суурилсан, нийгмийн загварт шилжих буюу ICF-ийг нэвтрүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авсны нэг нь 2016 оны ХБХЭТХ-д энэ зохицуулалтыг тусгасан явдал юм.

Харин хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ЭМЯ-наас 2011 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлийг олон нийтэд түшиглэсэн сэргээн засах үйлчилгээний хөтөлбөр”-ийн хүрээнд 2015 он гэхэд олон улсад стандартчилагдсан мэдээллийн систем боловсруулах болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх үнэн зөв бодит мэдээллийг бодлого боловсруулагчдад хүргэхийн тулд ICF-ийг нэвтрүүлэх зорилт тавьсан, мөн ЗГ-аас 2018 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т 2018-2020 онд ICF-ийн туршилт төслийг хэрэгжүүлэхээр тусгагдсан боловч эдгээр хөтөлбөрүүдийг хүчингүй болгосноор хэрэгжилт удааширч, төлөвлөсөн ажлууд хугацаандаа хийгдээгүй байна.

Олон улсын чиг хандлагад нийцүүлэн тусгасан хуулийн заалтын бодит хэрэгжилтийг хангаснаар хөгжлийн бэрхшээлийг цогц байдлаар үнэлэх боломж бүрдэх ба энэ нь нийгмийн халамж үйлчилгээний төрөл, тэтгэмжийн хэмжээг тодорхойлох гол хүчин зүйл болно. Тодруулбал, ICF-ийн үнэлгээг ашигласнаар хөгжлийн бэрхшээлтэй гэсэн онош тогтоогоод зогсохгүй, цаашид энэ хүн юу хийж чадах, энэ чадварыг ашиглахын тулд гадаад дотоод ямар хүчин зүйлүүд нөлөөлж болох, хэрхэн яаж энэ хүний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, юун дээр нь анхаарах талаар үнэлдэг, мэдээлэл цуглуулах, энэ төрлийн үйлчилгээ, үйл ажиллагааны уялдааг хангах, чиглүүлэхэд дэвшил гарна гэж үздэг.

Монгол Улс хөдөлмөрийн чадварын үнэлгээг зөвхөн эмнэлгийн дүгнэлтээр үнэлж, хөгжлийн бэрхшээлийг тогтоож тэтгэвэр, тэтгэмж олгодог тогтолцоо нь тухайн хүн хөгжлийн бэрхшээлтэй байсан ч нийгмийн амьдралд (мэргэжлийн үйл ажиллагаа, өдөр тутмын амьдралын үйл ажиллагаа) хэрхэн оролцож болох, үүний тулд түүнд ямар төрлийн туслах үйлчилгээ үзүүлэх боломжтойг тодорхойлдоггүй хязгаарлагдмал арга хэрэглэж байна гэж үздэг. Энэ нь ХБХ нийгэмд гадуурхагдах болон зөвхөн төрөөс олгож буй тэтгэмжээр амьжиргаагаа залгуулдаг, дийлэнх нь боловсрол багатай, ядуу амьдралтай зэрэг хүний эрхийн асуудал хөндөгдөж байна.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлийг тогтооход орон нутагт хөгжлийн бэрхшээлийн үнэлгээ хийх нөхцөл бүрэн бүрдээгүйгээс иргэд олон удаа эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамрагдах шаардлагатай байдаг нь Үнэлгээний системийн хүртээмж муу байгааг илэрхийлж байгаа бол хөгжлийн бэрхшээлээ тогтоолгосон ч нийгмийн халамжийн үйлчилгээ хүртэх процесс удаан байдаг нь ХБХ төрийн үйлчилгээ авахад хүндрэлтэй байдал үүсэж байна.

Иймээс ХБХ-ий нийгмийн амьдралд оролцох боломжийг олгож, нийгмийн талаас үзүүлэх дэмжлэг үйлчилгээг тодорхойлох гол хэрэгсэл болох ICF-ийг нэвтрүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдлийн чадамжийг тогтоох, бодлого төлөвлөлтийг оновчтой хийх, хүний онцлог, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хүргэх арга зүйг боловсруулж, энэ чиглэлээр холбогдох мэргэжилтнүүдийг бэлтгэх шаардлагатай байна. Мөн орон нутгийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын байгууллагуудын чадавхыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүний хөгжлийн бэрхшээлийг тогтоосны дараа тэдэнд хүргэх боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээ, оновчтой тогтоох зэрэг ХБХ-ий эрхийг хамгаалах, тэдний амьдралын чанарыг дээшлүүлэх бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх заалтад “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна, Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “...шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...” гэж, Арван зургадугаар зүйлийн 6-д иргэн бүр “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй ...” гэж, мөн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх...” гэж тус тус заасан.

Гэвч ХБХ эдгээр Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эдэлж, нийгмийн харилцаанд тэгш оролцох боломж хязгаарлагдмал, нийгмээс гадуурхагдсан хэвээр байна.

ХБХЭТХ-д өнгөрсөн хугацаанд нийт 10 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд дийлэнх нь бусад хууль тогтоомжийн шинэчлэлтэй холбоотой, дагалдах хуулийн түвшний өөрчлөлтүүд байсан ба зарчмын шинжтэй өөрчлөлт хийгдээгүй. Иймээс НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, ХБХЭТХ-ийн зөрчил, давхардал, хийдлийн судалгаагаар илэрсэн зөрчлийг арилгах, хууль батлагдсанаас хойш улс орны нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн орчинд гарсан ахиц дэвшилтэй уялдуулах зорилгоор шинэчлэх шаардлагатай байна. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 8, 51 дүгээр зүйлд заасны дагуу үр дагаврыг үнэлэх шаардлагад үндэслэн ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу ХБХ-ий ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, боловсрол олгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн бэрхшээлийг тогтоох болон хууль зүйн туслалцаа үзүүлэх, улс төрийн оролцоог хангах, биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих зэрэг ХБХ бусдын адил эрхээ эдэлж, нийгмийн харилцаанд тэгш оролцох орчин, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй зарим үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт өгөхийг зорьсон болно.

Монгол Улсын хүн амын тоо 2016 оноос 2024 он хүртэл 16,9 хувиар өссөн бол ХБХ-ий тоо 11,7 хувиар өссөн бөгөөд ХБХ-ий нийт хүн амд эзлэх хувь ойролцоогоор 3 хувьтай байна. Хөгжлийн бэрхшээлийн хувьд хэл, яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн тоо буурч, харин хөдөлгөөний, сэтгэц, оюуны болон бусад бэрхшээл 72 хувийг эзэлж байгаа нь цаашид төрөөс зайлшгүй анхаарах шаардлагатай асуудлын нэг болжээ.

ХБХЭТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр судалсан асуудлуудыг тоймлон дүгнэвэл дараах үр дүнд гарч байна. Үүнд:

[Хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдрах орчин нөхцөлийг сайжруулах асуудал](#)

Хуулийн 8, 9, 10, 11 дүгээр зүйлд заасан барилга байгууламж, зам талбай, нийтийн тээврийн хэрэгсэл, мэдээллийн хүртээмжийг ХБХ-ийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн нэмэгдүүлэх зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна. Хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт боловсруулах, шинэчлэн батлахтай ажлыг төрийн байгууллагууд сайн хэрэгжүүлсэн. Гэвч нийтийн орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хүртээмжтэй, саадгүй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, ийм шаардлага хангаагүй барилга байгууламжийг ашиглалтад авахгүй байх зохицуулалтууд бүрэн хэрэгжихгүй байна. Тухайлбал, барилга ашиглалтад авах улсын комисс шаардлага хангаагүй барилга хүлээж авч байгаа нь хүн бүхэнд ил байх боловч хаа хаанаа хариуцлага хүлээдэггүй, хариуцлага хүлээлгэдэггүй байдал хууль тогтоомжийг хэрэгжүүлэх шатанд тавих хяналт хангалтгүй, төлөвлөлт, хэрэгжилт, ашиглалтад хүртээмжтэй байдлыг хэрхэн уялдуулах, хэн хянах, хэн хариуцлага хүлээх асуудал тодорхойгүй, ногдуулах хариуцлага нь хэтэрхий бага зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Түүнчлэн хүртээмжгүй баригдсан барилга байгууламжийг хэрхэн өөрчлөх тухай эрх зүйн зохицуулалт байхгүй, төсөв, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, хүрэлцээгүй байдал, хуваарилагдсан төсвийг чанаргүй, дүр эсгэсэн ажилд зарцуулж байгаа нь энэ байдалд нөлөөлж байна. Энэ нь ялангуяа барилга хүлээж авах улсын комиссын бүрэлдэхүүнд ХБХ-ий эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий ТББ-ын төлөөллийг оролцуулах журмын дагуу төлөөллийн оролцоог хангаж байх авч барилга байгууламж ХБХ-д хүртээмжгүй, саадтай хэвээр байгаагаас харагдана. ХБХ-д хүртээмжтэй орчин бий

болгоход зориулсан хөрөнгө оруулалт, тохижилт нийслэлийн хэмжээнд илүү хийгдэж байгаа бол орон нутагт хангалтгүй байгаа нь ХБХ бусдаас байнга дэмжлэг авч, тэднээс хараат, нийгмийн идэвхгүй нэгэн болоход нөлөөлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангах асуудал

ХБХЭТХ-ийн 14, 15,16 дугаар зүйлийн зарим хэсгийн хэрэгжилтийг үнэлж, ХБХ сурч боловсрох эрхээ бусдын адил бүрэн эдэлж чадахгүй буюу хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр Монгол Улсад 108,000 гаруй ХБХ бүртгэгдсэн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй 4 хүн тутмын 1 нь боловсролгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 21,6 хувь нь бага боловсрол эзэмшиж байгаа ч анги ахих тусам энэ тоо буурч, 6,7 хувь нь дээд боловсрол эзэмшсэн судалгаа гарсан. Энэ нь бүх шатны боловсролын байгууллагын ХБХ сурч боловсроход хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатайг илэрхийлж байна.

ХБХ-ий сурч боловсрох эрхийг хангахтай холбоотой хуулийн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж үзэхэд хууль батлагдсанаас хойших 8 жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалт бага, сургууль завсардалт өндөр, боловсролын хүртээмж хөдөө орон нутагт хоттой харьцуулахад бага, тусгай хэрэгцээт боловсролын сургалтын материал, орчин хомс, дээд боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал хэвээр байгаа нь гол тулгамдсан асуудал болно. ХБХ хаана амьдарч байгаа, ямар бэрхшээлтэй эсэхээс хамааран давхар ялгаварлан гадуурхалтад өртөж байна. Тухайлбал, орон нутагт суралцаж буй ХБ-тэй сурагчдын тоо 2020 оноос хөдөө орон нутагт тогтмол буурч байгаа бол төвийн бүсэд болон Улаанбаатар хотод өссөн, мөн сонсголын бэрхшээлтэй хүний 50-иас дээш хувь, харааны бэрхшээлтэй ХБХ-ий 45 орчим хувь нь боловсрол эзэмшсэн байдаг бол оюуны бэрхшээлтэй иргэдийн 30 орчим хувь нь боловсрол эзэмшсэн байдаг нь тэд ялгаварлан гадуурхалт, ядуурал, гэр бүлийн хүчирхийлэл зэрэгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хэдийгээр төрөөс ХБХ-ий сурч боловсрох эрхийг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд анхаарч, 2020 оноос эхлэн ЗГ-ын “Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай” 235 дугаар тогтоол, БСШУС-ын сайдын тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”, Боловсролын багц хуулиуд зэрэг холбогдох эрх зүйн орчинг шинэчилж байна. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийг боловсрол эзэмшүүлэх, тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн сурах орчин, сургалтын хөтөлбөр, тохирох хэрэглэгдэхүүн, мэдлэг, арга зүйтэй багш боловсон хүчнээр хангах, тэднийг бэлтгэх ажил удаашралтай байна. Түүнчлэн хугацааны хувьд зарим эрх зүйн зохицуулалтын үр дүнг тооцох боломжгүй байдлаас гадна олон нийтийн болон эцэг эх, асран хамгаалагчийн амьжиргааны болон боловсролын түвшин, хандлага өөрчлөлтийг хүлээж авахад бэлэн биш байна.

Хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх журам, аргачлалуудыг боловсруулж, батлах явц удаан, сургалтын байгууллага, ХБХ, тэдний эцэг, эх, асран хамгаалагч, багш мэргэжилтнүүдийн шинэ нөхцөл байдлыг хүлээж авах, түүнд шилжих буюу дасан зохицоход бэлтгэх арга хэмжээ байдаггүйгээс гадна төсөв санхүүгийн асуудал ч нөлөөлж байна. Тухайлбал, ХБ-тэй суралцагчид тохирох орчин бүрдүүлэх, хэрэглэгдэхүүнээр хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургахад шаардлагатай анги, танхимыг тохижуулах ажлыг улс, орон нутгийн болон боловсролын байгууллагын төсөвт тусгаж, хэрэгжүүлэх ажил хангалтгүй учраас гадаадын донор байгууллагууд, дотоодын аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагын хүрээнд голчлон хэрэгжиж байна. Үүнд нийт төсвийн хэдэн хувийг энэ чиглэлд зарцуулах тухай тодорхой заагаагүй, санхүүжилтийн үр нөлөөг тооцдоггүй зэрэг тогтолцооны шинжтэй асуудлууд байгаагаас хүртээмжтэй орчин бүрдүүлэх ажил сургууль, цэцэрлэг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай нүүр тулах хүртэл энэ чиглэлд тодорхой хөрөнгө оруулахгүй байхад нөлөөлж байна. Үүний үр дүн ХБ-тэй суралцагч сургуульд элссэний дараа тохирох орчин, хэрэглэгдэхүүнтэй болох хүртэл хугацаанд сурлагын хоцрогдолд орох, ялангуяа хүнд хэлбэрийн ХБ-тэй хүүхэд боловсролын тогтолцооноос гадуур үлдэх өндөр эрсдэл үүсгэж болзошгүй юм. Иймээс боловсролын салбарт хуваарилах төсвийн ангилалд ХБХ-ий сурч боловсрох эрхийг хангахад чиглэсэн төсвийг бие даасан ангилал болгон тусад нь тусгаж хэрэгжилтийн талаарх мэдээллийг тайлагнадаг байх шаардлагатай байна.

Боловсролын түвшин бүр нь харилцан уялдаатай, нэг нэгнээ дэмжсэн шинж чанартай байх ёстой. Төрөөс үзүүлж буй боловсролын үйлчилгээ, халамжийн бодлогын үр дүнд СӨБ-ын байгууллагад суралцах ХБ-тэй бага насны хүүхдийн тоо нэмэгдэж байгаа бол эсрэгээрээ ЕБС-д суралцаж буй ХБ-тэй суралцагчийн тоо жил бүр, анги дэвших тусам буурч байгаа нь сургалтын байгууллагын хүртээмжгүй байдал, сургалтын хөтөлбөр, багш, мэргэжилтний арга зүй зэрэг олон зүйлээс шалтгаалах боломжтой. Тусгай хэрэгцээт боловсрол олгох, багш бэлтгэхэд нэн шаардлагатай асуудлын нэг бол ХБ хүүхдийн талаарх статистик мэдээлэл бодитой, тодорхой байх явдал. Салбар дундын уялдаагүй байдлаас шалтгаалж нэг ХБХ-нд холбогдох асуудлыг салбар бүр өөрийн онцлогт нийцүүлэн судалж, мэдээллийн сан үүсгэж байгаа нь ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр бодлого тодорхойлоход хүндрэл үүсгэж байна. Иймээс ХБ-тэй хүүхдийн статистик мэдээллийг боловсронгуй болгох, бусад салбарын мэдээлэлтэй уялдуулах шаардлагатай. Ингэснээр ХБХ-нд боловсрол эзэмшүүлэх, ажил хөдөлмөр эрхлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зэрэг үндсэн эрхүүдийг хүртээмжтэй хүргэх, өөрөөр хэлбэл дараа дараагийн шатанд хэрэгжүүлэх бодлого төлөвлөх боломж бүрдэнэ.

Дараагийн асуудал бол хүний нөөцийн буюу тусгай хэрэгцээт боловсролын багшийн дутагдал их байгаа нь сургалтын чанар, суралцагчийн боловсролын түвшинд сөргөөр нөлөөлж сургуульд хамрагдаж байгаа ч зохих түвшний мэдлэг авахгүй байхад нөлөөлж байна. Тухайлбал, 2013 оноос хойш 2025 он хүртэл тусгай хэрэгцээт боловсролын нийт 200 оюутан МУБИС-ийг 3.5 жилийн бакалаврын болон 1 жилийн хөрвөх сургалтаар төгсжээ. Үүнийг СӨБ-ын байгууллагад улсын хэмжээнд тусгай хэрэгцээт боловсролын 7 багш ажилладаг, мөн 29-р сургуулийг төгсөгчдийн ЭЕШ-ийн үнэлгээний дүнгээс харж болно. Иймээс тусгай сургуулиудаас гадна хүүхэд бүрийн хөгжлийн түвшинг тодорхойлж, тэдэнд тохирох дэмжлэг, боловсролын үйлчилгээг үзүүлэх чадвартай багш, мэргэжилтэн бэлтгэж, мэргэшүүлснээр хуулийн хэрэгжилт сайжрах боломжтой.

Хууль тогтоомжийн дагуу сургалтын байгууллагад ХБ-тэй хүүхэд суралцах нөхцөлийг бүрдүүлж байгаа боловч ХБХ гэрээсээ боловсролын сургалтын байгууллагад хүрэх, суралцахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ тодорхойгүй, хэн, хэзээ, хаана, ямар санхүүжилтээр хэрэгжүүлэх нь ойлгомжгүй зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан ХБ-тэй хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөх, сургууль завсардах асуудал байсаар байна.

Дээр дурдсан асуудлууд дээд боловсролын сургалтын байгууллагуудад бүр ч илүү тулгамдаж байна. Ийнхүү ХБХ-ий боловсролын хүртээмж, хамрагдалт хангалтгүй хэвээр байгаа нь тэдний хөдөлмөр эрхлэлт, амьдралын чанар зэрэг дараа дараагийн нийгмийн хамгааллын асуудалд сөргөөр нөлөөлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал

ХБХЭТХ-ийн 17, 18 дугаар зүйлийн холбогдох хэсгийн хэрэгжилтэд үнэлгээ хийж хэрэгжилтийн түвшинг тодорхойлохыг зорьсон.

2023 оны байдлаар улсын хэмжээнд ажиллах хүчний 93,6 хувь нь ямар нэг ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол хөгжлийн бэрхшээлтэй, 15-аас дээш насны 100 мянга гаруй хүний 0,15 хувь нь ямар нэг хөдөлмөр эрхэлдэг гэх судалгааны дүн ХБХ-ийг ажлын байраар хангах, түүний онцлог хэрэгцээнд нийцсэн тохируулгат орчин бүрдүүлэх ажил хангалтгүй байгааг харуулж байна. Үүнд ХБХ-ий боловсрол, мэргэжил эзэмшсэн байдлаас ажлын байрны олдоц муу, ажил олгогч, ажилтнуудын ойлголт, хандлага сөрөг байгаа нь нөлөөлж байна.

Эрх зүйн орчны тухайд Монгол Улс хүний эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах, хөдөлмөрлөх эрхийг дэмжих чиглэлээр цөөнгүй олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орж, дотоодын хууль тогтоомжоо түүнд нийцүүлэн өөрчилж байгаа ба ХБХ-ий талаар төрөөс “халамжаас хөдөлмөрт” бодлого баримталж, зохистой хөдөлмөрийг дэмжих замаар ядуурлыг бууруулах, ХБХ-ий чадамжид тохирсон ажлын байрыг бий болгохыг зорьж байна. Гэвч Монгол Улсын ЗГ, холбогдох төрийн байгууллагуудаас баталсан ХБХ-ий хүний эрх, оролцоо, хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хэмжээний хөтөлбөрүүд зогссон нь нэг талаас эдгээр хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх эх үүсвэр байхгүй, нөгөө талаас хөтөлбөрийн үр дүнг бодитой үнэлэх ажил хийгдээгүйгээс шалтгаалсан байх магадлалтай.

ХБХ ажил олох, ажлын байраа хадгалах, түүнд ахиж дэвших адил боломж олгох, тэгш хандах, тухайн ажил нь өөрийн сонголтод нийцэж, хувь хүний боломж чадварыг харгалзсан

хүртээмжтэй, тохируулгат ажлын байр бий болгох, энэ нөхцөлийг хангасан ажил олгогч, ХБХ-д үзүүлэх хөнгөлөлт, урамшуулал, чөлөөлөлт, дэмжлэгийн хуулийн зохицуулалт цөөнгүй бий. Тухайлбал, Хөдөлмөрийн хуульд өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд ХБХ-ийг ажиллуулахаар хуульчилсан. Гэвч 2023 оны байдлаар төрийн албанд 226,496 хүн ажиллаж байгаагаас 4554 нь ХБХ байна. Хөдөлмөрийн хуульд заасан квотын дагуу төрийн албанд хамгийн багадаа 9,060 ХБХ ажиллахаас 50 хувийн хэрэгжилттэй байгаа нь төр өөрөө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй хувийн хэвшлийн байгууллагуудад буруу үлгэр үзүүлж байгааг харуулж байна. Энэ нь ХБХ-ийг ажлын байраар хангах асуудал хувийн хэвшилд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх гэхээс илүүтэй нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжихэд хүргэж байна.

ХБХ-нд ажлын байр бий болгох, ажлын байраа хадгалахад зарцуулах төсөв, санхүүжилтийн төлөвлөлтийг бодит шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байна. Үүний тулд өмнө санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийг тоо, статистикт бус үр дүнд, өгөөжид суурилсан буюу “мөрдөх” хэлбэрээр үнэлдэг тогтолцоонд шилжих нь чухал. Тухайлбал, ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангаас харахад ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, олгосон мөнгөн дүнгийн хэмжээ анх төлөвлөснөөс бага байдаг бөгөөд нэг ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд төрөөс дунджаар 3 сая төгрөг зарцуулж байгаа нь дэмжлэгийн төрөл, хэмжээ зохистой хэлбэрээр хэрэгжиж байгаа эсэх, ажлын байраар хангах, хадгалах зорилгоо биелүүлэхэд хангалттай эсэх, цаашид энэ чиглэлээр бодлогын өөрчлөлт хийх эсэхийг судлах, дүн шинжилгээ хийх шаардлагатайг харуулж байна.

ХБХ-ий эрхийн асуудал олон салбарын хамтын ажиллагаа шаардсан асуудал болохын хувьд ХБХ-ий асуудал хариуцсан байгууллагуудын үүрэг, оролцоог тодорхой болгох, хувийн хэвшилд төдийгүй төрийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, харилцаанд анхаарах, төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлох, төрийн институт хоорондын хамтын ажиллагааг уялдуулах, холбогдох нөөцийг бүрэн ашиглаж, үр дүнтэй зохицуулах хэрэгцээ, шаардлага байна. Учир нь хүн амын насжилт нэмэгдэж байгаа төдийгүй эрүүл мэнд, ажил мэргэжил, зам тээврийн осол, гэмтлийн улмаас ХБ-тэй болж буй хүний тоо өсч байгаагаас гадна сэтгэц, оюуны бэрхшээлтэй иргэдийн тоо нэмэгдэж байгааг анхаарах нь зүйтэй.

Иймээс цаашид холбогдох хууль тогтоомжийг цаг үеийн шаардлагад нийцүүлэх шинэчилж, нийгмийн халамжийн бодлогын хүрээнд ХБХ-ий хөдөлмөр эрхлэлт, ажил олгогчийг бодлогоор дэмжих, хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх шинэ үйлчилгээг бий болгох, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг оновчтой болгох, ХБХ-ий ажил хөдөлмөр эрхлэх ур чадварыг нэмэгдүүлэх, ажилд зуучлах үйлчилгээг сайжруулах, үүнд тэдний эрх ашгийн төлөөх төрийн бус байгууллагыг татан оролцуулахад анхаарах шаардлагатай байна.

Хэдийгээр ХБХ-нд зориулсан хүртээмжтэй, тохируулгат ажлын байр бий болгосон ч тухайн ажлын байранд ХБХ-ийг дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, ажил олгогч, ажилтнуудын ойлголт, хандлагыг өөрчлөхөд ажлын байрны дадлагажуулагчийн оролцоо үгүйлэгдэж байна. ХБХ-ийг ажлын байранд зуучлах, ажлын байранд нь тогтвортой ажиллуулахын тулд ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу дэмжлэг үзүүлэх ажлын байрны дадлагажуулагчийн үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн нь ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлөх боломжтой байна.

Мөн боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээний нэгэн адил ХБХ ажил хөдөлмөр эрхлэхэд дэмжих үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх замаар “гэр-ажил” хооронд үүсэж буй хүндрэлүүдийг арилгах буюу ХБХ хөдөлмөр эрхлэхэд тулгамдаж буй асуудлыг цогцоор нь харж шийдвэрлэх шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн асуудал

ХБХ-ий онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай туслах хэрэгсэл, бусад үйлчилгээгээр авах эрхийг хангахад чиглэсэн ХБХЭТХ-ийн 20 дугаар зүйлийн зарим заалтын хэрэгжилтийг үнэлж үзэхэд Монгол Улсын Үндсэн хууль болон нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод заасан эдийн засаг, оршин суугаа газар зэргээс үл хамааран эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж,

үйлчилгээг эрх тэгш авах эрхийн хэрэгжилт болон хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үр дүнг сайжруулах зорилгоор жирэмсний хяналт, нярайн тандалт шинжилгээ, хүүхдийн ягаан дэвтрээр дамжуулан хүүхдийн хөгжлийг хэмжих, дархлаажуулалтад хамруулах зэрэг цөөнгүй арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Нийт хүн амд эзлэх ХБХ-ий тоо тогтмол 3,3 орчим хувь байдаг, үүнээс хөдөлгөөний, сэтгэцийн болон бусад бэрхшээлтэй хүмүүс нийт ХБХ-ий 72 хувийг эзэлдэг зэрэг нь хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх ажил зөвхөн эрүүл мэндийн салбарын асуудал биш болохыг харуулж байна. Иймээс төрөөс баримтлах хүн ам зүйн болон агаар, орчны бохирдлыг бууруулах, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх, шаардлагатай төсөв санхүүжилтийг шийдвэрлэж хэрэгжилтийг бодитой байлгахад анхаарах шаардлагатай. Харин нөгөө талдаа иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, амьдралын буруу дадал, хэвшлээс салахад нь дэмжлэг үзүүлэх бодлого үгүйлэгдэж байна. Үүний жишээ манай улсад газар авсан архины хэрэглээ⁹⁹. Судлаачдын үзэж байгаагаар ялангуяа, оюуны бэрхшээлтэй ХБХ-ий тоо цус ойртолт, агаар орчны бохирдлоос шалтгаалан цаашид ч өсөх хандлагатай байгаа. Иймээс хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой тодорхойлж холбогдох арга хэмжээ авах асуудал тулгамдаж байна. Харин хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэхэд иргэдийн ойлголт, мэдлэгийн түвшин, оношилгооны тоног төхөөрөмжийн хүрэлцээ, өртөг өндөр, эмч мэргэжилтнүүдийн хайхрамжгүй алдаа зэрэг хүчин зүйлс сөргөөр нөлөөлдөг.

ХБХ өөрт шаардлагатай эмчилгээ, сувилгаа, дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжийг бүрдүүлэхэд эцэг, эх, эмч, багш, олон нийт гээд хүн бүрийн ХБХ-д хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээг аль болох эрт үзүүлэх талаарх ойлголт, мэдлэг, хандлагыг дээшлүүлж, оролцоог нэмэгдүүлэх нь чухал байна. Гэвч ХБХ-д үзүүлэх ЭМТҮ, хөгжлийн дэмжлэгт холбогдох хуулийг хэрэгжүүлэх явц удаашралтай, эрх зүйн орчин дутмаг, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн боловсон хүчний нөөц хангалтгүй байна. Ялангуяа ХБХ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах орчны саадгүй байдал, хүртээмж хязгаарлагдмал, эрүүл мэндийн нууцаа хадгалах, энэ талаар бие даан шийдвэр гаргахад үзүүлэх дэмжлэг хомс байна.

Түүнчлэн ХБХ-ий эрүүл мэндийн байдлыг дордуулахгүй байх, амь насанд нь эрсдэл учрахаас урьдчилан сэргийлэх эм, эмийн бэлдмэлийн хангамж, хүртээмж, бүртгэл, нөөц бүрдүүлэлт, үнэ, өртгийг хянах, бүртгэх, хянах тогтолцоо хангалттай ажиллахгүй байна. Үүнээс болж хот, хөдөөгийн ялгаа ихээр үүсч байгаа нь эрдэл үүсгэж байна.

Эмч нарын харилцаа, хандлага, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ХБХ-нд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт нөлөөлж байх тул тэдний ажлын ачаалал, ур чадвар, харилцаа хандлагыг дээшлүүлж ХБХ-ий эрхийг хүндэтгэх, ойлгох байдлыг сайжруулах шаардлагатай байна.

ХБХ-ий зарим эрхийн хэрэгжилтийг үнэлсэн байдал

ХБХ нийгмийн эд эс болохын хувьд түүнд Үндсэн хууль, ХБХЭТХ болон бусад хууль тогтоомжоор олгогдсон, тухайлбал хууль зүйн туслалцаа авах, сонгох, сонгогдох эрхээ эдлэх боломжийг олгож буй байдал, мөн биеийн тамир, спортоор хичээллэх боломж бүрдсэн эсэхийг онцлон судаллаа.

ХБХ хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хуулийн зохицуулалт харьцангуй сайн хэрэгжиж шүүх, хууль сахиулах байгууллагууд шүүн таслах, мөрдөн шалгах ажиллагааны явцад хэл ярианы, харааны бэрхшээлтэй хүнд дохионы хэлмэрч, орчуулагч зэрэг дэмжих үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Тухайлбал, УИХ-аас 2022 онд баталсан Хууль зүйн туслалцааны тухай хуулийн хүрээнд ХБХ улсын өмгөөлөгчөөс туслалцаа авах эрхийг тусгасан нь хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлсэн зохицуулалт болжээ.

Гэвч эдгээр зохицуулалт нь сэтгэц, оюуны болон хавсарсан бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй буюу тодорхой зохицуулалтгүй байхаас гадна хуулийн хэрэгжилт хот, хөдөөд

⁹⁹ Монгол Улсад насанд хүрсэн нэг хүнд 28 литр архи оногдож, 51 хувь нь архийг хэтрүүлэн хэрэглэдэг, согтууруулах ундаа хэрэглэсний улмаас жилд 3328 хүн бусдын биед гэмтэл учруулдаг, мөн жилд 83 мянга гаруй хүн эрүүлжүүлэгдэж, 4500 хүн архины шууд болон шууд бус хамаарлаар нас бардаг. 2022 он. ЦЕГ-ын мэдээллээс

ялгаатай хэрэгждэг. Орон нутгийн түвшинд хууль зүйн үйлчилгээний хүртээмж бага, мэдээлэл дутмаг, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх боломж хязгаарлагдмал байгаад ХБХ-ий хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад шаардлагатай материаллаг болон хүний нөөц хангалттай бүрдээгүй, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудал тодорхойгүй байдаг нь давхар нөлөөлж байна. Хуулийн байгууллагууд ХБХ-тэй харилцах нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор албан хаагчдаа сургалтад хамруулах, хөтөч үйлчилгээг нэвтрүүлэх замаар асуудлыг шийдвэрлэхийг зорьж байгаа боловч ажлын ачаалал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн их байдаг тул төдийлөн үр дүн гарахгүй байна. Иймээс хуулийн салбарт ХБХ-д үзүүлэх үйлчилгээнд төрийн бус байгууллагууд, мэргэжлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, түүний санхүүжилтийг тодорхой тусгах шаардлагатай юм.

Түүнчлэн ял эдэлж буй ХБ-тэй хоригдлуудын асуудлыг хорих ангийн дотоод журам, бусад дүрэм журмаар зохицуулаагүйгээс ХБХ хорих ял эдлэх хугацаандаа хөдөлмөр чадвар алдалтын хувь хэмжээг тогтоолгох, сунгуулах процесс хүртээмжгүй, хугацаандаа сунгуулж чадахгүй байх, хорих ангийн барилга байгууламж, үйлчилгээ ХБХ-нд хүртээмжгүй, ял эдлэх хугацаандаа сургалт, хөдөлмөр, нийгмийн ажлын үйлчилгээнд хамрагдаж, ялын хугацааг өөрчлөх боломжоо ашиглаж чадахгүйд хүрдэг зэргээс харахад ял эдэлж буй ХБХ-ий хөгжлийн бэрхшээлийн онцлогт нийцсэн сургалт, нийгмийн ажилд хамруулах тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлага байна.

ХБХ Үндсэн хуулиар олгогдсон улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхээ бүрэн эдэлж чадахгүй байна. 2023 онд Монгол Улсын Үндсэн хууль болон сонгуулийн тухай хууль тогтоомжуудад оруулсан нэмэлт өөрчлөлтөөр анх удаа ХБХ УИХ-ын гишүүнээр сонгогдсон нь эрх зүйн орчинд орсон томоохон өөрчлөлтийн үр дүн. Гэхдээ ХБХ улс төрийн үйл ажиллагаанд бие даан оролцох эрх нь дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжгүй байдал, нийгмийн хандлага, ойлголт сул, хууль, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй, сонгуулийн тогтолцоо зэргээс гадна ХБХ-ийн боловсрол, эдийн засгийн чадавхаас шалтгаалан хязгаарлагдмал хэвээр байна. ХБХ сонгох эрхээ эдлэхэд саналаа нууцаар, бие дааж өгөх нөхцөл бүрдэхгүй байх, өөрийн онцлог хэрэгцээнд нийцсэн хэлбэрээр мэдээлэл авч чадахгүй байх, ойр дотно хүмүүсийн нөлөөнд автах асуудал их байгаа бол сонгогдох эрхээ эдлэхэд хувь хүний боловсрол, санхүүгийн чадавх, хувь хүний хөгжил, нийгмийн харилцаанд бие даан оролцох дадал, өөрийгөө үнэлэх үнэлэмж, улс төрд оролцох идэвх, олонд танигдаагүй байдал зэрэг хөгжлийн бэрхшээлийн үр дагавар, хүчин зүйлс нөлөөлж байна.

ХБХЭТХ-ийн 33 дугаар зүйлд ХБХ-ийг биеийн тамир, спортын тэмцээн, уралдаанд оролцоход нь төрөөс дэмжлэг үзүүлэхээр заасан боловч салбар хоорондын уялдаагүй байдал, санхүүгийн болон бусад дэмжлэгийг хариуцах байгууллага тодорхойгүйгээс хэрэгжээгүй зохицуулалт. Үүнд биеийн тамир, спортын зориулалтаар ашиглаж буй барилга, байгууламж, дэд бүтцийн гадаад, дотоод орчин ХБХ-д хүртээмжгүй, ХБХ-ийг дасгалжуулах багш, мэргэжилтэн хомс, спортоор хичээллэхэд дэмжлэг үзүүлэх ажил зөвхөн түүний ар гэрт хамаардаг зэрэг олон асуудалд байна. Харин 2024 онд баталсан Биеийн тамир, спортын тухай хуульд паралимп, дифлимп, тусгай олимпын наадамд оролцогчдод дэмжлэг үзүүлэхээр тусгасан мөн ХБХ-ий биеийн тамир, спортын үйл ажиллагааг тусгайлсан заалт болгон шинээр нэмсэн нь хуулийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлж, дифлимп, тусгай олимпын наадамд оролцох тамирчид олон нийтийн хандив тусламжаар тэмцээнд оролцдог, хууль тогтоомжид заасан шагнал, урамшууллаа ямарваа нэг бэрхшээлгүйгээр авах боломжийг бүрдүүлэх магадлалтай байна.

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ

Орчны хүртээмжтэй байдал, өөрөөр хэлбэл нийтийн орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хүртээмжтэй, саадгүй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх нь зөвхөн ХБХ-д ээлтэй төдийгүй ахмад настан, хүүхэд, түр хугацаанд хөдөлмөрийн чадвараа алдсан хүн гээд хүн бүрт саадгүй, хүртээмжтэй орчинд амьдрах боломжийг олгоно. Нөгөөтээгүүр ХБХ-нд саадгүй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх нь эдгээр хүмүүс нийгмийн амьдралд бусдын нэгэн адил оролцож, Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эдлэх үндэс, суурь нөхцөл болохыг дурдаад дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

- Нийтийн орон сууц, олон нийтийн барилга байгууламж, дэд бүтэц, нийтийн тээвэр, харилцаа холбоо, мэдээллийн сувгуудыг ХБХ-нд саадгүй, хүртээмжтэй байлгахад чиглэсэн хууль, тогтоомж, стандарт, норм, дүрэм зэрэг эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах,
- Дээр дурдсан шаардлага хангаагүй тохиолдолд ашиглалтад оруулахгүй байх,
- ХБХ-нд саадгүй, хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд зориулагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгайлан тусгадаг байх,
- Улсын болон орон нутгийн санхүүжилтээр гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын чанар, үр дүнг үнэлэх тогтолцоог боловсронгуй болгох,
- Хот байгуулалтын хүрээнд ХБХ-д саадгүй, аюулгүй орчин бүрдүүлэх боломжгүй буюу гадаад /явган хүний зам, пандус, зогсоол гэх зэрэг/ болон дотоод орчинд хангалттай зай талбайгүй нийтийн орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбайн төлөвлөлт, зураг төсөл батлахгүй, зөвшөөрөл олгохгүй байх,
- Барилга байгууламж батлагдсан зураг, төслийн дагуу баригдаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих, илэрсэн зөрчлийг цаг тухайд нь арилгах,
- Холбогдох эрх зүйн баримт бичигт заасан шаардлага хангаагүй зураг төсөл баталсан, барилга байгууламжийг ашиглалтад авсан, дүр эсгэн гүйцэтгэсэн албан тушаалтан, байгууллагад тооцох хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх,

Тогтвортой хөгжлийн зорилгын үндсэн зарчим болох “Хэнийг ч ардаа хоцроохгүй байх” зарчмыг хэрэгжүүлэхэд ХБХ-ий сурч боловсрох эрхийг хангах замаар мэдлэг, мэргэжил олгох нь нийгмийн харилцаанд тэгш оролцох, ажил, хөдөлмөр эрхлэх улмаар бие даан амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй болохыг онцлоод дараах асуудалд анхаарах шаардлагатайг зөвлөж байна. Үүнд:

- ХБХ-ийн статистик мэдээллийг тасралтгүй хөтлөх, салбар дундын бодлого төлөвлөлтөд ашиглах боломжтой мэдээллийн сан үүсгэх байдлаар цуглуулж, ашиглаж хэвших,
- Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх ажлыг бүх шатны боловсролын түвшинд эрчимжүүлэх, багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт онол, практик хосолсон илүү өргөн агуулгаар тусгах замаар ХБХ-нд чанартай боловсрол олгоход анхаарах,
- ХБХ, түүний гэр бүл, асран хамгаалагчдын боловсролд хөрөнгө оруулах замаар тэднийг ажил мэргэжилтэй болгож ядуурлыг бууруулахад нөлөөлөх арга хэмжээ авах,
- Боловсролын сургалтын байгууллагын гадаад, дотоод орчны хүртээмжийг нэмэгдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах төсвийг тусгайлан баталж, төсвийн үр нөлөөтэй зарцуулалтад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах, тайлагнаж хэвших,
- Дээд боловсролын байгууллагуудад шинээр элсэгчдийн тодорхой хувийг ХБ-тэй элсэгч бүрдүүлэх эрх зүйн зохицуулалт бий болгох замаар ХБХ-ий боловсролыг дэмжих, энэ ажилд төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургуулиудыг татан оролцуулах,
- Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжих үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох,

ХБХ-ий бие даан амьдрах, шийдвэр гаргах, эдийн засгийн хараат байдлаас гарах, нийгмийн харилцааны оролцогч байх, өөрийн хүсэл, сонирхлын дагуу сурч, хөгжих боломжийг бүрдүүлэхэд төрөөс үзүүлэх нийгмийн хамгаалал, халамжийн тогтолцооноос гадна ХБХ-ий

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагад үндэслэн дараах зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

- ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, ялангуяа төр өөрөө хуулиа хэрэгжүүлэх,
- хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрт шаардлагатай аливаа үйлчилгээ, тусламж дэмжлэгийг цаг алдалгүй авах нөхцөлийг бүрдүүлэх, эдгээр үйлчилгээг үзүүлж буй байгууллагуудын эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагааг нь дэмжих, бэхжүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох,
- ХБХ-ийг ажлын байраар хангаж буй ажил олгогчийг бодлогоор дэмжих, тухайлбал, хуульд заасан квот хангаагүй хуулийн этгээдээр төлүүлэх төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх, ХБХ-ий чадварыг харгалзсан хүртээмжтэй, тохируулгат ажлын байр бий болгосон, ажлын байраар хангасан ажил олгогч, ХБХ-д үзүүлэх татвар, шимтгэл, төлбөр зэрэг үүргээс хөнгөлөх, чөлөөлөх, олгож буй урамшуулал, дэмжлэгийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх замаар ХБХ ажиллуулах хуулийн этгээдийн тоог нэмэх хөшүүрэг бий болгох,
- ХБХ-нд ажлын байр бий болгох, ажлын байраа хадгалахад зарцуулах төсөв, санхүүжилт тасралтгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, эх үүсвэрийг тодорхой зааж, зарцуулалтад хяналт тавих, үр дүнг үнэлж хэвших,
- ХБХ-ий хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудал хариуцсан төрийн байгууллагуудын чиг үүрэг, оролцоог тодорхой болгох, үйл ажиллагааг уялдуулах, холбогдох нөөцийг бүрэн ашиглаж, үр дүнтэй, хүнд суртал, чирэгдлийг арилгах,
- Оюуны бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажил мэргэжлийн дадал олгох сургалтын төв, бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээний төрөл, санхүүжилтийг тодорхой болгох
- ХБХ-ийг хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх, ажлын байранд зуучлах, дадлагажуулах, ажлын орчин, хамт олны дунд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх ажлын байрны дадлагажуулагчийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, нэвтрүүлэх,
- ХБХ-ий хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор хувийн туслах зэрэг үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, /гэр-ажил/,
- ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх.

Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, нэгэнт бий болсон тохиолдолд түүнийг эрт илрүүлэн эмчлэх нь нэг хүний төдийгүй түүний хүрээлэлд буй хүмүүсийн амьдралын чанарыг бүх талаас нь сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх бол ХБХ-ий хэрэгцээ, боломжид нийцсэн чанартай, хүртээмжтэй ЭМТҮ-д үндэслэн урт хугацааны хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээгээр аль болох эрт хангах нь ХБХ бусдын нэгэн адил эрх тэгш амьдрахад чухал нөлөөтэй болохыг дурдаад дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх бодлого тодорхойлж, салбар дундын уялдааг хангах,
- Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үр дүнг сайжруулах ажлын үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын буруу дадал, хэвшлээс салахад нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах,
- Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчны хүртээмжийг нэмэгдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжийг түүнд шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг төсөвт тусгайлан тусгаж, хэрэгжилтийн үр дүн, тасралтгүй байдлыг үнэлэх,
- ХБХ-д үзүүлэх эмчилгээ, асаргаа, олгох бүтээгдэхүүн, туслах хэрэгсэл, үйлчилгээний цар хүрээ, нэр төрлийг олон улсын жишиг, чиг хандлагад нийцүүлэх нэмэгдүүлэх, биеийн болон бэрхшээлийн хөгжлийн онцлогт нийцүүлэн өөрчлөх, солих, санхүүжилтийг аль байгууллагын төсвөөс гаргах зэрэг асуудлыг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох,
- ХБХ цар тахал, гамшиг осол гээд ямар ч цаг үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад шаардлагатай дэмжих үйлчилгээ, цаг тухайд бүр тасралтгүй авах, урьдчилан захиалах нөхцөлийг бүрдүүлэх,
- ХБХ-ий эрүүл мэндийн нууцыг хамгаалах, өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргах орчин, нөхцөлийг сайжруулах,

- Оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид анхаарах, ялангуяа шүд, ам, нөхөн үржихүйн чиглэлээр,
- ХБХ-ий эрүүл мэндийн байдлыг дордуулахгүй байх, амь насанд нь эрсдэл учрахаас урьдчилан сэргийлэх эм, эмийн бэлдмэлийн тасралтгүй байдлыг хангах зорилгоор түүний хангамж, хүртээмж, түгээлт, нөөц бүрдүүлэлт, үнэ, өртгийг хянах, бүртгэх, хянах тогтолцоог боловсронгуй болгох,
- эрүүл мэндийн салбарт ажиллагсдын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах арга хэмжээг эмч, мэргэжилтэн бэлтгэхээс эхлэн бүх шатанд хэрэгжүүлэх

Бие дааж шийдвэр гаргах, амьдрах дадал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үнэмлэхүй олонход байхгүй, амьдралын наад захын асуудлаар бие даан шийдвэр гаргаж, нийгмийн харилцаанд оролцох хүсэлтэй ч хүртээмжгүй байдлаас шалтгаалан тэд зөвхөн эрүүл мэнд, боловсрол, ажил хөдөлмөр зэрэг амин чухал хэрэгцээг хангах үйлчилгээнээс бусад чөлөөт цагаа зохистой өнгөрүүлэхэд зориулсан хүний эрх, соёлын арга хэмжээ, улс төрийн үйл ажиллагаанд оролцох асуудлаар Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон эрхээ эдэлж чадахгүй байгааг онцлоод дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Хууль зүйн туслалцаа авах эрхийн асуудлаар

- шүүх, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа сэтгэц, оюуны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- ХБХ-д үзүүлэх хууль зүйн үйлчилгээний хүртээмж хөдөө орон нутагт хязгаарлагдмал байгаад анхаарч шаардлагатай хүний нөөц, материаллаг нөөцөөр хангах,
- Хууль зүйн салбарт ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр оруулах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг төсөвт тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнадаг байх.
- Албан хаагчдын ойлголт, мэдлэг, хандлагыг хөгжлийн бэрхшээлийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг үр дүнтэй хэлбэрээр зохион байгуулж хэвших,
- Хуулийн салбарт ХБХ-д үзүүлэх үйлчилгээнд төрийн бус байгууллагууд, мэргэжлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, түүний санхүүжилтийг тодорхой тусгах,
- Хорих ангид ял эдэлж буй ХБ-тэй хоригдол бусдын адил тэгш боломжоор хангагдах нөхцөлийг бүрдүүлэх.

Улс төрийн үйл ажиллагаанд оролцох асуудлаар

- Сонгуулийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах,
- ХБХ сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд саад учруулж буй дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжгүй байдлыг арилгах,
- ХБХ саналаа нууцаар, бие дааж өгөх нөхцөлийг бүрдүүлэх,
- Нэр дэвшигчдийн тодорхой хувьд ХБХ оролцуулах /квот/ зохицуулалт бий болгох.

Биеийн тамир, спортын тэмцээн, уралдаанд оролцох асуудлаар

- Бүх шатны биеийн тамир, спортын байгууллага, сургууль ХБХ-нд шаардлагатай тохируулга, хүртээмжтэй орчин, нөхцөл бүхий заал талбай, тоног төхөөрөмж, спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний тусламж үйлчилгээгээр дэмжлэг үзүүлэх,
- ХБХ биеийн тамир, спортоор хичээллүүлдэг, дасгалжуулдаг байгууллага, холбоодод төрөөс дэмжлэг үзүүлэх,
- ХБ-тэй тамирчин паралимп, тусгай олимп, дифлимп, тив, дэлхийн тэмцээнд холбогдох журмын дагуу шалгаран оролцоход нь тамирчин, түүний хувийн туслах, дасгалжуулагч, сэтгэлзүйч, дохионы хэлмэрч зэрэг зайлшгүй шаардлагатай бүрэлдэхүүний зардлыг улсын төсөвт тусгах,
- Паралимп, дифлимп, тусгай олимп, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй тамирчин, түүний дасгалжуулагчид хууль, тогтоомжид заасан мөнгөн шагнал, урамшуулал олгох, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох.

Хөгжлийн бэрхшээлийг тогтоох асуудлаар

- Хөгжлийн бэрхшээлийг үйлдэл, үйл ажиллагааны ажиллагааны олон улсын ангиллын дагуу тогтоох тогтолцоог нэвтрүүлэх,
- Эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдлаар (ICD) хөдөлмөрийн чадвар алдагдлыг тогтоож байгаа ч насанд хүрэгчийн, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоож буй ангилал (ICD10, 11) хоорондын зөрүүтэй байдлыг арилгах,
- Олон улсад стандартчилагдсан мэдээллийн систем бий болгож хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх үнэн зөв бодит мэдээллийг бодлого боловсруулагчдад хүргэх тогтолцоог бүрдүүлэх,
- Хөгжлийн бэрхшээлийг үйлдэл, үйл ажиллагааны ажиллагааны олон улсын ангиллыг ашиглаж хийсэн үнэлгээнд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүргэх үйлчилгээг оновчтой болгох, үйлчилгээний санхүүжилтийг тасралтгүй байх эрх зүйн орчинг бүрдүүлэх
- Үйлдлийн чадамжид суурилсан боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх замаар ХБХ-ий бие даан амьдрах, эдийн засгийн хараат байдлаас гарах боломжийг бүрдүүлэх.

ХБХ-ий ахуйн хүрээнд бие даан хийж чаддаг үйлдэл нь нийгмийн харилцаанд бие даан хийдэг үйлдлээс харьцангуй олон байна. Бид олон арван жилийн туршид хөгжлийн бэрхшээлийг зөвхөн анагаах ухааны талаас нь тодорхойлдог байсан бөгөөд ХБХ-ий талаар зөв мэдээллийг иргэд хожуу буюу зан харилцаа, хүмүүжил төлөвшин тогтсон үедээ авч байгаа нь нийгэмд ХБХ-ийг хүлээн авах, ойлгох сэтгэл зүй бүрдэхгүй байх нэг шалтгаан болж байна. Үүн дээр нэмээд ХБХ-ий бие даан нийгмийн харилцаанд ороход улирлын шинж байдал, дэд бүтэц, мэдээллийн хүртээмжгүй байдал, гэр бүл, нийгмийн гишүүдийн хандлага сөргөөр нөлөөлдөг болох нь энэхүү үнэлгээний дүнгээс харагдаж байна. Иймээс багаас нь буюу ХБ-тэй хүүхэд, залуучуудын бие даан амьдрах, хөгжих боломжийг ялангуяа одоо зохицуулагдаагүй байгаа оюуны бэрхшээлтэй хүүхдийн тухайд бүх талаар нь нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчныг бүрдүүлэх нь чухал бөгөөд дараах холбон зуучлах, урт хугацааны дэмжих үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчны боловсронгуй болгосноор эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт гээд салбар тус бүрт өөр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд ХБХ-ий эрхийг хангах, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний үр дүн бодитой байх боломжтой гэж үзэж байна. Үүний тулд дараах асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна.

- Хувийн туслах үйлчилгээг оновчтой тодорхойлж, хүртээмжтэй зохион байгуулах замаар “гэр-сургалтын байгууллага”, “гэр-ажлын байр” зэрэг харилцаанд хэн нэгнээс хараат байдлыг арилгах,
- ХБХ бие даан амьдрахад үзүүлэх дэмжлэгийн төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх,
- Сурч хөгжихөд нь туслах, дэмжих үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх,
- Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх хандлагыг бий болгох,
- ХБХ-ий эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, үйлчилгээ үзүүлдэг иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, тодорхой шаардлага хангасан тохиолдолд магадлан итгэмжилж төрийн зарим чиг үүргийг тэднээр гүйцэтгүүлэх,
- Төрөөс хуулийн этгээдэд хөнгөлөлт, урамшуулал, татаас олгоход ХБХ-ийг ажлын байраар хангасан, тэднийг дэмжсэн үйл ажиллагаа явуулсан, хүртээмжтэй орчин бий болгосон байдлыг шалгуур үзүүлэлт болгон үнэлдэг байх,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар тэдний нийгэм, гэр бүл дэх идэвх, оролцоог нэмэгдүүлэх, бие даан амьдрах боломжийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах хэрэгцээ шаардлагад үндэслэн төрийн худалдан авах ажиллагааны явцад нийт ажиллагсдын 30 ба түүнээс дээш хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс бүрдсэн аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан тендерээр худалдан авах ажиллагаанд хамааруулахгүйгээр шууд худалдан авалт хийх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангаж буй ажил олгогчийг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан “Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэл”-ээс тодорхой хугацаанд чөлөөлөх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангаж нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрх ашгийг хамгаалагч байгууллагыг шалгаруулж урамшуулах зэрэг хөнгөлөлт, урамшууллыг бий болгох шаардлага байгааг анхаарч холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах,

- ХБХ-нд үзүүлж буй үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор баяр ёслол, амралтын өдрөөс үл хамаарч хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж буй боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, өдөр тутмын асаргаа (дэмжих төв, бие даан амьдрах үйлчилгээ үзүүлэгч, ажлын байрны дадлагажуулагч зэрэг) үзүүлэх эрх бүхий этгээдийн үйлчилгээний зардлын санхүүжилтийг тодорхой хугацаанд тогтмол олгодог болгох,
- Аливаа үйл ажиллагаа хариуцсан эзэн, санхүүжилтгүйгээр хэрэгждэггүй болохыг анхаарч шаардлагатай төсөв, хөрөнгийг хариуцсан байгууллагын төсөвт тусгайлсан ангилал болгон оруулах, ямар ажил үйлчилгээний зардлыг аль сангаас гаргах асуудлыг тодорхой болгож хэрэгжилтийг бодит үр дүнгийн үзүүлэлтээр тайлагнадаг болох,
- ХБХ-нд үзүүлж буй байгууллагуудын үйлчилгээний үнэ, тарифыг тухайн жилийн инфляцын түвшинтэй уялдуулан үйлчилгээний үнэд өөрчлөлт оруулдаг байх эрх зүйн орчныг боловсронгуй болгох,
- Хуулийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлөх хүчин зүйлийн нэг бол хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоо, хариуцлагын төрөл, хэмжээ хангалтгүй байгааг илэрхийлдэг. Тухайлбал, Зөрчлийн тухай хуульд ХБХЭТХ-ийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тусгаагүйгээс энэ төрлийн хэрэг, маргаан үүсгэсэн тохиолдол байхгүй байна.
- Эрх, хууль ёсны эрх ашиг нь хөндөгдсөн хөгжлийн бэрхшээлтэй хүн, бүлэг бусдаар буюу мэргэжлийн байгууллагаар төлөөлүүлэн нэр төр, эрх ашгаа хамгаалуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.
- ХБХ-ийн хөгжлийн чиг хандлага, үр дүнг тооцсоны үндсэн дээр хэтийн бодлого төлөвлөлт хийгддэг. Тэгвэл үүнд шаардлагатай мэдээллийн зөрүүтэй байдал нь төрийн бодлого хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэхэд хүндрэл үүсгэж байна. Иймээс ХБХ-ий талаар статистик мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаа чанаржуулж тооноос чанарт шилжих шаардлагатай.

___оОо___

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Биеийн тамир, спортын тухай
3. Боловсролын ерөнхий хууль
4. Дээд боловсролын тухай хууль
5. ЗГ-ын “Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 235 дугаар тогтоол
6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
7. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
8. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль
9. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
10. Нийгмийн халамжийн тухай хууль
11. Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам
12. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль
13. Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого батлах тухай
14. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
15. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн актын эмхэтгэл. 2022 он.
16. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал. 2021 оны дугаар а/220, А/475, А/812.
17. Хөдөлмөрийн тухай хууль
18. Хууль зүйн туслалцааны тухай
19. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал. ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт.

Бодлогын баримт бичиг

1. “Алсын хараа-2050” УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт
2. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоол
3. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” УИХ-ын 2024 оны 181 дүгээр тогтоол
4. Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030. НҮБ.

Судалгааны тайлан

1. “Бизнес ба хүний эрх Азийн хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн “Хүний эрхийн магадлан шинжилгээ”-ний үр нөлөө судалгааны тайлан. 2024 он. UNDP
2. UB_Case_Study_Publication_Package_Mongolian_version
3. Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан.
4. Боловсрол, шинжлэх ухаан, оюуны өмч. Салбарын танилцуулга. 2022 он. ҮСХ.
5. Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын Үзэл баримтлал
6. Боловсролын салбарын 2022 оны төсвийн зарлага болон үр дүнгийн тайлан. 2024 он. UNDP, ILO, FAO.
7. Боловсролын яам, сургуулийн өмнөх боловсролын 2024-2025 оны хичээлийн жилийн статистик тайлан. БЕГ
8. Ерөнхий боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн статистик тайлан. БЕГ
9. Монгол Улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь. 2020 он. АХБ
10. Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан. 2019 он. Боловсролын яам.
11. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн үзэл баримтлал
12. Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх хэрэгцээг судалсан нь. Г.Батцэнгэл, дэд профессор, Ч.Байгалмаа, магистр. Боловсрол судлал.

13. Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж. Эрдэм шинжилгээ, онол практикийн XI хурлын эмхэтгэл. 2023
14. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа 2020. ХНХЯ.
15. хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт. ХЭҮК. 2024 он
16. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 2018 он. Д.Сүнжид.
17. Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2017-2022 оны үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт
18. Хөдөлмөрийн зах зээлийн тойм. 2024 оны III улирал. ГБХНХЯ.
19. Хүн ам дахь цус ойртолт, үр дагавар. 2021 он. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх Стратеги судалгааны хүрээлэн.
20. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн судалгаа судалгааны тайлан. 2021 он. ЭМЯ, АШУҮИС, ДЭМБ.
21. Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан. 2018 он. ХЭҮК.

Нийтлэл, илтгэл

1. “Тусгай хэрэгцээт хүүхдийг ебс-д тэгш хамран сургах” журмын хэрэгжилт ба асуудал” хэлэлцүүлэгт оролцогчдын ярилцлага. gogo.mn
2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг сайжруулах нь” тандалт судалгааны үр дүнд суурилсан хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа. gadpwd.gov.mn
3. “Цогц үзлэгт хамруулснаар хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх боломжтой” 2022 он. ГБХНХЯ
4. Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны гишүүдтэй уулзлаа. 2023 он. НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс
5. Тив, дэлхийн тэмцээнд амжилт үзүүлсэн тамирчдад мөнгөн урамшуулал олгоно
6. Тусгай хэрэгцээт хүүхдүүд оршихын тулд биш хөгжихийн тулд амьдардаг. gogo.mn
7. Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах багш нарыг мэргэшүүлэх шаардлагатай. 2020 он. Б.Гэрэлтуяа
8. Хөгжлийн бэрхшээл судлалын үр дүнгийн асуудалд илтгэлээс. Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж. Эрдэм шинжилгээ, онол практикийн XI хурлын эмхэтгэл. 2023 он
9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд салбар дундын уялдааг сайжруулах шаардлагатай. У.Сосорбурам
10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлого, шийдвэр, үйл ажиллагааг бүх талаар дэмжинэ 2024 он. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар
11. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоо” үндэсний чуулган. ГБХНХСайд Л.Энх-Амгалангийн илтгэлээс. 2024.11.29. Төрийн ордон
12. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоо” үндэсний чуулган. УИХ-ын гишүүн О.Саранчулууны илтгэлээс. 2024.11.29. Төрийн ордон
13. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар Х.Булгантуяа сайдын мэдээлэл
14. Хөдөлмөрлөх чин хүсэлтэй ч ажлын талбараас гадуурхагдсаар буй Хөгжлийн бэрхшээлтэй иргэд - Eguur.MN
15. Хууль сахиулах байгууллагаас хэл, ярианы бэрхшээлтэй иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлэхэд анхаарах асуудал. Н.Бадамцэцэг. 2022 он
16. Хүн бүр саадгүй амьдрах орчин бүрдүүлье. Өнөөдөр сонин. 2022 он. О.Бат-Ундрах.